

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА ЕРӨӨ СУМЫН ЗАСАГ ДАРГАТАЙ
ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ 2023 ОНЫ ХЭРЭГЖИЛТ**

2023.12.20

ТАВИН

Сэлэнгэ аймгийн Засаг дарга, Ерөө сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээний 17 бүлэг 231 заалт нь 2023 оны жилийн эцсийн байдлаар 87 хувийн хэрэгжилттэй байна.

Зорилтын нэр	Заалтын тоо	2023 оны хэрэгжилтийн хувь
1. Төрийн захиргаа, хяналт шинжилгээ үнэлгээний арга хэмжээ	23	87%
2. Хууль эрхзүйн салбарын ажил арга хэмжээ	12	90%
3. Хөдөө аж ахуйн салбарын ажил арга хэмжээ	18	95%
4. Байгаль орчин, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын ажил арга хэмжээ	20	86%
5. Аялал жуулчлалын салбарын ажил арга хэмжээ	9	47%
6. Худалдаа үйлчилгээ, жижиг дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуйг дэмжих ажил арга хэмжээ	16	90%
7. Хөрөнгө оруулалтын салбарын ажил арга хэмжээ	8	83%
8. Хот төлөвлөлт, дэд бүтцийн салбарын ажил арга хэмжээ	13	80%
9. Боловсролын салбарын ажил арга хэмжээ	11	99%
10. Биеийн тамир спортын салбарын ажил арга хэмжээ	8	81%
11. Эрүүл мэндийн салбарын ажил арга хэмжээ	20	88%
12. Соёл урлагийн салбарын ажил арга хэмжээ	13	91%
13. Хүн амзүйн салбарын ажил, арга хэмжээ	8	96%
14. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж, нийгмийн даатгалын салбарын ажил арга хэмжээ	17	100%
15. Эдийн засаг, төсөв санхүүгийн ажил, арга хэмжээ	11	94%
16. Статистикийн салбарын ажил, арга хэмжээ	7	100%
17. Үндэсний аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах салбарын ажил, арга хэмжээ	19	87%
Нийт:	231	87%

№	Ажил арга хэмжээ	Биелэлт	Биелэлтийн хувь
ТӨРИЙН ЗАХИРГАА, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ:			
1.1 Төр, засгийн бодлого шийдвэрийг орон нутагт хэрэгжүүлэх хүрээнд:			
1	1.1.1 Монгол Улсын хууль, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж тайлагнах /Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, УИХ, Засгийн газрын тогтоол, албан даалгавар, аймгийн ИТХ-ын тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, албан даалгавар/	Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол зэрэг салбар салбарын мөрдөгдөж буй 13 баримт бичгийн хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 90 хувьтай байна.	90%
2	1.1.2 Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, дээд шатны байгууллагаас өгсөн цаг үеийн үүрэг даалгаврыг шуурхай хэрэгжүүлж, тайлан мэдээ, хариутай бичгийг хугацаанд нь тайлагнаж ажиллах	Дээд шатны байгууллагаас жилийн эцсийн байдлаар 1194 албан бичиг ирсэн. Үүнээс хариутай 122 байна. Хугацаандаа явуулсан хариутай бичиг 113, хоцорсон 20 шийдвэрлэсэн албан бичиг, шийдвэрлэх хугацаа болоогүй 1 бичиг байна. Хугацаатай бичгийн шийдвэрлэлт 93 хувийн биелэлттэй байна.	90%
3	1.1.3 Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, багийн иргэдийн Нийтийн Хурлын ажиллах нөхцөлийг хангаж ажиллах	Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 9, Тавин багийн Иргэдийн Нийтийн хурал 3, Буурагчин багийн Иргэдийн нийтийн хурал 2 тус тус хуралдсан бөгөөд тухай бүрт нь хурлын заал, техник тоног төхөөрөмж, мэдээ мэдээллээр ханган ажилласан.	100%
4	1.1.4 Аймгийн “Иргэдийн оролцоотой цахим хөгжлийн жил”-ийн төлөвлөгөөнөөс суманд хамааралтай зорилт, арга хэмжээг хяналтад авч хэрэгжүүлэн, үр дүнг тооцож тайлагнах	Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн “Иргэдийн оролцоотой цахим хөгжлийн жил” болгох тухай А/01 тоот захирамжийн хавсралтаар батлагдсан төлөвлөгөөний Ерөө суманд хамааралтай 11 бүлэг 45 заалтын хэрэгжилт 90 хувьтай байна.	90%
1.2 Төрийн үйлчилгээний ил тод, шуурхай байдлыг хангаж, сахилга хариуцлагыг дээшлүүлэх хүрээнд:			
5	1.2.1 “Ёс зүйн зөрчилгүй аймаг” хөдөлгөөнийг сум, орон нутгийн хэмжээнд өрнүүлж, бүх шатны төрийн байгууллагуудыг хамруулах	2023 оны байдлаар Ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй байна.	100%
6	1.2.2 “Таныг сонсьё” арга хэмжээг төр, төсвийн бүх шатны байгууллагуудад зохион байгуулж, иргэдээс гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацааг 12 хоног байхаар тооцож ажиллах	Нийтийн сонсголын цаг “Таныг сонсьё” арга хэмжээг малчид, тариаланчид, ногоочид, худалдаа үйлчилгээнийхэн, багийн хэсгийн дарга нар, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, бичил уурхай эрхлэгч, багийн иргэд гэсэн бүлгээр 9 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 771 иргэнд орон нутагт хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажил арга хэмжээ, мөн төрийн үйлчилгээний талаарх мэдээллийг танилцуулж, санал хүсэлтийг сонсож ажиллалаа.	100%
7	1.2.3 Монгол Улсын төрийн дээд одон медаль, салбарын болон аймаг, орон нутгийн шагналд иргэд, төрийн албан хаагчдыг холбогдох журмын дагуу тодорхойлох /Ардын Их Хурлын 1990 оны 148, МУ-ын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоол, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 134 дүгээр тогтоол/	Монгол Улсын Төрийн дээд шагнал Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон 1, Алтан гадас одон 2, Хөдөлмөрийн хүндэт медаль 1, Салбарын тэргүүн 2, Яамны жуух бичиг 1, аймгийн Засаг даргын жуух бичгээр 5 иргэн, ажилтан албан хаагчийг шагнуулахаар тус тус уламжлаад байна.	100%
8	1.2.4 Цахим хурлын төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж, цахим хурал, сургалт зөвлөгөөнд тогтмол оролцох	Төрийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй, шуурхай хүргэж, цаг алдалгүй мэдээллээр хангах ажлын хүрээнд Ерөө сумын веб сайт /eruu.se.gov.mn/, Бугант тосгоны вэб сайт /bugant.se.gov.mn/, Ерөө сумын ЗДТГ-ын мэдээ цахим хуудас зэрэг мэдээллийн сувгуудыг идэвхжүүлэн, нутгийн захиргааны байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг,	100%

		<p>байршил, албан хаагчдын харилцах утасны дугаар, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаягийг сумын вэб сайт, мэдээллийн самбар, албаны хэвлэмэл хуудаст байршуулж тайлант хугацаанд “Таныг сонсьё” (9 уулзалт, 68 өрх, 771 иргэн), Нээлттэй хаалга” (103 иргэн)-ны арга хэмжээгээр төрөөс баримталж буй бодлого шийдвэр, ажил үйлчилгээтэй холбоотой 1080 гаруй мэдээ, мэдээлэл нийтэлсэн.</p> <p>Төрийн ажил үйлчилгээний чанар хүртээмж, үр дүнгийн талаар хэрэглэгчийн санал асуулгыг салбар бүрд цахимаар 4, санал асуулгын хуудсаар 1 удаа явуулж нийт 772 өрх, иргэнээс санал авч дүн шинжилгээ хийн ажил үйлчилгээндээ тусган хэрэгжүүлэн ажилласан. Иргэдээс ирсэн санал хүсэлтийн дийлэнх нь хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, сумын өнгө үзэмж, ажлын байрны санал санаачилга байна. Сумын төр, төсвийн байгууллагуудын ажил үйлчилгээ хангалттай хэмжээнд үнэлэгдсэн.</p> <p>Тоон гарын үсгийн тухай хууль, түүнийг хэрхэн авах, ашиглах, ач холбогдол талаар цахимаар болон хурал, зөвлөгөөнөөр хүргэж ажилласнаар Цэцэрлэг, Эмнэлэг, ЗДТГ азар, Соёлын төв, ХААН, Төрийн банкнууд, 12 жилийн сургуулийн сурагчид бүрэн хамрагдаж 552 иргэн тоон гарын үсгээ авснаас 345 нь иргэний үнэмлэхээр, 207 иргэн мобайл апп.аар авсан ба сумын нийт 16-аас дээш настай иргэдийн 68,9 хувь буюу 1352 иргэн тоон гарын үсгээ авснаар цахим орчинд иргэд өөрсдийн мэдээллийг хамгаалах, өөрийгөө таниулах, төрийн үйлчилгээг авах боломж бүрдэж байна.</p> <p>Мөн иргэний гадаад паспортын үйлчилгээг сумдад нэвтрүүлэх зорилтын хүрээнд 957000 төгрөгийн өртөг бүхий гэрэлтүүлгийн төхөөрөмжийг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлүүлснээр иргэд гадаад паспортыг сумандаа захиалан авах боломж бүрдэж байна..</p>	
9	1.2.5 Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон дагалдан гарсан дүрэм журмын хэрэгжилтийг хангах зорилгоор сум, тосгодын албан ёсны цахим хуудсыг шинээр үүсгэж, байнгын тасралтгүй ажиллагааг ханган, мэдээ мэдээллийг тогтмол шинэчлэх	Иргэдэд шилэн данс, tender.gov.mn сайт, ЗДТГ-ын мэдээ пэйс бүүк хаягаар мэдээ, мэдээллийн чанартай пост 1080 ширхэг, сэтгэгдэл 1595, хариу үйлдэл 4518 ширхэг байна. Eguu.se.gov.mn вэб сайтын шинэчлэлийг Богд вүүд солюшн ХХК-тай гэрээ байгуулан 100 хувь гүйцэтгүүлсэн.	100%
10	1.2.6 Цахим шилжилтийн хүрээнд И-Монгол системээр иргэдэд төрийн үйлчилгээг операторын горимоор 1 болон 2 шатлалт үйлчилгээг үзүүлэх арга хэмжээг авч, сум орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжид сургалт, сурталчилгаа зохион байгуулах	<p>Төрийн үйлчилгээний оператораас Төрийн үйлчилгээний e-mongolia буюу Хур системээр дамжуулан иргэдэд лавлагаа мэдээллийг тогтмол олгон ажиллаж байна.</p> <p>Тайлант хугацаанд :</p> <ul style="list-style-type: none"> • Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа – 105 • Оршин суугаа хаягийн лавлагаа – 30 • Иргэний үнэмлэхийн лавлагаа - 53 • Зээлийн лавлагаа – 3 • Жолоочийн лавлагаа – 5 • Үл хөдлөх хөрөнгөтэй эсэх лавлагаа- 5 • Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоосон акт-1 • Төрсний бүртгэлийн лавлагаа-1 • Үл хөдлөх хөрөнгийн лавлагаа-1 • Хүүхдийн төрсний лавлагаа-4 • Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн лавлагаа-3 • Шүүхийн шийдвэрээр бусдад өр төлбөргүй эсэх тодорхойлолт-2 • Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тодорхойлолт- 1 	100%

		<ul style="list-style-type: none"> Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэлгүй тухай тодорхойлолт-1 нийтдээ 215 төрлийн лавлагаа мэдээллийг тус тус олгоод байна 	
11	1.2.7 Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем /ERP/-fi төр, төсвийн байгууллагуудыг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх	<p>“ERP.E-MONGOLIA.MN” буюу төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системд бүртгүүлсэн сургалтад хамрагдаж, Төр төсвийн байгууллагын Архив, бичиг хэргийн ажилтнууд болон удирдлагуудад Сэлэнгэ аймгийн дотоод сүлжээ хариуцсан мэргэжилтэн Ч.Гандүүрэн цахимаар сургалт зохион байгуулсан.</p> <p>Одоогоор аймгийн хэмжээнд egr.e-mongolia.mn систем хэрэгжиж эхлээгүй байна.</p>	30%
1.3. Хүний нөөцийн хөгжлийг хангах ажлын хүрээнд:			
12	1.3.1 Сумын Засаг даргын Тамгын газарт чиг үүргийн шинжилгээ хийж, бүтэц орон тоог шинэчлэн баталж, албан тушаалын тодорхойлолтыг эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авч мөрдүүлэх	<p>Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн А/55 тоот тушаалаар ЗДТГ-н бүтэц орон тоог 18, гэрээт ажилтан 6, Тосгоны бүтэц орон тоог 8, гэрээт ажилтан 4-р тус тус баталсан.</p> <p>Мөн ЗДТГ-н даргын 2023 оны “Албан тушаалын тодорхойлолт батлах тухай” Б/22 тоот тушаалаар төрийн захиргааны 7 албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг баталгаажуулан мөрдлөг болгон ажиллаж байна.</p>	100%
13	1.3.2 Төрийн албан хаагчдыг чадавжуулах “Менторшип” хөтөлбөрт албан хаагчдыг хамруулж мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх	<p>Засаг даргын Тамгын газрын дарга С.Цэвэлмаа нь “Менторшип” хөтөлбөрийн анхан шатны сургалтад 2023 оны 04 дүгээр сард хамрагдсан. Мөн хөтөлбөрийн хүрээнд шинээр хамрагдах сургагч багш болон суралцагчийн судалгааг хүргүүлээд байна.</p>	30%
14	1.3.3. Нээлттэй ажлын байр арга хэмжээг сум, орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, сул орон тоог нөхөх арга хэмжээг авах	<p>“БТЕГ ХХК-н 2023 оны 3 сарын 4-нд Ерөө суманд, 5 сарын 17-нд Сэлэнгэ аймгийн төвд нээлттэй ажлын байрны өдөрлөгийг тус тус зохион байгуулж давхардсан тоогоор сумын хэмжээний 350 иргэн ажил горилогчийн анкет бөглөсөн бөгөөд үүнээс 32 иргэн байнгын ажлын байртай болсон байна.</p> <p>Мөн ЗДТГ-н мэдээ пэйж хуудас болон цахим сайтад шинэ ажлын байрны зарыг тухай бүрт иргэдэд нээлттэй зарлан хэрэгжүүлэн ажиллаж байна.</p>	90%
15	1.3.4 Төрийн албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	<p>Эрүүл мэндийн газраас зохион байгуулсан “Халуун сэтгэл 2023” аяны хүрээнд суманд нийт 258 иргэн урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд хамрагдсан бөгөөд үүнээс 18 төрийн албан хаагч хамрагдсан байна.</p>	50%
16	1.3.5 Төрийн албан хэрэг хөтлөлтийг кирилл болон үндэсний бичгээр хослуулан явуулах ажлыг эхлүүлж, төрийн бүх шатны байгууллагуудад сургалт зохион байгуулах	<p>Хэл бодлогын үндэсний үндэсний зөвлөл, Архивын ерөнхий газраас аймгуудын Засаг дарга нарт “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ийг хэрэгжүүлж, тайлан мэдээ ирүүлэх, төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх ажлыг эхлүүлэх талаар үүрэг чиглэл өгч “Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага MNS 6395:2022” стандарт болон Монгол бичгийн программ дээр ажиллах дадлага олгох анхан шатны сургалтад төр, төсвийн 5 албан хэрэг хөтлөлтийн ажилтнууд хамрагдсан.</p>	50%
17	1.3.6 Төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх, төрийн үйлчилгээний удирдах албан тушаалын сул орон тоо гарсан тухай бүрд захиалгыг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлж нөхөх арга хэмжээг авах	<p>Засаг даргын Тамгын газар болон Захирагчийн албанд бий болсон 4 сул орон тооны захиалгыг ТА3-ийн Салбар зөвлөлд хүргүүлж, төрийн албаны тусгай шалгалтад 4 иргэн тэнцэж ТА3-ийн салбар зөвлөлийн “Нэр дэвшүүлэх тухай” тогтоолын дагуу холбогдох албан тушаалд томилогдон ажиллаж байна.</p>	100%
1.4 Хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг тооцох ажлын хүрээнд:			

18	1.4.1 Бодлогын баримт бичгүүдийн суманд хамааралтай заалтын хэрэгжилтийг хангаж, үр дүнг иргэд олон нийтэд мэдээлж, тайлан мэдээг хугацаанд нь холбогдох газарт хүргүүлэх /Монгол Улсын Засгийн газрын 2020-2024, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө/	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Ерөө суманд хамааралтай 13 бүлэг 32 заалт нь 2023 оны хагас жилийн байдлаар 98 хувийн хэрэгжилттэй байна. Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Ерөө суманд хамааралтай 3 бүлэг 15 хэсэг 84 заалт нь 2023 оны жилийн эцсийн байдлаар 91 хувийн хэрэгжилттэй байна.	90%
19	1.4.2 Төрийн байгууллагуудын иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанар хүртээмж, цаашид орон нутагт хэрэгжүүлэх ажил арга хэмжээний талаар улирал бүр хэрэглэгчийн үнэлгээ авах ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцох	Төрийн ажил үйлчилгээний чанар хүртээмж, үр дүнгийн талаар хэрэглэгчийн санал асуулгыг салбар бүрд цахимаар 4, санал асуулгын хуудсаар 1 удаа явуулж нийт 772 өрх, иргэнээс санал авч дүн шинжилгээ хийн ажил үйлчилгээндээ тусган хэрэгжүүлэн ажилласан. Иргэдээс ирсэн санал хүсэлтийн дийлэнх нь хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, сумын өнгө үзэмж, ажлын байрны санал санаачилга байна. Сумын төр, төсвийн байгууллагуудын ажил үйлчилгээ хангалттай хэмжээнд үнэлэгдсэн	100%
20	1.4.3 Сум орон нутагт зохион байгуулсан ажил арга хэмжээний мэдээг тухай бүр олон нийтэд мэдээлж, аймгийн Засаг даргын хэвлэлийн алба, хэвлэл мэдээллийн байгууллагуудад дамжуулан түгээх ажлыг тогтмолжуулах	Иргэдэд шилэн данс, tender.gov.mn сайт, ЗДТГ-ын мэдээ пэйс бүүк хаягаар мэдээ, мэдээллийн чанартай пост 1080 ширхэг, сэтгэгдэл 1595, хариу үйлдэл 4518 ширхэг байна. Eguu.se.gov.mn вэб сайтын шинэчлэлийг Богд вүүд солюшн ХХК-тай гэрээ байгуулан 100 хувь гүйцэтгүүлсэн.	100%
21	1.4.4 Олон нийтийн сүлжээнд байршуулсан төрийн болон нийтийг хамарсан ажил арга хэмжээнүүдийн мэдээ мэдээллийг тухай бүрд төрийн захиргааны дээд шатны байгууллагад мэдээлэх	Иргэдэд шилэн данс, tender.gov.mn сайт, ЗДТГ-ын мэдээ пэйс бүүк хаягаар мэдээ, мэдээллийн чанартай пост 1080 ширхэг, сэтгэгдэл 1595, хариу үйлдэл 4518 ширхэг байна. Eguu.se.gov.mn вэб сайтын шинэчлэлийг Богд вүүд солюшн ХХК-тай гэрээ байгуулан 100 хувь гүйцэтгүүлсэн.	100%
1.5 Бусад ажил арга хэмжээ			
22	1.5.1 Гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулахад чиглэгдсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Ерөө сумын Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж, Ерөө сумын Засаг даргын 2023 оны А/104 дугаартай захирамжаар Гамшгийн эрсдэлийн тойм судалгаа хийх ажлын хэсэг байгуулж Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газрын мэргэжилтэн, дэслэгч Б.Анхныбаярын заавар, чиглэлээр Ерөө сумын гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийсэн. Сумын Засаг даргын 2023 оны А/105, А/106, А/156 дугаартай захирамжаар Сумын онцгой комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж, Гамшгаас хамгаалах сайн дурын ажилтныг бүртгэх, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллах ажлын хэсэг, сайн дурын ажилтны ажлын чиг үүрэг, гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийг тус тус байгуулж, сайн дурын хэсгийн гишүүдэд чиг үүргийг танилцуулан баталгаажуулсан. Зарлан мэдээллийн дохио дамжуулах СИРЕНЬ дохиоллын төхөөрөмжийг сумын ЗДТГ-ын өмнөх талбайд байрлуулж бэлэн байдлыг хангалаа. Зарлан мэдээллийн дохиогоор аюулгүй байдлаа ханган гэр, ажлын байраа орхин гарах, аюулгүй цэгт цугларах арга ажиллагааны дадлагыг 1 удаа хийллээ. Сумын онцгой комисс, ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд тодотгол хийж томилгоожуулан, техник хэрэгсэл, багажийн жагсаалтыг гаргалаа. Гамшгийн дайчилгаа зарласан үед татан нийлүүлэх бараа, бүтээгдэхүүнээр хангах гэрээг Хүнсний 3 дэлгүүр, Шатахуун түгээх 1 станц, 1 эмийн сантай байгуулж баталгаажуулсан. Гамшгийн үед дайчлах хүн, хүч, техник хэрэгсэл, шатахуун, хоол хүнс, орон байр, зэрэг 17 төрлийн судалгааг тодотгон гаргасан. Гамшгаас хамгаалах команд штабын сургалтын бэлтгэл ажлыг ханган 2023 оны 6 сарын 7,8-ны өдрүүдэд сургалтад хамрагдаж, “Газар хөдлөлтийн гамшгийн үеийн хариу арга хэмжээ” команд штабын сургуулиар өгөгдсөн	100%

		<p>цагийн байдалд нөхцөл байдлын үнэлгээ хийж өгөгдсөн цагуудад авах хариу арга хэмжээг авч мэдээллийг аймгийн онцгой комисст тухай бүр хүргүүлэн ажилласан. 2023 оны 6-р сарын 08-ны өдрийн 16:00 цагт гамшгийн зарлан мэдээллийн дуут дохиог 1 минутын хугацаатай 3 удаа дуугарган, түр цуглах талбайд нүүлгэн шилжүүлэх дадлага сургуулийг зохион байгууллаа. Тус ажиллагааны хүрээнд сумын төвд түр цуглах 11 цэг, Бугант тосгоны цугларах талбайд гамшгаас хамгаалах дуут дохиогоор түр цугларах цэгт нүүн шилжих дадлага ажил хийгдэж гүйцэтгэлийн хувь 38.5 хувьтай байлаа. Цугласан иргэдэд гамшгаас хамгаалах бэлтгэл бэлэн байдлын талаар мэдээлэл өгч тус ажилласан.</p> <p>1. Аймгийн Засаг даргын 2023 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн "Хяналт шалгалт зохион байгуулах тухай" А/154 дүгээр захирамжийн дагуу Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга, хошууч Г.Батсүхээр ахлуулсан ажлын хэсэг 4 дугаар сарын 10, 11-ны өдрүүдэд Ерөө суманд ажиллалаа.</p> <p>Ажлын хэсэг болзошгүй гамшгийн аюул, хүн ам, хүрээлэн байгаа орчныг хамгаалах, урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд аж ахуй нэгж, байгууллага, иргэдийг сургах, харилцан ажиллагааг сайжруулах, 2023 оны 6 дугаар сард зохион байгуулагдах стратегийн команд штабын сургуулийн бэлтгэл ажлыг хангах зорилгоор бэлэн байдлын үзлэг, хяналт шалгалт, гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийж сургалт зохион байгууллаа.</p> <p>Ерөө сумын Засаг даргын Тамгын газраас Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газарт уламжилсан хүсэлтийн дагуу "ГЭР ХОРООЛЛЫН АЙЛ ӨРХҮҮДИЙН ГАЛ ТҮЙМРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ" 2023 оны 04 дүгээр сарын 10 өдөр зохион байгуулагдлаа. Тус ажлын хүрээнд Онцгой байдлын газрын 21 албан хаагч, Ерөө сумын Засаг даргын Тамгын газрын 9 албан хаагч, "ДСЦШС"ХХК-ны 3 албан хаагч, 1,2-р багийн хэсгийн дарга нартай хамтран Ерөө сумын 473 айл өрхөд галын аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг хийж, пийшин, зуух, яндангийн аюулгүй байдал, стандарт, норм, нормативыг мөрдүүлэх, галын аюулгүй ажиллагааны зааварчилгааг таниулан сурталчлах ажлыг зохион байгууллаа.</p> <p>Онцгой комиссын гишүүд болон ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг "Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах тухай" сургалтад хамрууллаа.</p>	
23	1.5.2 Үйлдвэрлэл, үйлчилгээний стандартын шаардлага ханган ажиллаж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллах	<p>Тамхи худалдаалах тусгай зөвшөөрөл олгох тухай 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/185 дугаартай захирамжаар үйлдвэр үйлчилгээний стандарт шаардлага ханган ажиллаж байгаа Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй худалдаа үйлчилгээний газрын хүсэлтийн дагуу шаардлага хангасан 5 хүнсний дэлгүүрт Тамхи худалдаалах тусгай зөвшөөрөл олголоо. Тусгай зөвшөөрөл авсан 5 аж ахуй нэгж иргэд санамж бичиг өгч ажиллаа.</p> <p>3 удаагийн хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж 5 дэлгүүрт Цагдаагийн байгууллага, аймгийн Эрүүл мэндийн газрын эрүүл ахуйн байцаагчтай хамтран хяналт шалгалт хийж зөрчлийг арилгуулж заавар зөвлөгөө өгч ажилласан.</p>	100%
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН САЛБАРЫН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ:			
24	2.1 Авлигатай тэмцэх үндэсний /УИХ-ын 2016 оны 51 дугаар тогтоол/ хөтөлбөрийг хэрэгжүүлж, авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх,	<p>"Авлигын эсрэг нэгдье" соён гэгээрүүлэх аяны хүрээнд "АВЛИГЫН ЭСРЭГ НЭГДЬЕ" анонс хэвлүүлэн байршуулсан. Мөн байгууллагын цахим хуудсанд авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр 17 төрлийн мэдээ мэдээллийг иргэдэд тогтмол хүргэн ажиллаж байна.</p>	90%

	соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээ, аяныг зохион байгуулах	“Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдээллийн ил тод байдлын тухай” сургалтыг Засаг даргын Тамгын газрын албан хаагчид болон төр, төсвийн байгууллагын дарга эрхлэгч нийт 43 ажилтан албан хаагчдад хүргэсэн. Монгол Улсын Авлигын эсрэг хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр алба хаагчдаас ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх тухай баталгаа авч, ажлын чиглэлийг өгч ажилласан. Мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-л зааснаар эрх бүхий 23 алба хаагчийн хөрөнгө оруулгын мэдүүлгийг хуулийн хугацаанд хүргүүлсэн. Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд алба хаагчдын мэдлэгийг шалгах шалгалтыг цахимаар авсан.	
25	2.2 Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах, хүний эрхийн талаарх хууль тогтоомж, батлагдсан хөтөлбөрийг иргэд, байгууллагад сурталчлах ажлыг зохион байгуулах	Хүний эрхийн үндэсний комиссын дарга референт Д.Гантулга ХЭУКомисс болон Хүний эрхийн тухай ойлголт, Хүүхдийн эрх, Хүний эрх хамгаалагчийн тогтолцоо сэдвээр сургалт зохион байгуулж 32 албан хаагч хамрагдсан. Мөн хүний эрхийн талаарх цахим фостер, подкаст, шторкийг ЗДТГ-н мэдээ пайж хуудсаар дамжуулан тогтмол хүргэж байна.	70%
26	2.3 Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх /МУЗГ-ын 2018 оны 50-р тогтоол/ үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, “Цахим эрх зүйн хөтөч” / www.e-khutuch.mn/-MH хэрэглээг нэмэгдүүлэн, хууль тогтоомжийн сургалт, хэлэлцүүлэг, сурталчилгааны олон талт ажлыг зохион байгуулах	“Цахим эрх зүйн хөтөч” / www.e-khutuch.mn/-MH дамжуулан Ерөө ЗДТГ-н мэдээ фасебүүк хуудсанд “Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга”, “Иргэний хэргийн шүүхэд гомдол гаргах”, “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай”, “Ээлжийн амралт, жирэмсэн болон амаржсаны тэтгэмж”, “Тэжээн тэтгэхтэй холбоотой харилцаа”, “Нэлттэй ажлын байрны зар”, “Дээрэмдэх гэмт хэрэг”, “Худалдах худалдан авах гэрээ”, “Хөлдөлт осголтоос сэргийлэх”, “Төрийн албаны ерөнхий шалгалт”, “Гэр бүлийн тухай хууль”, “Цэргийн дүйцүүлэх алба”, “Жолоочийн даатгалын тухай”, “Гэр бүлээс гадуурх харилцаа” “Хүний эмзэг мэдээлэл”, “Алдуул мал гээгдэл эд хөрөнгө” зэрэг салбар бүрийн 52 төрлийн мэдээллийг иргэдэд сурталчилж ажилласан. Албан өрөөгөөр үйлчлүүлсэн 12 иргэн, утсаар хандаж мэдээлэл авсан 13 иргэнд тус тус “Тэтгэвэр тогтоолгох, тэжээн тэтгэх, улсын бүртгэл, үрчлэлт, нотариатын үйлчилгээний талаарх мэдээллийг тухай бүрд өгч ажилласан.	100%
27	2.4 Захиргааны шийдвэрийн хувийн хэргийг бүрдүүлж, зайлшгүй гаргах шаардлагатай захиргааны хэм хэмжээний актуудыг гарган мөрдүүлж, захиргааны шийдвэр гаргахдаа нөхцөл байдлыг тогтоон, сонсох ажиллагааг явуулж, иргэд, оролцогчдын оролцоог хангаж ажиллах	Жилийн эцсийн байдлаар А захирамж 299, Б захирамж 32, А тушаал 14, Б Тушаал 45 гарсан бөгөөд бүх захирамж, тушаал шийдвэр дээр хувийн хэрэг нээн ажилласан.	100%
28	2.5 Архивын өрөө, зориулалтын техник, хэрэгслийг шийдвэрлэн, 2023 онд зохион байгуулагдах “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг”-ийн бэлтгэлийг хангаж, “хангалттай сайн” үнэлэгдэх	Архивын өрөө нь зориулалтын техник хэрэгслээр бүрэн хангагдсан бөгөөд нягтаршуулсан шүүгээ- Төмөр зам дээр гүйдэг 1350000*6=8100000, Сканер түргэн-2100000, компьютер Делл-i5-2600000, Үдэгч машин /Цахилгаан/ -1800000, Тэргэнцэр -750000, Архивын өрөөний чийгшүүлэгч-520000, Баримт ариутгагч-1700000, Шат-800000, Баримт устгагч-580000, Зориулалтын ширээ-750000 нийт -20000000 төгрөгийн өртөг бүхий шаардлагатай тоног төхөөрөмжийг суурилуулсан. Түр 2008-2022 он хүртэл 572 хадгаламжийн нэгж ,Байнга 1992-2022 он хүртэл 177 хадгаламжийн нэгж, 70 жил 1957-2009 он хүртэл 37 хадгаламжийн нэгж устгах 1995-2017 он хүртэл 606 хадгаламжийн нэгж , 1972-2021 он хүртэл Зураг төсөл, техникийн байнга хадгалах 29 хадгаламжийн нэгж, 2011-2022 он хүртэл худалдан авах ажиллагааны баримт 255 хадгаламжийн нэгж нийт 1676 хадгаламжийн нэгжийг он цагийн дарааллаар эмхэлж цэгцэлсэн. Уг ажлыг гүйцэтгэхэд 1,250,000 төгрөгийг зарцуулсан	90%

29	<p>2.6 Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомж, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлыг үр дүнтэй төлөвлөн хэрэгжүүлж, гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг өмнөх оны мөн үеэс бууруулах</p>	<p>Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан “Анхаар хүүхэд”, “Илрүүлэлт-Шийдвэрлэлт”, “Мал хулгайлах ГХУС”, “Мод”, “Нуугдмал”, “Оргодол-1”, “Үзлэг шалгалт”, “Хяналт”, “Хүн бүр байгаль хамгаалагч”, “Уусан бол бүү жолоод”, “Анзаар”, “Мал мах-2023”, “Зэвсэг-2023”, “Зөрчлийн шийдвэрлэлт”, “Илрүүлэлт-Оргодол-Шийдвэрлэлт” зэрэг нөлөөллийн арга хэмжээг хариуцсан сум орон нутгийн хэмжээнд зохион байгуулан, эргүүл хяналт шалгалтаар 150 удаа 900 цагийн давхардсан тоогоор 1200 алба хаагч эргүүл, хяналт шалгалтыг зохион байгуулж, нийт 650 зөрчлийг илрүүлэн 51.473.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 70 зөрчил илрүүлэн ЗТХ-ийн 14.7 дугаар зүйлийн 3 дах хэсгийн 3.1 дэх хэсэгт заасан 1 жил эрх хасах 400 нэгжээр торгох арга хэмжээ авч шийдвэрлэсэн бол захиргааны журмаар 31 иргэнийг аймгийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр оруулж 7-30 хоногийн хугацаатай баривчлуулах шийтгэл оногдуулсан байна.</p> <p>Ерөө суманд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллага иргэнд тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 10 төрлийн 2023001, 07, 23, 27, 34, 36, 39, 68, 72, 73 дугаартай мэдэгдэл хүргүүлж, үр дүнг тооцсон. Цагдаагийн байгууллагаас өгсөн мэдэгдлийн хүрээнд мод бэлтгэн нийлүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Номин Од ХХК, ЭБНЗ ХХК, Сэлэнгэ Бугант ХХК, Монгол улсын стандарт MNS 6423:2019 шаардлага хангасан 35 ширхэг 35.000.000 төгрөгийн хяналтын камер суурилуулсан. Мөн Ерөө сумын 3 дугаар баг Бугант тосгоны нутаг дэвсгэр гудамж талбай олон нийтийн газарт үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийгмийн хариуцлагын хүрээнд модны аж ахуйн нэгж, байгууллага, нөхөрлөл 12.893.500 төгрөгийн өртөг бүхий 7 чиглэлд 19 хяналтын камер /чигийн 16, 360 градус эргэдэг 3/ тавьж суурилуулан, Бугант тосгоны цагдаагийн хэсэгт хүлээлгэн өгсөн.</p> <p>Сэлэнгэ аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга Б.Нарантуяагийн 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 40 дугаартай “Хамтдаа шалгая, хамгаалъя” арга хэмжээ зохион байгуулах тухай, мөн аймгийн Засаг даргын энэ оны 03 дугаартай албан даалгаврын хүрээнд хүүхдийг ахуйн осол гэмтэл, болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхийг хангах, хамгаалах, орчны эрсдэлийг бууруулах чиглэлээр сум, тосгоны хамтарсан баг, төр төсвийн байгууллагын ажилтан, алба хаагч нарыг цагдаагийн алба хаагчдын хамтаар нэгдсэн эргүүлийн хуваарьт оруулсан.</p> <p>Эргүүл хяналт шалгалтад өнөөдрийн байдлаар 38 удаа давхардсан тоогоор 131 алба хаагч, 152 цагийн эргүүлийн үүрэг гүйцэтгэн, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэж болзошгүй айл өрх, хараа хяналт сул хүүхдийн гэрээр орж, ярилцлага зохион байгуулсан. Мөн хүүхэд унаж бэртэж болзошгүй ухсан нүх, цахилгааны ил гарсан утас, эвдэрсэн тоглоом болон золбин нохойнуудын судалгааг гаргаж, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар эрх бүхий байгууллагад мэдэгдсэний дүнд Бугант тосгонд нохой устгах тухай Захирагчийн албанаас шийдвэр гаргуулан ажилласан.</p> <p>Улсын хэмжээнд зохион байгуулж байгаа “Анзаар” нэгдсэн арга хэмжээний хүрээнд Цагдаагийн Ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газраас Ерөө сумын ерөнхий боловсролын сургуулийн 200 сурагч, 100 гаруй эцэг, эх, багш сурган хүмүүжүүлэгч нарт “Хар тамхины өнөөгийн нөхцөл байдал, сөрөг үр дагавар” сэдэвт сургалтыг зохион байгуулахад тус цагдаагийн тасгийн алба хаагчид хамтран ажилласан.</p> <p>Мөн ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх газар, Урьдчилан сэргийлэх хэлтсээс бэлтгэн гаргасан видео шторк, контентыг тухай тасгийн пейж хуудас, алба хаагчид өөрсдийн фейсбүүк</p>	100%
----	---	--	------

		<p>хаягаас сумын олон дагагчтай группүүдэд түгээлт хийж, олон нийтэд сурталчилж ажилласан.</p> <p>Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нартай хамтран 7 удаагийн 96 цагийн эргүүл, хяналтын шалгалтын ажлыг зохион байгуулж, хууль бусаар ашигт малтмалд олборлосон 8 гэмт хэргийн шинжтэй үйлдлийг илрүүлэн мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.</p> <p>Сэлэнгэ аймгийн прокурорын газар, Ерөө сумын цагдаагийн тасгаас сум, тосгоны иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал, шалтгаан нөхцөлийн талаар энэ оны 05 дугаар сарын 29-ны өдөр Бугант тосгоны соёлын төвд сургалт орж, нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулсан. Энэхүү сургалтаар Монгол улсын Эрүүгийн хуулийн 24 дүгээр бүлэгт хамаарах хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн тухай ойлголт, хуулийн хариуцлагын талаар дэлгэрэнгүй байдлаар сургалт зохион байгуулж, 80 орчим иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл хамрагдсан.</p> <p>Хариуцсан сумын хэмжээнд энэ оны 11 сарын байдлаар 53 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд оны мөн үетэй харьцуулахад 27 нэгжээр буюу 33.7 хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байна.</p>	
30	2.7 Суманд үйл ажиллагаа явуулж буй сүм хийдийг хуулийн дагуу үйл ажиллагаа явуулахад хяналт тавьж, зөвшөөрөлгүй сүм хийдийг хуулийн этгээдийн бүртгэлд хамруулах, хамрагдаагүй сүм хийдийн үйл ажиллагааг таслан зогсоох	<p>Ерөө суманд зөвшөөрөлтэй 3 сүм, 1 дацан үйл ажиллагаа явуулж байна. Аймгийн ИТХурлын Тэргүүлэгчдийн 2022.07.08-ний өдрийн 71 дүгээр тоот тогтоолоор "Бугант Баптист", "Ерөө Баптист", "Ерөө нэгдсэн методист", "Зурхай засал гэгээрүүлэх дацан" тус тус 3 жилийн хугацаагаар үйл ажиллагаагаа сунгуулсан байна.</p> <p>1. "Ерөө Баптист" сүм нь 2021.02.11 өдөр Сэлэнгэ аймаг Ерөө сумын 2-р баг Буурагчин ногоон дов гудамж 1-126 тоотод 408 м2 талбайг түрээсийн гэрээгээр түрээслэн үйл ажиллагаагаа явуулдаг.</p> <p>2. "Ерөө нэгдсэн методист" сүм нь иргэн Р.Жаргалцэцэг, Л.Бямбасүрэн нарын гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газар дээр үйл ажиллагаа явуулдаг.</p> <p>3. "Зурхай засал гэгээрүүлэх дацан" нь 2010 оны 1-р сарын 20-ны өдөр Ерөө 1-р баг төвийн хэсэгт 15 жилийн хугацаатай хийдийн зориулалтаар газар эзэмших эрхийн гэрчилгээг тус тус аван үйл ажиллагаагаа явуулж байна. .</p>	100%
31	2.8 Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, Өрсөлдөөний тухай, Зар сурталчилгааны тухай хууль, ШӨХТГ-аас зарласан жилийн хүрээнд тодорхой ажлуудыг төлөвлөн зохион байгуулж, үр дүнг тооцох	<p>Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, Өрсөлдөөний тухай, Зар сурталчилгааны тухай хуулийг иргэд, олон нийтэд сурталчлах зорилгоор Ерөө сумын ЗДТГ-н мэдээ групп 3 төрлийн мэдээлэл байршуулж 45 иргэний хандалт авсан байна.</p> <p>Төрийн ажил үйлчилгээний чанар хүртээмж, үр дүнгийн талаар хэрэглэгчийн санал асуулгыг салбар бүрд цахимаар 4, санал асуулгын хуудсаар 1 удаа явуулж нийт 772 өрх, иргэнээс санал авч дүн шинжилгээ хийн ажил үйлчилгээндээ тусган хэрэгжүүлэн ажилласан. Иргэдээс ирсэн санал хүсэлтийн дийлэнх нь хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, сумын өнгө үзэмж, ажлын байрны санал санаачилга байна. Сумын төр, төсвийн байгууллагуудын ажил үйлчилгээ хангалттай хэмжээнд үнэлэгдсэн.</p>	70%
32	2.9 Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг сурталчилж, МУ-ын Засгийн газрын 2017 оны 195 дугаар тогтоолоор батлагдсан "Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс	<p>"Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан эд хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журам"-ын хэрэгжилтийг ханган орон тооны бус зөвлөл хуралдаж холбогдох шийдвэрүүдийг гарган материалуудыг цагдаа, прокурорын байгууллагад хугацаанд нь хүргэн ажилладаг.</p>	100%

	хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах жүрам"-ын хэрэгжилтийг хангах		
33	2.10 Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийг хэрэгжүүлж, бүртгэл судалгааг хуулийн дагуу явуулан тайлан мэдээг аймгийн ЗДТГ-т сар бүр мэдээлж тайлагнах	Суманд бүртгэлтэй гадаадын иргэн байхгүй байна.	100%
34	2.11 Улсын хил хамгаалалтад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, зарласан аян, ажил, арга хэмжээг Хил хамгаалах байгууллагуудтай хамтран үр дүнтэй зохион байгуулж, Хилийн тухай хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллах	Улсын хил хамгаалах байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийн дагуу Хил хамгаалах тухай хуулийг сурталчлан ажиллаж байна.	70%
35	2.12 Сумын Засаг дарга болон эрх бүхий албан тушаалтнаас тусгай зөвшөөрөл, энгийн зөвшөөрөл олгохдоо Зөвшөөрлийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, хувийн хэргийг бүрдүүлж, хяналт тавьж ажиллах	<p>Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй худалдаа үйлчилгээний газрын хүсэлтийн дагуу шаардлага хангасан 5 хүнсний дэлгүүрт Тамхи худалдаалах тусгай зөвшөөрлийг хууль тогтоомжийн дагуу олгож. Тусгай зөвшөөрөл авсан 5 аж ахуй нэгж иргэд санамж бичиг өгч хувийн хэрэг бүрдүүлэн ажиллаж байна.</p> <p>3 удаагийн хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж 5 дэлгүүрт Цагдаагийн байгууллага, аймгийн Эрүүл мэндийн газрын эрүүл ахуйн байцаагчтай хамтран хяналт шалгалт хийж зөрчлийг арилгуулж заавар зөвлөгөө өгч ажилласан.</p> <p>Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хязгаарыг шинэчлэн тогтоох тухай аймгийн Засаг даргын А/02 дугаартай захирамжийг архины тусгай 10 аж ахуй нэгжид мэдэгдэн цагдаагийн байгууллагатай хамтран хяналт тавьж ажиллаж байна. Архи согтууруулах ундаа худалдаалдаг сумын төвд байрлалтай 7 аж ахуй нэгжид төлөвлөгөөт төлөвлөгөөт бус 3 удаагийн хяналт шалгалтыг хийж зөрчлийн арилгуулж заавар зөвлөгөө өгч ажиллаа.</p> <p>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн норматив тогтоох тухай” А/272 дугаар тушаалаар согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх цэгийн тоог аймаг, нийслэл, суманд 1000 хүн тутамд 4 хүртэл байхаар тогтоосныг баримтлан ажиллаж байна. Сумын хүн амын тоо 7257 тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж 18 байна. www.e-mongolia.mn- согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгалтын үйлчилгээг авах талаар Ерөө сумын ЗДТГ-ын мэдээ цахим сайт 3 удаа мэдээллээ. Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахаар тодорхойлолт авсан 6 аж ахуйн нэгжид e-mongolia-аас үйлчилгээ авах боломжтой талаар заавар зөвлөгөө өгч ажиллаа.</p>	100%
ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ:			
36	3.1 “Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай” Аймгийн Засаг даргын албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах	Мал аж ахуйг байгаль, цаг уурын эрсдэлээс хамгаалах, бэлэн байдлыг хангах зорилгоор 2022 онд нөөцөлсөн 120 тн өвсийг 2023 оны хавар 1,2-р багийн нийт 50 малчин, мал бүхий өрхөд хуваарилан хөнгөлөлттэй үнээр олгосон. Мөн 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах арга хэмжээний тухай Засгийн газрын 2021 оны 221 тоот тогтоолын хүрээнд 2023 онд бизнесийн зориулалтаар хадлан бэлдэж буй 1 га талбайгаас 2 боодол өвсийг сумын өвсний фондод авахаар 35 иргэнтэй гэрээ байгуулан ажиллаж одоогийн байдлаар 50 тн өвсийг бэлтгээд байна. Мөн тэжээлийн нөөцийг газар тариалангийн аж ахуйн нэгжүүдтэй хамтран 4 тн тэжээлийг нөөцлөөд байна.	100%

		Малчин, мал бүхий иргэдтэй хадлангийн гэрээ байгуулахдаа 2 тн өвс нэмж нөөцлөхийг үүрэг болгон бэлтгүүлсэн. Малчин, мал бүхий иргэдтэй хадлангийн гэрээ байгуулахдаа 2 тн өвс нэмж нөөцлөхийг үүрэг болгон бэлтгүүлсэн	
37	3.2 Малын тоо толгойн албан татварын орлогыг "Төсвийн тухай хууль"-ийн 60 дугаар зүйлийн 60.2.8 дахь заалтын дагуу зарцуулах, хяналт тавих	Малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр энэ онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Сайн чанарын 2 гүү • Малын үүлдэр угсааг сайжруулах зорилгоор 5 бух • Малчдад зориулсан сургалт, туршлага судлуулах • Малын тарилгын суурин төмөр 2 хашаа • Мал угаалгын банн 1 • Нарийн хөндийд гүний худаг 1 • Мал үржлийн нэгжийн үйл ажиллагааны зардал • Хөдөөгийн хэсэгт 2 гүүр тавих ажлуудыг тус тус хийж хүлээлгэн өгөөд байна. 	100%
38	3.3 Тариалангийн бүс нутагт үржүүлж буй мал сүрэгт үзлэг ангилалт хийх, цөм сүрэг бүрдүүлэх, стандартын шаардлага хангасан үржлийн малыг ялган тэмдэглэж, мэдээллийн нэгдсэн санд бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулах	Тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйн суурин, хагас суурин мал аж ахуйг эрхлэн ажлын хүрээнд малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр "ХАРИУЦЛАГАТАЙ МАЛЧИН- ХӨДӨӨ АЖ АХУЙН СЭРГЭЛТ" сургалтыг зохион байгуулан нийт 60 гаруй малчин, мал бүхий иргэдийг хамруулж малын үүлдэр угсааг сайжруулахаар НҮБ-ын ХХААБ-ын Стрийм төслөөс 80 гаруй сая төгрөгийн тоног төхөөрөмжийг нийлүүлсэн бөгөөд малын ашиг шимийг нэмэгдүүлэх малын генийн санг хамгаалах зорилгоор хавар намрын давхардсан тоогоор 250 хуц, 200 ухна, 2500 Ерөө үүлдрийн хэсгийн хонинд үзлэг ангилалт хийж 10 дугаар сард үржлийн болон цөм сүргийн 367 хонинд Цыга үүлдрийн хуцнаас үр авч зохиомол хээлтүүлэг хийгээд байна.	100%
39	3.4 Мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгжийг байгуулж, бог малын хээлтүүлэгчийн мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжид төвлөрүүлэх	Малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр сумандаа мал үржлийн нэгж байгуулан бог малын хээлтүүлэгчийн ялган төвлөрүүлээд байна.	100%
40	3.5 Бэлчээрийн даацаас илүү гарсан малыг эдийн засгийн эргэлтэд оруулах	Бэлчээрийн даацаас илүү гарсан малыг эдийн засгийн эргэлтэд оруулах талаар малчин, мал бүхий иргэдэд мэдээлэл өгч уриалга гарган ажиллаж байна. Мөн Улаанбаатар хотын "ХӨХ ҮҮР АГРО" ХХК-тай 1000 хурга нийлүүлэхээр санамж бичигт гарын үсэг зураад байна. Одоогийн байдлаар 26462 толгой малыг зах зээлийн эргэлтэд оруулаад байна.	100%
41	3.6 Отор нүүдлээр ирсэн малчид, малын судалгаа мэдээллийг дэлгэрэнгүй гаргаж холбогдох арга хэмжээг тухай бүр авч ажиллах	Отор нүүдлээр ирсэн 5 малчин өрхийн судалгаа гаргаж багийн дарга нартай хамтран хугацаатай мэдэгдэл өгч ажилссанаас одоогийн байдлаар 5 өрх буцаж гарсан байна.	100%
42	3.7 "АТАР IV" аяны хүрээнд газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжиж, нэмүү өртөг шингэсэн өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	Монгол улсын Засгийн газрын 2020 оны "Газар тариалангийн тогтвортой хөгжлийг дэмжих арга хэмжээний тухай" 138 дугаар тогтоол болон Монгол Улсын Их Хурлын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 36 дугаар тогтоолын 3.1-д заасан "Тариалангийн зориулалттай газар ашиглалтыг сайжруулах, талбайн хэмжээг нэмэгдүүлэх, атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх, зорилгын хүрээнд сумын Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 373 тоот албан бичгээр тус сумын хэмжээнд тариалангийн ангилалд шилжүүлэх боломжтой 84 байршилд 1159 га газрын судалгааг гарган координатжуулан аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлсэн. Тариалангийн тухай хуулийн 5.1 дэх заалтад Сум дүүргийн ИТХ-д атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх талаар Засаг даргын саналыг хэлэлцэж шийдвэр гаргана гэж заасны дагуу атар газарт шилжүүлэх боломжтой ашиглаж байгаа 597 га, атар газар	100%

		<p>нэмж хагалах боломжтой 562 га газрыг сумын ИТХ-д санал оруулан батлуулахаар хэлэлцэх шатандаа явж байна.</p> <p>Монгол улсын Газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3, Засгийн газрын 2003 оны 02-р сарын 07-ны өдрийн 28 тоот тогтоолын 5 дугаар хавсралт “Тариалангийн газрыг давуу эрхээр эзэмшүүлэх журам”-ын дагуу 7 иргэний өргөдлийг хэлэлцүүлж, давуу эрхийн тариаланч өрхөөр тодорхойлуулахаар сумын ИТХуралд саналыг хүргүүлсэн.</p> <p>➤ 2023 онд ногоочдын үйл ажиллагааг эрчимжүүлэн дэмжих зорилгоор ХХААХҮЯамнаас 80 хувийн хөнгөлөлттэй үнээр ирсэн 397300 төгрөгний үнэ бүхий 300 кг сонгино, 200 кг саримс, 1 кг хүрэн манжин, 4 кг шар манжин, 4 кг лууван, 1 кг бууцай, 5 уут байцаа, 1 кг урт сонгино, 6 уут өргөст хэмхний үрийг 196 ногоочинд олгож, 65,4 га талбайд тариалалт хийсэн. Цаг агаарын өөрчлөлтийн улмаас хаврын тариалалт оройтож эрт тариалсан хүнсний ногооны соёлолт удаашран тариалах талбайн хэмжээ буурсан ч га талбайгаас авсан ургацын үзүүлэлт өнгөрсөн онтой харьцуулахад 0.2 цн-ээр өссөн дүнтэй байна.</p> <table border="1" data-bbox="831 646 1761 980"> <thead> <tr> <th></th> <th colspan="2">2021</th> <th colspan="2">2022</th> <th colspan="2">2023</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Улаан буудай</td> <td>9662 га</td> <td>11805тн</td> <td>12822га</td> <td>23079тн</td> <td>8399га</td> <td>16706,1 тн</td> </tr> <tr> <td>Арвай</td> <td>-</td> <td>-</td> <td>49га</td> <td>38тн</td> <td>77га</td> <td>70тн</td> </tr> <tr> <td>Рапс</td> <td>2842 га</td> <td>2000 тн</td> <td>2761га</td> <td>1086тн</td> <td>4766,6 га</td> <td>1779,09 тн</td> </tr> <tr> <td>овъёос</td> <td>156 га</td> <td>176тн</td> <td>92га</td> <td>111тн</td> <td>77га</td> <td>140тн</td> </tr> <tr> <td>Ногоон тэжээл</td> <td>481 га</td> <td>325тн</td> <td>617га</td> <td>534тн</td> <td>75га</td> <td>90тн</td> </tr> <tr> <td>төмс</td> <td>63,4 га</td> <td>761,8тн</td> <td>67,2га</td> <td>915тн</td> <td>57,5га</td> <td>575,3тн</td> </tr> <tr> <td>Хүнсний ногоо</td> <td>75,75 га</td> <td>873тн</td> <td>82,6га</td> <td>842,9тн</td> <td>65,4га</td> <td>680,9тн</td> </tr> <tr> <td>Уринш</td> <td>10701 га</td> <td></td> <td>7501га</td> <td></td> <td>10448га</td> <td></td> </tr> </tbody> </table> <p>Хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 3.6.2 дахь заалтын хэрэгжилтийг хангах, хөрсний үржил шимийг сайжруулахаар тариалалтад зориулж бордоо худалдан авсан ААН, иргэнд үнийн дүнгийн 30 хүртэлх хувьд татаас олгох ажлын хүрээнд үр тарианы 9 ААНэгж хүсэлтээ илгээн хамрагдсан бөгөөд үүнтэй холбоотой энэ онд нэгж га талбайгаас хураан авсан улаан буудайн ургацын хэмжээ 19,9 цн буюу өмнөх онуудтай харьцуулахад өссөн дүнтэй байна.</p>		2021		2022		2023		Улаан буудай	9662 га	11805тн	12822га	23079тн	8399га	16706,1 тн	Арвай	-	-	49га	38тн	77га	70тн	Рапс	2842 га	2000 тн	2761га	1086тн	4766,6 га	1779,09 тн	овъёос	156 га	176тн	92га	111тн	77га	140тн	Ногоон тэжээл	481 га	325тн	617га	534тн	75га	90тн	төмс	63,4 га	761,8тн	67,2га	915тн	57,5га	575,3тн	Хүнсний ногоо	75,75 га	873тн	82,6га	842,9тн	65,4га	680,9тн	Уринш	10701 га		7501га		10448га		
	2021		2022		2023																																																													
Улаан буудай	9662 га	11805тн	12822га	23079тн	8399га	16706,1 тн																																																												
Арвай	-	-	49га	38тн	77га	70тн																																																												
Рапс	2842 га	2000 тн	2761га	1086тн	4766,6 га	1779,09 тн																																																												
овъёос	156 га	176тн	92га	111тн	77га	140тн																																																												
Ногоон тэжээл	481 га	325тн	617га	534тн	75га	90тн																																																												
төмс	63,4 га	761,8тн	67,2га	915тн	57,5га	575,3тн																																																												
Хүнсний ногоо	75,75 га	873тн	82,6га	842,9тн	65,4га	680,9тн																																																												
Уринш	10701 га		7501га		10448га																																																													
43	3.8 Тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийг хуульд заасны дагуу өөрийн эзэмшлийн талбай, ургацаа бусдын хандлага болон малаас хамгаалах, хашаажуулах, ойн зурвас байгуулах ажлыг хийж гүйцэтгэх	2023 онд Малчдын өвөлжөө, хаваржааны ойр “ТАРИАЛАНГИЙН ТАЛБАЙГ ХАШААЖУУЛАХ” ажлын хүрээнд Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч 8 ААНэгж 2770 га талбайг өөрсдийн хөрөнгөөр хашаажуулаад байна.	100%																																																															
44	3.9 Ургамал хамгааллын бодис бордооны зохистой хэрэглээнд хяналт шалгалт хийж, дотоод хорио цээртэй болон гоц хөнөөлт организмыг устгах ажлыг зохион байгуулах	Аймгийн ХХААГазрын Ургамал хамгаалал хорио цээрийн асуудал хариуцсан байцагч Азжаргалтай хамтран ургамал хамгааллын бодисын зохистой хэрэглээнд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж зөвлөмж хүргэн ажиллаа. 2023 онд Ерөө суманд газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч Жаргалант Ерөө ХХК нь БНМАУ-с ургамал хамгааллын бодис үйлдвэрлэдэг томоохон компаниудтай хамтран МУ-	100%																																																															

		н газар тариалангийн салбарт тохирсон бүтээгдэхүүнийг импортлон оруулж ирдэг болсон байна.	
45	3.10 Эрүүл ахуй, чанар, стандартын шаардлага хангасан зоорь, агуулах, элеваторын тоо хэмжээг нэмэгдүүлэх, бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулах	Сумын хэмжээнд 108 ширхэг энгийн хийцтэй нийт 1053 тн багтаамж, 1 ширхэг 100 тн багтаамжтай механикжсан зоорийг ашиглалтад оруулж одоогийн байдлаар 35 тн төмс хүнсний ногоог хадгалж байна.	100%
46	3.11 Усалгаатай тариалангийн талбайн тооллогыг зохион байгуулж, усалгаатай тариалангийн хэмжээг нэмэгдүүлэх	Усалгаатай тариаланг хөгжүүлэхээр услах боломжтой газруудын судалгааг гаргаж 12,5 га талбайг төмс, хүнсний ногоо тариалахаар олгосон. Энэ онд 40 га талбайд төмс, 50 га талбайд хүнсний ногоо тариалаад байна.	100%
47	3.12 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд жимс жимсгэнийн тариалалтыг нэмэгдүүлэх, боловсруулах үйлдвэр байгуулах	Сүүлийн 5 жилийн дотор нийт 176 өрх 45,8 га талбайд чацаргана, үхрийн нүд , бөөрөлзгөнө, алим болон бусад жимс жимсгэний суулгацыг тариалсан бөгөөд тариалалтын 87,7 %-ийг чацаргана, үхрийн нүдний мод, бут эзлэж байна.2023 оны байдлаар чацаргана – 3,2 тн , үхрийн нүд- 2,8 бөөрөлзгөнө- 5 кг, тэсэргэнэ- 7кг, улаалзгана- 15 кг, алим-5кг тус тус хураан авсан. Нийт өрхийн 10 орчим хувь нь жимсээр нь 230 кг, өрхийн хэрэгцээнд жимсгэний чанамал боловсруулан 0,5 гр-ийг дунджаар 10000-12000 төгрөгөөр үнэлэн үзэсгэлэн худалдаа болон хот суурин газрын иргэдэд захиалгаар нийлүүлэн борлуулж байна. 2023 онд жимс жимсгэний тариалалтын төрлийг нэмэгдүүлэх зорилгоор ЗДТГ, “Хашаандаа сайхан амьдаръя” групп хамтран Булган голын алим ХХК-ний захирал Хумжаагийн Балжиннямаар “Алим тариалах аргачлал” онол практикийн сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд идэвхи санаачилгатай оролцсон 1 , 2-р багийн нийт 42 иргэнд БТЕГ ХХК-ний Байгаль орчны албанаас бэсрэг алимны модны суулгацыг үнэ төлбөргүй олгон жимс, жимсгэний тариалалтыг дэмжин ажиллаа.	100%
48	3.13 Хүнсний хангамж-аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах	Хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 3.6.2 дахь заалтын хэрэгжилтийг хангах, хөрсний үржил шимийг сайжруулахаар тариалалтанд зориулж бордоо худалдан авсан ААН, иргэнд үнийн дүнгийн 30 хүртэлх хувьд татаас олгох ажлын хүрээнд үр тарианы 9 ААН хүсэлтээ илгээн хамрагдсан бөгөөд үүнтэй холбоотой энэ онд нэгж га талбайгаас хураан авсан улаан буудайн ургацын хэмжээ 20,3 цн буюу өмнөх онуудтай харьцуулахад өссөн дүнтэй байна. Улаан буудай болон хүнсний ногооны урамшууллыг 13 ААН, 5 иргэн тариалангийн Plant.mofa.gov.mn программд шивэн хүсэлтээ илгээгээд байна.	50%
49	3.14 Органик үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Адра олон улсын байгууллагын Органик хөдөө аж ахуйн түншлэл төсөл нь Органик хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг Сэлэнгэ Дархан уул аймгуудад тэлж , хамтын баталгаажуулалтын тогтолцоог бэхжүүлэн орон нутгаас нийлүүлдэг органик хүнсний нийлүүлэлт борлуулалтын үр ашигтай сүлжээг талуудын оролцоотойгоор бий болгох зорилгоор 2023 онд дахиан сунгагдан хэрэгжихээр үйл ажиллагаагааны хүрээнд Ерөө сумаас 6 хоршоо сонгогдоод байна.	70%
50	3.15 Сумын хөдөө аж ахуйн салбарыг мэргэжлийн боловсон хүчнээр хангаж, бүтэц орон тоог бүрдүүлэн ажиллах	Хөдөө аж ахуйн тасаг: <ul style="list-style-type: none"> • Хөдөө аж ахуйн тасгийн дарга • Бэлчээр газар тариалан хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн • ЖДҮ хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн • МЭТ-н дарга, улсын байцаагч • Тархвар зүйч гэсэн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. 	100%

51	3.16 Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг технологит хугацаанд шуурхай зохион байгуулах	Мал эмнэлгийн үйл ажиллагаанд төрөөс тавих хяналтыг сайжруулан урьдчилан сэргийлэх арга хэмжээг чанаржуулах ажлын хүрээнд энэ онд Улсын санхүүжилттэй тарилга-3, Орон нутгийн санхүүжилттэй тарилга- 6, Гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга-3 нийт 12 төрлийн тарилгыг 213'724 толгой мал, амьтанд хийгдэж одоогийн байдлаар гоц халдварт өвчин бүртгэгдээгүй эрүүл малтай сумын статусаа хадгалж байна.	100%
52	3.17 Мал, амьтны гэрчилгээ, баталгаажуулалтын нэгдсэн цахим системийн хэрэгжилтийг бүрэн нэвтрүүлэх	2023 оны жилийн эцсээр мал эмнэлгийн 1822 гэрчилгээ бичигдсэнээс <ul style="list-style-type: none"> • Бүтээгдэхүүний зориулалтаар-1013 гэрчилгээ • Отор нүүдлийн зориулалтаар -59 гэрчилгээ • Үржлийн зориулалтаар-182 гэрчилгээ • Хэрэгцээлэх зориулалтаар-567 гэрчилгээ 	100%
53	3.18 Аймгаас зохион байгуулж буй үзэсгэлэн худалдаа, бусад арга хэмжээнд сумаа удирдлага зохион байгуулалтаар хангаж, бүрэн хамруулах	2023 онд Улс, аймгийн 10 үзэсгэлэн худалдаанд давхардсан тоогоор 59 жижиг дунд бизнес эрхлэгч, аж ахуйн нэгж, хоршоод 158 төрлийн бүтээгдэхүүнээр оролцож 22,640,200 төгрөгийн орлого олсон байна. Ерөөлтэй цагаан сар-2023, ургацын баяр, малчдын өдөрлөг арга хэмжээний үеэр 3 удаагийн үзэсгэлэн худалдааг сумандаа зохион байгуулж 24 иргэн 2 аж ахуй нэгж 72 төрлийн бараа бүтээгдэхүүнээр оролцож 10400000 төгрөгийн борлуулалт хийсэн байна.	100%
БАЙГАЛЬ ОРЧИН, УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН АЖИЛ АРГА ХЭМЖЭЭ:			
54	4.1 Ойн санг гэрээгээр эзэмшиж буй нөхөрлөлүүдтэй хамтран ажиллах гэрээг шинэчлэх, үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж илэрсэн зөрчлийг арилгуулах	Ойн мэргэжлийн 16 аж ахуйн нэгж, ойн санг гэрээгээр эзэмшигч 10 нөхөрлөлтэй түймрийн хариуцлагын гэрээг сумын Засаг даргатай байгуулж, хуваарийн дагуу түймрийн эргүүлийг давхардсан тоогоор 16 удаа хийж ажиллууллаа. Мод бэлтгэх тусгай зөвшөөрөлтэй 16 аж ахуйн нэгжийн, ой хээрийн түймрийн үед хэрэглэх багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангуулсан. 2023 оны 4 сарын 1-нээс 6 дугаар сарын 10, 9 дүгээр сарын 20-оос 10 дугаар сарын 10-ны хооронд ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Ерөө бүсийн сум дундын ойн анги, ХХУТХГ-ын Ерөө хэсэг ойн мэргэжлийн 16 аж ахуйн нэгж хамтарсан хуваарь гаргаж, ойн сан бүхий газруудад эргүүл хяналтын ажлуудыг хуваарийн дагуу хяналтын эргүүл шалгалтыг нийт 16 удаа хийж гүйцэтгэсэн. Бугант тосгоны нутагт дэвсгэр болох 35-ын аманд, 2 дугаар баг Баянгол, дэнжийн гацал. Ялбаг Асгатын ам, бэрлэгийн цагаан тохойд нийт 5 удаа ой хээрийн түймэр гарч Сэлэнгэ аймгийн онцгой байдлын газар, Мандал сумын онцгой байдлын алба, ойн санг гэрээгээр эзэмшдэг аж ахуй нэгжүүд болон сумын иргэдтэй нийлж хугацаа алдалгүй хохирол багатай унтраасан.Түймрийн эзэн холбогдогчийг олж тогтоох ажлыг цагдаагийн байгууллагад шилжүүлсэн.	100%
55	4.2 сумын хэмжээнд “Тэр бум мод” аяныг өрнүүлэн ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх	“БҮХ НИЙТЭЭР МОД ТАРИХ” арга хэмжээг 2023 оны 05 дугаар сарын 17- н, 10 дугаар сарын 17- ний өдрүүдэд тус тус зохион байгууллаа. Уг арга хэмжээнд “БТЕГ” ХХК, ойн мэргэжлийн байгууллагуудын модны тарьцыг “Эзэнтэй мод” урианы дор нийтийн эзэмшлийн зам талбайд нөхөн тарилтаар 25 ш нарс мод, шинээр “Төгөлдөр Ерөө” ОНӨАТҮГ-тай хамтран Гэрэлт гудамжинд 1000 ш хайлаас, Трактортой толгойд 1250 ш гүйлс, голт бор мөн албан байгууллага болон айл өрхүүдэд 4000 ширхэг хайлаас, өрөл, монос, агч зэрэг модыг тараан тарьж ургуулах ажлыг зохион байгуулж заавар зөвлөгөөг өгч ажиллалаа. Сумын хэмжээнд нийт шинээр болон нөхөн тарилтаар 8 төрлийн 6275 ширхэг мод тарилаа. БТЕГол ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд Ерөө сум хүртэлх 3,7 км авто зам дагуу ногоон байгууламжийг хамгаалах хашаа барьж, мод тарьсан. /17,0 сая₮/	100%

56	4.3 Бүх нийтийн хог, цас цэвэрлэгээг тогтмол зохион байгуулж, тайлагнан “Хоггүй цэвэрхэн Сэлэнгэ” аяныг өрнүүлэн үр дүнг тооцох	Сумын нэгдсэн хогийн цэгийн хогийг нийт 15 удаа түрж булшлах ажил хийж гүйцэтгэлээ. Нийт 160000м2 талбайн 128000м3 хогийг түрж булшилсан байна. Сумын төвийн айл өрх, албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн энгийн хог хаягдал цуглуулах, тээвэрлэх ажлыг хуваарийн дагуу гүйцэтгэн ажиллаж оны эхнээс 251 өдөр 1200 айл өрх, 30 байгууллагын хог хаягдал цуглуулж ойролцоогоор 1150 тн хог хаягдал тээвэрлэн хогийн цэгт хүргэсэн байна Аймгийн Засаг даргын 2023 оны “Бүх нийтийн хог цэвэрлэгээ арга хэмжээ зохион байгуулах тухай” А/156 дугаар захирамжийн хүрээнд Ерөө самбараас БТЕГ ХХК-ний зогсоол хүртэлх 9,9 км хатуу хучилттай автозамын хоёр талаар хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулж 5 орчим тонн хог хаягдлыг цуглуулан тээвэрлэж төвлөрсөн хогийн цэгт буулгасан. Мөн хавар, намар 2 удаа аж ахуйн нэгж байгууллагууд, айл өрх, ЕБС-ын сурагчдыг дайчлан бүх нийтийн хог цэвэрлэгээг зохион байгуулж сумын төвийн эзэнгүй хог хаягдал, гудамж талбай, голын ай сав газрыг цэвэрлэж 5 тн орчим хог хаягдал цуглуулж тээвэрлэн нэгдсэн хогийн цэгт буулгасан.	100%
57	4.4 Стандартын шаардлагад нийцээгүй нүхэн жорлонг үе шаттайгаар ариутган устгах, булшлах замаар “Эко жорлон”-г хэрэглэж хэвших	Нүхэн жорлонтой айл өрхийн судалгааг гаргаж, хөрсний бохирдол үүсгэгч нүхэн жорлонгийн хэрэглээг зогсоох, стандарт шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжийг бий болгох байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар мэдээ мэдээллийг хүргэж био жорлонтой болгох талаар ухуулга сурталчилгаа, гарын авлага айл өрхүүдэд тарааж ажиллалаа.	50%
58	4.5 Агаар бохирдуулах бодисын хаягдал агаарт үзүүлэх физикийн сөрөг нөлөөлөл тэдгээрийн эх үүсвэрийн улсын тооллогыг төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу холбогдох байгууллагатай хамтран гүйцэтгэх	Зуух, пийшин, яндангийн битүүмжлэл алдагдах, янданд цэвэрлэгээ хийгээгүйн улмаас бөглөрөл үүсэх, яндангийн гүхээгийн хаалтыг хаасан, зуухны битүүмжлэл алдагдсан зэргээс шалтгаалан угаар гарах нөхцөл бүрдэж, иргэд угаарын хийн хордлогод өртөх эрсдэл нэмэгддэг талаар сэрэмжлүүлэх мэдээ мэдээлэл бэлтгэн Ерөө сумын цахим хаягуудаар сурталчлан ажиллалаа.	50%
59	4.6 Булаг шандын эхийг тохижуулах ажлыг зохион байгуулах	“БТЕГ” ХХК-нь Баянголыг рашааны эх, Хонгорын рашаан, Дэлэнч, Улаанбулаг, Хужиртын булгийн хашааг сэргээн засварлаж эргэн тойрны хог хаягдлыг малчин өрхүүд цэвэрлэсэн. Усны ундаргаас нэмэгдсэн.	90%
60	4.7 Цөлжилтийн судалгаанд тулгуурлан үр шим нь буурсан тариалангийн талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулах, бэлчээрийн талхагдлыг бууруулах, сэлгэх, чөлөөлөх, шимт ургамал тарималжуулах ажлыг хийж гүйцэтгэх	Сэлэнгэ аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2022 оны 12 дугаар сарын 28 - ны өдрийн 86 тоот тогтоол болон Ерөө сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 85 тоот тогтоолыг үндэслэн баталсан хуваарийн дагуу өөрийн хөрөнгөөр 427.24 га талбайд ойжуулалтын ажил хийгдэхээс ойн мэргэжлийн байгууллага болох 11 аж ахуй нэгж 204 га талбайд өөрийн хөрөнгөөр Яргайт, 16-ын даваа, Баян гол /Сөдтэй/, Нам даваа Дөхөм, зэрэг газруудад нарсны тарьцаар ойжуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн байна.	70%
61	4.8 Ойн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд магадлан итгэмжлэл хийлгүүлэн, ойн нөөцийг үр ашигтай ашиглах	Энэ онд нийт 36 аж ахуйн нэгж магадлан итгэмжлэлд хамрагдсанаас 32 аж ахуйн нэгж тэнцэж нэг аж ахуйн нэгж ахин оролцохоор болсон.	90%
62	4.9 Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах эргүүл, пост ажиллуулах, сургалт, сурталчилгааг зохион байгуулах	Ойн мэргэжлийн 18 аж ахуйн нэгж, ойн санг гэрээгээр эзэмшигч 10 нөхөрлөлтэй түймрийн хариуцлагын гэрээ хийж, хуваарийн дагуу түймрийн эргүүлийг давхардсан тоогоор 16 удаа хийж Улаан гүүрэн дээр ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хяналтын постыг батлагдсан хуваарийн дагуу ажиллууллаа. Мод бэлтгэх тусгай зөвшөөрөлтэй 14 аж ахуйн нэгжийн, ой хээрийн түймрийн үед хэрэглэх багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангуулж ажиллалаа. 2023 оны 4 сарын 1-нээс 6 дугаар сарын 10-ны хооронд ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Ерөө бүсийн сум дундын ойн анги, ХХУТХГ-ын Ерөө хэсэг ойн мэргэжлийн 14 аж ахуйн нэгж хамтарсан хуваарь гаргаж, ойн сан бүхий газруудад эргүүл	100%

		хяналтын ажлуудыг хуваарийн дагуу хяналтын эргүүл шалгалтыг нийт 16 удаа хийж гүйцэтгэсэн. Бугант тосгоны нутагт дэвсгэр болох 35-ын аманд ойн түймэр гарч Сэлэнгэ аймгийн онцгой байдлын газар, ойн санг гэрээгээр эзэмшдэг аж ахуй нэгжүүдтэй хохирол багатай унтраасан.Ерөө сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт гарсан хээрийн 2 түймэрт Бугантаас 2 автомашин, 8 хүн явж тухайн гарсан түймрийг түргэн шуурхай унтраасан.	
63	4.10 Ой хээрийн түймэр гарсан тохиолдолд эзэн холбогдогчийг тогтоох, түймрийн улмаас экологид учирсан хохирлыг буруутай этгээдээс нэхэмжлэн барагдуулах	Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор ойн сан гэрээгээр эзэмшиж байгаа аж ахуйн нэгж, нөхөрлөлүүд өөрийн ойн сандаа морьт эргүүл гарган хуваарийн дагуу эргүүл, хяналт шалгалтыг хийж ажиллалаа. Хагас жилийн байдлаар 3 удаагийн ой хээрийн түймэр гарч 83.9 га талбай түймэрт өртөж 76,881,150 төгрөгийн хохирол учирсан. Эзэн холбогдогчийг тогтоон учирсан хохирлыг буруутай этгээдээс нэхэмжлэн барагдуулахаар цагдаагийн байгууллагад шилжүүлж ажилласан.	100%
64	4.11 Ой хээрийн түймэрт шатсан талбайг нэн тэргүүнд ойжуулах арга хэмжээ авах, ойжуулсан талбайд мал бэлчээхгүй байх	Сэлэнгэ аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2022 оны 12 дугаар сарын28 - ны өдрийн 86 тоот тогтоол болон Ерөө сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 85 тоот тогтоолыг үндэслэн баталсан хуваарийн дагуу өөрийн хөрөнгөөр 427.24 га талбайд ойжуулалтын ажил хийгдэхээс ойн мэргэжлийн байгууллага болох 11 аж ахуй нэгж 204 га талбайд өөрийн хөрөнгөөр Яргайт, 16-ын даваа,Баян гол /Сөдтэй/, Нам даваа Дөхөм, зэрэг газруудад нарсны тарьцаар ойжуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Мөн ойжуулсан талбайд мал бэлчээхгүй байх арга хэмжээг авч ажиллаж байна.	100%
65	4.12 Газар эзэмшигч, ашиглагч иргэн ААН байгууллагын гэрээг дүгнэж төлбөрийг төвлөрүүлэх	Сумын Засаг даргын 2023 оны 02 сарын 27-ны өдрийн 85 тоот албан бичгээр газар эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад гэрээ дүгнэх тухай мэдэгдлийг хүргүүлсэн бөгөөд тайлант хугацаанд 14 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын 99 нэгж талбарын газар эзэмших, ашиглах гэрээг дүгнээд байна. Төсвийн орлогын төлөвлөгөөний дагуу тайлант жилд 275.4 сая төгрөгийг газрын төлбөрийн орлогод төвлөрүүлэхээр тусгагдсан бөгөөд орлогыг бүрэн төвлөрүүлээд байна.	100%
66	4.13 Газар өмчлөхтэй холбогдсон хууль тогтоомжийг сурталчлан газар өмчлүүлэх ажлыг эрчимжүүлэх	Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 09 сарын 30-ны өдрийн 69 дугаар “2023 онд иргэнд өмчлүүлэх газрын зориулалт, байршил, хэмжээг батлах тухай” тогтоолыг батлуулан ажилласан бөгөөд Монгол улсын иргэнд 2023 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай Монгол улсын Засгийн газрын 2023 оны 03 сарын 22-ны өдрийн 105 дугаар тогтоол батлагдан гарснаас хойш дээрх тогтоол шийдвэрүүдийг үндэслэн сумын Засаг даргын 10 удаагийн захирамжаар нийт 89 иргэнд 17.86 га буюу 224.35 сая төгрөг бүхий газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар нэг удаа үнэгүй өмчлүүлж газрыг эдийн засгийн эргэлтэд оруулаад байна. Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн хүрээнд 2023 оны эхний хагас жилийн байдлаар Ерөө суманд нийт 2825 иргэнд 631.66 га газар өмчлүүлсэн байгаа бөгөөд газар өмчлөлийн явц 39.75 хувьтай явагдаж байна.	100%
67	4.14 Хүрээлэн буй орчны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах	Сумын хэмжээнд үйлдэгдэж буй хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор "БАЙГАЛИА ХАМГААЛТЯ"-2023 нэгдсэн арга хэмжээний Ерөө сумын төлөвлөгөөг 4 бүлэг 18 заалттайгаар Ерөө сумын Засаг даргаар батлуулж хэрэгжилтийг ханган ажиллалаа. 2023 оны 05 дугаар сарын 1-15-ны өдрүүдэд 2-р багийн нутаг дэвсгэр Харганат, Өлөнт, Могой, Цамхаг, Ялбаг гэх газруудад ашигт малтмал олборлох гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хяналт шалгалтын ажлыг зохион байгууллаа. Хяналт шалгалтаар Харганын ам Аниш гэх газарт хууль бус ашигт малтмал олборлосон байх шинжтэй зөрчил илэрснийг экологийн цагдаагийн алба шалгаж байна.	100%

68	4.15 Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагын судалгааг гаргаж тусгай зөвшөөрөлтэй болон хууль бусаар ашигласан талбайн нөхөн сэргээлтийг холбогдох байгууллагаар хяналт тавиулан гүйцэтгүүлэх	<p>“НӨХӨН СЭРГЭЭЛТ-2024” нэгдсэн арга хэмжээний хүрээнд: Техникийн нөхөн сэргээлтээр. Өлөнтөд: Монлид Трейд ХХК 6 га талбай Их өлөнтөд: “Ди Зэт -Элд -Ай” ХХК 3,5 га талбай, “Хонгорын орд” ХХК 3,5 га талбай, “Цемент шохой” ХХК 6 га талбай, “Чамин алт” ХХК 3 га талбай, “Сонор трейд” ХХК 3 га талбайд тус тус техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн. Бэрлэгийн цагаан тохой: “Бэрлэг майнинг” ХХК 1,68га талбай техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн Баянгол: “БТЕГ” ХХК 2,6 га талбай, “Инфинити спейс” ХХК 6,5га талбайд тус тус техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн. Биологийн нөхөн сэргээлт: Бэрлэгийн цагаан тохой: “Бэрлэг майнинг” ХХК 4,0га талбайд, “БТЕГ” ХХК Баянголд 4,6 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийсэн. Эрдэнэт үйлдвэрийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн нөхөн сэргээлт: “Тотал Идеал” ХХК-ны техникийн нөхөн сэргээлт хийсэн га талбай Өвөр залаат 53,36 га талбай, Гозон 109,84 га талбай, Угтаал гол 27,2 га талбай, Цамхаг 183 га талбай, Могой 56,4 га талбай нийт 429,1 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн. “Жинжий майнинг” ХХК-ны техникийн нөхөн сэргээлт хийсэн га талбай Харангат гэх газарт: 650 га талбай, Харангат 36,6 га талбай, Могой 118 га талбай нийт 800,7 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн. Оюу толгой ХХК-ны хөрөнгө оруулалтаар хийсэн нөхөн сэргээлт Ялбаг гэх газарт: “Бугант нандин” ХХК 140га талбай, “Үзэгдэх дэлгэрэх” ХХК 125,65 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн</p>	100%
69	4.16 Уул уурхайн үйл ажиллагаанд тавих иргэдийн хяналтыг сайжруулж, биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах ажлыг гүйцэтгүүлэх	<p>Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтээр: Их Өлөнтөд дараах аж ахуйн нэгжүүд нийт 19 га талбайд нөхөн сэргээлт хийсэн. Үүнд: 1.“ДИ ЗЭТ-ЭНД-АЙ” ХХК 3.5 га 2.“Хонгорын орд” ХХК 3.5 га 3.“Цемент шохой” ХХК 6 га 4.“Чамин алт” ХХК 3 га 5.“Сонор трейд” ХХК 3га. Биологийн нөхөн сэргээлтийг Бэрлэгийн цагаан тохойд “Бэрлэг майнинг” ХХК –нь 4 га талбай , “Болд төмөр Ерөө гол” ХХК 4,6га.</p>	100%
70	4.17 Уул уурхайн хайгуул, ашиглалтын үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээр хийлгэн, аймаг сумын хамтарсан комисст хүлээлгэн өгөх	<p>Уул уурхайн чиглэлээр 3 аж ахуйн нэгж 135.1 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн хийсэн байна. Жинжий майнинг ХХК- 66 га Үзэгт дэлгэрэх ХХК- 63.1 га Цемент шохой ТӨХК- 6 га</p>	30%
71	4.18 Бичил уурхай эрхлэгчдийн судалгааг хагас бүтэн жилээр шинэчлэн гаргах, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэн нөхөн сэргээлт хийлгэхэд хяналт тавих	<p>ЗАСГИЙН ГАЗРЫН 296 ДУГААР ТОГТООЛ ХЭРЭГЖЭЭГҮЙН УЛМААС 2023 ОНЫ БАЙДЛААР бичил уурхай эрхлэгч нар үйл ажиллагаа эрхлээгүй.</p>	100%
72	4.19 “НӨХӨН СЭРГЭЭЛТ-2024” нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд сумын хэмжээнд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах	<p>“НӨХӨН СЭРГЭЭЛТ-2024” нэгдсэн арга хэмжээний хүрээнд: Техникийн нөхөн сэргээлтээр. Өлөнтөд: Монлид Трейд ХХК 6 га талбай</p>	100%

		<p>Их өлөнтөд: “Ди Зэт -Элд -Ай” ХХК 3,5 га талбай, “Хонгорын орд” ХХК 3,5 га талбай, “Цемент шохой” ХХК 6 га талбай, “Чамин алт” ХХК 3 га талбай, “Сонор трейд” ХХК 3 га талбайд тус тус техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн.</p> <p>Бэрлэгийн цагаан тохой: “Бэрлэг майнинг” ХХК 1,68га талбай техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн</p> <p>Баянгол: “БТЕГ” ХХК 2,6 га талбай, “Инфинити спейс” ХХК 6,5га талбайд тус тус техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн.</p> <p>Биологийн нөхөн сэргээлт: Бэрлэгийн цагаан тохой:“Бэрлэг майнинг” ХХК 4,0га талбайд, “БТЕГ” ХХК Баянголд 4,6 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийсэн.</p> <p>Эрдэнэт үйлдвэрийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн нөхөн сэргээлт: “Тотал Идеал” ХХК-ны техникийн нөхөн сэргээлт хийсэн га талбай Өвөр залаат 53,36 га талбай, Гозон 109,84 га талбай, Угтаал гол 27,2 га талбай, Цамхаг 183 га талбай, Могой 56,4 га талбай нийт 429,1 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн.</p> <p>“Жинжий майнинг” ХХК-ны техникийн нөхөн сэргээлт хийсэн га талбай Харангат гэх газарт: 650 га талбай, Харангат 36,6 га талбай, Могой 118 га талбай нийт 800,7 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн.</p> <p>Оюу толгой ХХК-ны хөрөнгө оруулалтаар хийсэн нөхөн сэргээлт Ялбаг гэх газарт: “Бугант нандин” ХХК 140га талбай, “Үзэгдэх дэлгэрэх” ХХК 125,65 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн</p>	
73	4.20 Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, ашигт малтмалын боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлэх	Монголын төмөрлөгийн томоохон үйлдвэрлэгч “Болд Төмөр Ерөө гол” ХХК-нь тус сумын Буурагчин багийн нутаг дэвсгэр Баянгол хэсэгт үйл ажиллагаа явуулж жилдээ 3,0 сая тонн төмрийн хүдэр олборлож байна.	50%
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ:			
74	5.1 “Сэлэнгэ аймгийн аялал жуулчлалын хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг зохион байгуулах	<p>Ерөө сумын байгалийн үзэсгэлэнт болон дурсгалт газруудын жагсаалтад дараах газрууд хамрагдсан:</p> <ol style="list-style-type: none"> 1. Дааган дэлтэд Нийслэлийн туурь /сумын төвөөс 7кмт/ 2. Дарь эхийн хийдийн туурь /1712 онд байгуулагдаж байсан эртний хийд/ 3. Цагаан тохойд Сурын дов /сумын төвөөс / 4. Тулын тохойд загасчлах /сумын төвөөс 24 км/ 5. Ерөө голын эрэг дээр “Наран шарлагын газар” /сумын төвд/ 6. Ангийн отог Бүхлэй болон Бугантад байрладаг 7. Хонин нуга /загасчлах, байгалийн үзэсгэлэнт газрууд сонирхох/ 8. Ерөөгийн халуун рашаан эмчилгээ сувилал /сумын төвөөс 240 км/ 9. Минжийн рашаан /элэг цес, ходоодны эмчилгээний рашаан/ 10. Хонгорын боргилдог рашаан /ходоодны эмчилгээнд хэрэглэдэг сумын төвөөс 24км/ 11. МУ-ын Хөдөө аж ахуйн Ууган баатар Н.Бямбацогтын тракторын хөшөө /сумын төвд/ 12. Ялбагт ургадаг нэн ховор “Жодоо мод” /сумын төвөөс 150км/ 13. Гүн толгой /17-р зууны үед шавраар бурхан хийдэг байсан уул сумын төвөөс 15км/ 	50%

75	5.2 “Монголд зочлох жил”-ийн хүрээнд аялал жуулчлалын салбарын аж ахуйн нэгж, иргэдийн үйлчилгээний газрын гадна дотно тохижилт, өнгө үзэмж, үйлчилгээний чанарыг сайжруулах	Ерөө сумын Бугант тосгонд Бугант Нандин ХХК амралт, аялал жуулчлалын зориулалтаар амралтын баазыг шинээр байгуулаад байна.	50%
76	5.3 Нутгийн иргэдэд түшиглэсэн байгаль экологийн онцлог, түүх соёлын биет ба биет бус өв соёлыг хадгалсан аялал жуулчлалыг хөгжүүлэх	Ерөө сумын 2-р багийн нутагт орших Баянголын рашааны дэргэд иргэд буудаллах цэг бий болсон ба “БТЕГол” ХХКомпани нь засварлан тохижуулсан.	100%
77	5.4 Сумын аялал жуулчлалын нэгдсэн маршрут зэрэг холбогдох мэдээлэл бүхий самбар, амрах газрууд, замын уулзвар хэсгүүдэд таних тэмдгийг байрлуулан шинэчлэлт сайжруулалтыг тухайн бүр нь хийх	Энэ ажил хийгдээгүй байна.	0%
78	5.5 Аялагч, жуулчдын ихээр цуглардаг түүх дурсгалын болон байгалийн үзэсгэлэнт газар, цэцэрлэгт хүрээлэн, цогцолбор газар, жуулчны бааз, амралтын газруудын цэвэр бохир ус, био 00, агааржуулалтын систем зэргийг стандарт шаардлагад нийцүүлэх	Бугант нандин ХХК-ны байгуулсан амралтын бааз стандарт шаардлагад нийцсэн цэвэр, бохир усны системтэйгээр байгуулагдаж байна.	70%
79	5.6 Хог хаягдлын менежментийг сайжруулж түүх дурсгалын газар, байгалийн үзэсгэлэнт газрын хог хаягдалгүй эко орчныг бүрдүүлэх	Ерөө сумын залуусын нэгдэл “ЕРӨӨ ГОЛОО ХАЙРЛАЯ, ХАМГААЛТЯ”- уриатай голын эрэг дагуух хог хаягдлыг цэвэрлэх түүх аяныг өрнүүлж 1 портер хог, сэг зэм түүж төвлөрсөн хогийн цэгт хүргэж ажиллалаа.	90%
80	5.7 Аялал жуулчлалын төрлүүдийг шинээр бий болгон хөгжүүлж, дэд бүтцийг сайжруулж, жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх	Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор Ерөө сумын 1-р багийн нутаг Тойромт нуурт гэх газарт “Хойд бүсийн мөсөн сурын чуулга харваа” тэмцээнийг зохион байгууллаа. тус арга хэмжээнд 21 аймгийн 200 гаруй харваачид цэц мэргэнээ уралдууллаа.	70%
81	5.8 “Сэлэнгийн брэнд” бүтээгдэхүүн борлуулах сүлжээ цэгийг аялал жуулчлалын бүс, нийслэл болон бүс нутагт “Борлуулах цэг”-ийг бий болно.	Хэрэгжээгүй байна.	0%
82	5.9 Аялал жуулчлалын салбарын ажилчдыг чадавхжуулах сургалт, туршлага судлах аяллыг зохион байгуулах.	Хэрэгжээгүй байна.	0%
ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭ, ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ, ӨРХИЙН АЖ АХУЙГ ДЭМЖИХ, АЖИЛ АРГА ХЭМЖЭЭ:			
83	6.1 Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн норматив тогтоох тухай” А/272 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж, Төрийн үйлчилгээний нэгдсэн систем www.e-mongolia.mn-33D согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгалтын үйлчилгээг авах	Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хязгаарыг шинэчлэн тогтоох тухай аймгийн Засаг даргын А/02 дугаартай захирамжийг архины тусгай 10 аж ахуй нэгжид мэдэгдэн цагдаагийн байгууллагатай хамтран хяналт тавьж ажиллаж байна. Архи согтууруулах ундаа худалдаалдаг сумын төвд байрлалтай 7 аж ахуй нэгжид төлөвлөгөөт төлөвлөгөөт бус 3 удаагийн хяналт шалгалтыг хийж зөрчлийн арилгуулж заавар зөвлөгөө өгч ажиллаа. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн норматив тогтоох тухай” А/272 дугаар тушаалаар согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх цэгийн тоог аймаг, нийслэл, суманд 1000 хүн тутамд 4 хүртэл байхаар тогтоосныг баримтлан ажиллаж байна. Сумын хүн амын тоо 7257 тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж 18 байна. www.e-mongolia.mn- согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгалтын үйлчилгээг авах талаар Ерөө сумын ЗДТГ-ын мэдээ цахим сайт 3 удаа мэдээллээ.Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахаар тодорхойлолт авсан 6 аж ахуйн нэгжид e-mongolia-аас үйлчилгээ авах боломжтой талаар заавар зөвлөгөө өгч ажиллаа.	90%

84	6.2. Аймаг, сумын брэнд бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлэх, чанар, стандартад хяналт тавих	<p>Сумын брэнд талх аймгийн брэнд болгох сав баглааг сайжруулах зорилгоор халамжийн сангаас 10,000,000 төгрөгийн зээлийг олгосон. Цахир хоршоо нь зөгийн бал цэцгийн тоосонцор желли багц бүтээгдэхүүн, Примагултур ХХК-ийн цэцэг зөгийн бал 3 төрөл, Ургац Ерөө хоршооны шинэ ногооны сет, Ургац Ерөө, Цахир хоршооны даршилсан ногооны сет, Давсан урлал нийт 6 төрлийн сумын онцлох брэнд бүтээгдэхүүнээр бэлгийн багц гарган сумын иргэд болон үзэсгэлэн худалдаа, гэрээт байгууллагуудаар борлуулалт хийгдэж байна. Суманд Ерөөлтэй цагаан сар-2023 үзэсгэлэн худалдааг Ерөөд үйлдвэрлэсэн байраа бүтээгдэхүүнээр 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулж 14 иргэн 2 аж ахуй нэгж 52 төрлийн бараа бүтээгдэхүүнээр оролцож 6400000 төгрөгийн борлуулалт хийсэн байна.</p> <p>2023 онд Улс, аймаг, сумын 10 үзэсгэлэн худалдаанд давхардсан тоогоор 59 жижиг дунд бизнес эрхлэгч, аж ахуйн нэгж, хоршоод 158 төрлийн бүтээгдэхүүнээр оролцож 22,640,200 төгрөгийн орлого олсон байна.</p>	90%
85	6.3 Сумдын баялаг бүтээгчдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг сурталчлах, үзэсгэлэн худалдаа, экспо арга хэмжээг зохион байгуулах	<p>2023 онд Улс, аймгийн 10 үзэсгэлэн худалдаанд давхардсан тоогоор 59 жижиг дунд бизнес эрхлэгч, аж ахуйн нэгж, хоршоод 158 төрлийн бүтээгдэхүүнээр оролцож 22,640,200 төгрөгийн орлого олсон байна.</p> <p>Ерөөлтэй цагаан сар-2023, ургацын баяр, малчдын өдөрлөг арга хэмжээний үеэр 3 удаагийн үзэсгэлэн худалдааг сумандаа зохион байгуулж 24 иргэн 2 аж ахуй нэгж 72 төрлийн бараа бүтээгдэхүүнээр оролцож 10400000 төгрөгийн борлуулалт хийсэн байна.</p> <p>Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь Хөгжлийн шийдэл төрийн бус байгууллагын "Best" хөтөлбөртэй хамтран Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан болон Хоршоо хөгжүүлэх сангаас олгох хөнгөлөлттэй зээлийн мэдээллийг хүргэн, хүртээмжийг нэмэгдүүлэх, арга зүйн зөвлөгөөгөөр хангах талаарх сургалт, Төсөл бичих тухай 3 удаагийн сургалтыг сумандаа зохион байгуулж давхардсан тоогоор 75 иргэн, Хоршоо жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг хөгжүүлэх зорилгоор Хоршоо хөгжүүлэх сангаас 400000 төгрөгөөр "Цэнхэр харгиа ТББ"-аас "Харилцаа эерэг хандлага, маркетинг санхүү"-гийн сургалтыг сумандаа зохион байгуулж жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, хоршоод, худалдаа үйлчилгээний аж ахуйн нэгжийн 27 иргэн хамрагдлаа.</p>	100%
86	6.4 Орон нутгийн онцлог нөөцөд суурилсан чанар, стандартын шаардлага хангасан, зах зээлийн эрэлт хэрэгКцээнд нийцсэн үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх	<p>Хоршоо хөгжүүлэх сангийн сонгон шалгаруулалтаар сумын Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/137 дугаартай захирамжаар сум орон нутгийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийн дагуу Хөдөө, аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл-1, Эрчимжсэн мал аж ахуй-2, мод үржүүлэг-1, барилгын материал үйлдвэрлэл-1, өрхийн үйлдвэрлэл-2 буюу модон эдлэл-1, эсгий урлал-1 нийт 7 иргэн, жижиг дунд бизнес эрхлэгчдэд 70,000,000 төгрөгийн зээлийг хоршоо хөгжүүлэх сангаас журмын дагуу олгосон байна.</p> <p>Халамжийн сангаас 2023 онд малжуулах, авто засвар, жимсний мод тарих, гахай үржүүлэг, дахин боловсруулах бүтээгдэхүүн, цайны газрын чиглэлээр 6 иргэнд 29,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.</p> <p>Талх нарийн боовны үйлдвэрлэлийг сав баглаа, нэр төрлийг нэмэгдүүлэхээр халамжийн сангаас 10,000,000 төгрөгийн зээл олгосон. Хоршоо хөгжүүлэх сангаас модон эдлэл-7,000,000, эсгий урлал-10,000,000 төгрөгийн зээл олгон дэмжлэг үзүүлж ажиллаж байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор сумын хэмжээнд нийт 46 аж ахуйн нэгж, 86 иргэн 2 ахуйн үйлчилгээний төв үйл ажиллагаа явуулж байгааг дэмжин ажиллаж байна. Энэ онд шинээр цайны газар-1, гоо сайхан газар 1, оёдол-1, дугуй засвар авто угаалга-1 нийт 4 газар нэмэгдсэн байна.</p>	100%

87	6.5 Худалдаа үйлчилгээний салбарт ажиллагсдын дунд “Ажил мэргэжлийн уралдаан”, “Гадаад дотоодын туршлага судлах аялал”, сургалтуудыг зохион байгуулах	<p>Хөвсгөл аймгийн Мөрөн суманд зохион байгуулагдсан “ХҮСЭХҮЙН ЦОМ 2023”, Дэлхийн тогооч нарын өдрийг угтан сургууль, цэцэрлэгийн тогооч нарын ур чадварын улсын уралдаанд “Ургацын далай” тогоочдын ур чадварын тэмцээнд давхардсан тоогоор 5 тогооч оролцож К.Түмэнжаргал оролцож Сургуулийн хоолны төрөлд мөнгөн медаль, Орон нутгийн онцлог төрөлд хүрэл медаль хүртэж амжилттай оролцлоо, Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хоолны төрөлд Сэлэнгэ аймгийн Ерөө сумын ерөнхий боловсролын сургуулийн ахлах тогооч К.Түмэнжаргал “Тусгай” байр эзэллээ.</p> <p>Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидаан согтуурахтай тэмцэх тухай хууль, зөрчлийн хууль, Монгол Улсын хяналтын камерын стандарт, “Харилцаа эерэг хандлага, маркетинг санхүү”- гийн сургалт суманд зохион байгуулж жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, хоршоод, худалдаа үйлчилгээний аж ахуйн нэгж, давхардсан тоогоор 38 иргэн хамрагдлаа.</p> <p>Хүнсний аюулгүй байдлыг хангах, нийтийг хамарсан хоол хүнсээр дамжих, өвчин гарахаас урьдчилан сэргийлэх, бараа бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах зорилгоор сумын засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/10 дугаартай захирамжийн дагуу 3 удаа давхардсан тоогоор суманд үйл ажиллагаа явуулдаг худалдаа үйлчилгээний 27 аж ахуй нэгж байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгууллаа. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулж, заавар зөвлөмж, хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллаа. Хүнсний чанарын стандартын талаарх мэдээллийг цахимаар 12 удаа хүргэж ажилласан байна. Мөн аймгийн Засаг даргын захирамж, аймгийн хүнс хөдөө аж ахуйн газрын зөвлөмж, аймгийн эрүүл мэндийн төвийн байцаагчийн зөвлөмж, зөвлөгөөг 4 удаа давхардсан тоогоор 51 аж ахуй нэгж иргэдэд хүргэсэн</p>	100%
88	6.6 Төрийн худалдан авалтад дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх ажлыг удирдан, зохион байгуулах	<p>Ерөө сумын 2023 онд хийгдэх хөрөнгө оруулалтын ажлыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 08-р сарын 16-ны өдрийн 115 тоот тогтоолоор Төрийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 50 төрлийн ажил үйлчилгээг 6,165,4 сая төгрөгийн өртөгтэйгөөр хийгдэхээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд оруулан шалгаруулалт зохион байгуулж ажилласнаас Орон нутаг Хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Малын банн хийх 20000,0, Малын тарилгын суурин төмөр хашаа барих 20000,0 төсөвтэй ажилд Ерөө сумын Таван-Эрдэнэ вэт ХХК, Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаас “Ногоон байгууламж нэмэгдүүлэх” ажилд 20000,0 төгрөгийн төсөвтэй тендерт Ерөө сумын “Төгөлдөр Ерөө” ОНӨААТҮГазар шалгарч 100% гүйцэтгэсэн.</p>	100%
89	6.7 Хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийг сайжруулах	<p>“Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлтэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын дагуу 2011-2022 оны үйл ажиллагааны тайланг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж 2023 оны төсвийг батлуулан батлуулан ажиллалаа.</p> <p>Хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийг сайжруулах олон нийтэд ил тод мэдээлэх зорилгоор Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгох товыг 2023 оны 03 дугаар сарын 13-наас-04 дүгээр сарын 13-ны хооронд зарлаж нийтэд цахимаар, мэдээллийн самбаруудаар дамжуулан хүргэж 18 иргэн, аж ахуй нэгж, хоршооны төсөл ирсэн байна. Хоршоо хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах хороо хуралдаж 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр төслийг хамгаалуулж дундаж оноогоор эрэмбэлэн Засаг даргад хүргүүлж ажиллаа. Засаг даргын захирамжаар 7 иргэн жижиг, дунд бизнес эрхлэгчдэд 13 ажлын байр бий болгох зорилгоор 70,000,000 төгрөгийн зээлийг олгож нийтэд ЗДТГ-ын мэдээ цахим сайтад, ЗДТГ-ын мэдээллийн самбарт мэдээллээ.</p>	100%

		<p>Хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийг сайжруулах зорилгоор зээлдэгчидтэй утсаар сар бүр, биечлэн 4 удаа 46 зээлдэгчдтэй уулзаж нөхцөл байдалтай танилцан зээлээ хуваарийн дагуу төлөх талаар сануулж хяналтын хуудас хөтлөн ажиллаа. Мөн хоршоо хөгжүүлэх сангийн хяналт тавих орон тооны бус зөвлөл 2 удаа хуралдаж чанаргүй зээлийн ангилалд орсон 11 иргэнд мэдэгдэх хуудас өгч, энэ жилийн олголт 6 зээлдэгчдийн төсөл, зээл олголттой танилцаж зээлийг зориулалтын дагуу ашигласан эсэхэд хяналт шалгалт хийж ажиллаа. Энэ онд 5 зээлдэгч зээлээ бүрэн барагдуулсан. 12 сарын байдлаар сангийн 100130255401 тоот дансанд төгрөгийн 97,237,860 эргэн төлөлт орсон байна.</p> <p>Засаг даргын Тамгын газрын мэдээ цахим хуудсаар хоршоо хөгжүүлэх сан, хүнс жижиг дунд үйлдвэрлэл, стандарт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар 36 мэдээллийг оруулсан байна.</p> <p>Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа, сангийн хөрөнгийн зарцуулалт, олгосон зээлийн талаарх мэдээллийг нийтэд ил тод болгож, дүн шинжилгээ хийх боломжийг олон нийтэд олгож зээлийн мэдээллийг цахим мэдээлж байна.</p> <p>Жижиг, дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдэд орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлэх зорилгоор Монгол улсын Засгийн газраас зохион байгуулсан “Бэст” хөтөлбөртэй хамтран Хоршоо хөгжүүлэх сангийн журам, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн төсөл хөтөлбөрт хэрхэн хамрагдах, төсөл бичихэд анхаарах асуудлын талаарх 3 удаагийн сургалтад давхардсан тоогоор сумын 75 иргэд, жижиг дунд бизнес эрхлэгч, хоршоодыг хамруулж үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна.</p> <p>Хоршоо жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг хөгжүүлэх зорилгоор Хоршоо хөгжүүлэх сангаас 400000 төгрөгөөр “Цэнхэр харгиа ТББ”-аас “Харилцаа эерэг хандлага, маркетинг санхүү”-гийн сургалтыг сумандаа зохион байгуулж жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, хоршоод, худалдаа үйлчилгээний аж ахуйн нэгжийн 27 иргэн хамрагдлаа.</p>	
90	6.8 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг хоршооны бүтцэд тулгуурлан боловсронгуй болгож, загвар хоршоодыг байгуулах	<p>Суманд бүртгэлтэй 10 хоршоо байна. 8 хоршоо нь мод үржүүлэг, хүнсний ногоо тариалах, сүү сүүн бүтээгдэхүүн, мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Энэ жил Өгөөж ерөө сүү хоршоо шинээр байгуулагдаж НҮБ-ийн Хүнс хөдөө аж ахуйн байгууллагаас 140,000,000 төгрөгийн өртөг бүхий сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах тоног төхөөрөмжийг уг хоршоонд олгож үйл ажиллагаа эхлүүлэхэд бэлэн болоод байна.</p>	70%
91	6.9 “Монголд зочлох жил”-ийн хүрээнд худалдаа үйлчилгээний салбарын аж ахуйн нэгж, иргэдийг үйлчилгээний газрын гадна дотно тохижилт, өнгө үзэмж, үйлчилгээний чанарыг сайжруулах	<p>Худалдаа үйлчилгээний аж ахуй нэгж иргэдэд сумын 100 жил угтаж гаднах өнгө үзэмжээ сайжруулах уралдаан уриалга гаргаж 1 нийтийн хоолны салбар хаяг, гадна засвар, дотор тохижилт, бохир усаа бүрэн шийдсэн, 2 дэлгүүр гадна хаягаа шинэчилж, 1 дэлгүүр дотор засвар, 1 дэлгүүр гадна өнгө үзэмжээ сайжруулж пассат хийж нийт 5 аж ахуй нэгж өнгө үзэмжээ сайжруулсан байна. 3 дэлгүүр хог төрөлжүүлэн хийх хогийн сав байршуулсан байна.</p>	70%
92	6.10 Арьс шир, ноос, ноолуурын анхан шатны боловсруулах, үйлдвэр цех байгуулах иргэд аж ахуй нэгжид дэмжлэг үзүүлэх	<p>Арьс шир боловсруулах тоног төхөөрөмжийг зээлээр авах тухай мэдээллийг 2 удаа цахимаар мэдээлж ажиллаа. Суманд арьс шир боловсруулах 15,7 сая төгрөгийн иж бүрэн тоног төхөөрөмжийг Жижиг дунд үйлдвэрлэлийн газраас авсан.</p>	70%
93	6.11 Орон нутгийн бизнес эрхлэгчдийг чадавхжуулах, туршлага судлуулах арга хэмжээг зохион байгуулах	<p>“Бичил, жижиг, дунд үйлчилгээ эрхлэгчдэд санхүүгийн мэдлэг дээшлүүлэх” бичил, жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдэд санхүүгийн болон бизнесийн мэдлэгийг нэмэгдүүлэх, чадавхжуулах сургалтад Ерөө сумыг төлөөлж 1 бизнес эрхлэгч оролцсон байна.</p> <p>Монголын хүнсчидийн холбоо, АНУ-ийн Олон Улсын Хөгжлийн Агентлагийн санхүүжилттэй, Хөгжлийн Шийдэл ТББ-ийн хэрэгжүүлж буй BEST хөтөлбөртэй хамтран “Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн зохистой дадал”-ын сургалтад 4 иргэн, аж ахуй нэгж хоршоо хамрагдсан байна.</p>	100%

		<p>Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь Хөгжлийн шийдэл төрийн бус байгууллагын “Best” хөтөлбөртэй хамтран Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан болон Хоршоо хөгжүүлэх сангаас олгох хөнгөлөлттэй зээлийн мэдээллийг хүргэн, хүртээмжийг нэмэгдүүлэх, арга зүйн зөвлөгөөгөөр хангах талаарх сургалт, Төсөл бичих тухай 3 удаагийн сургалтыг сумандаа зохион байгуулж давхардсан тоогоор 75 иргэн, бизнес эрхлэгчид хамрагдсан байна.</p> <p>Хоршоо жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг хөгжүүлэх зорилгоор Хоршоо хөгжүүлэх сангаас 400000 төгрөгөөр “Цэнхэр харгиа ТББ”-аас “Харилцаа эерэг хандлага, маркетинг санхүү”- гийн сургалтыг сумандаа зохион байгуулж жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, хоршоод, худалдаа үйлчилгээний аж ахуйн нэгжийн 27 иргэн хамрагдлаа.</p>	
94	6.12 “Сум бүрт нэг үйлдвэр үйлчилгээ хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг тооцох	<p>Талх нарийн боовны үйлдвэрлэлийг сав баглаа, нэр төрлийг нэмэгдүүлэхээр халамжийн сангаас 10,000,000 төгрөгийн зээл олгосон. Хоршоо хөгжүүлэх сангаас модон эдлэл-7,000,000, эсгий урлал-10,000,000 төгрөгийн зээл олгон дэмжлэг үзүүлж ажиллаж байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор сумын хэмжээнд нийт 46 аж ахуйн нэгж, 86 иргэн 2 ахуйн үйлчилгээний төв үйл ажиллагаа явуулж байгааг дэмжин ажиллаж байна.</p> <p>Энэ онд шинээр цайны газар-1, гоо сайхан газар 1, оёдол-1, дугуй засвар авто угаалга-1 нийт 4 газар нэмэгдсэн байна</p> <p>Жижиг дунд бизнес эрхлэгчдийн борлуулалт марктенг, харилцаа хандлага, хоршооны хөгжлийн талаарх сургалтыг 2023 оны 11 дүгээр сарын 24 –ны өдөр суманд зохион байгуулж 27 иргэн, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, хоршоо, худалдаа үйлчилгээний аж ахуй нэгж хамрагдсан байна.</p>	100%
95	6.13 Орон нутгийн хүн амыг хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнээр хангах, нөөц бүрдүүлэх	<p>3 хүнсний дэлгүүртэй хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнээр хангах гэрээ байгуулсан. Сэлэнгэ аймгийн Хүнс Хөдөө аж ахуйн газарт долоо хоног бүрийн 7 хоногийн 1 дахь өдөр болгон хүнсний нөөцийн судалгааг гарган хүргүүлж байна. Сумын хэмжээнд хүнсний нөөц хангалттай, хомсдол үүссэн нөхцөл гараагүй байна.</p>	90%
96	6.14 Ашиглагдахгүй байгаа барилга, байгууламжийг хоршоодод гэрээгээр ашиглуулах	<p>Засаг даргын Тамгын газрын өмчид бүртгэлтэй хуучин ТМС-ийн 100 хүүхдийн гуанзны 225 м2 байрыг “Өгөөж Ерөө сүү” хоршоонд гэрээгээр ашиглуулж байна.</p>	90%
97	6.15 Төвөөс алслагдсан баг, тосгонд явуулын ахуйн үйлчилгээг хүргэх арга хэмжээг зохион байгуулах	<p>Хүлээж биш хүрч үйлчилье “Таныг сонсьё” хүрээнд ахуй үйлчилгээг хүргэх зорилгоор төвөөс алслагдсан Тавин багийн 5 чиглэлд 12 өрхийн 24 иргэдэд үсчин Х.Золзаяа 400,000 төгрөгийн үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлсэн байна.</p>	70%
98	6.16 “Хөх сав, канистргүй сум” хөдөлгөөнийг эрчимжүүлэн сав баглаа боодлын дотоодын үйлдвэрлэлийг дэмжин хүнсний зориулалтын бус хуванцар савны хор хөнөөлийг сурталчлах	<p>Хүнсний зориулалтын бус сав буюу хуванцар савнаас татгалзъя уриа нь дор сар бүр Дархан уул аймгийн зориулалтын сав суулга зардаг иргэн А.Ашид сар бүрийн 1 эсвэл 20 өдөр ирж 54 нэр төрлийн хүнсний зориулалтын сав суулга Ерөө сумын иргэдэд борлуулж 500,000-1,500,000 орлого олж байна. Мөн иргэн А.Ашидтай хамтран, “Хуванцар савнаас татгалзъя” хүнсний зориулалтын сав, суулга хэрэглэе уриа нь дор үзэсгэлэн худалдаа 2 удаа зохион байгуулан 82 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн худалдаалж 54 төрлийн 5,470,000 төгрөгийн борлуулалтыг сумын иргэдэд хийсэн байна. Хуванцар савны хор хөнөөл, зориулалтын сав баглаа хэрэглэх ажлыг сурталчилж 5 төрлийн мэдээ мэдээллийг 6 байгууллын зурагт самбар мэдээ мэдээллийн буланд байршуулан Засаг даргын Тамгын газрын мэдээ цахим сайтад 4 удаа мэдээлж ажиллаа.</p> <p>Малчдын өдөрлөг арга хэмжээний үеэр хүнс, хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, худалдаа, засвар үйлчилгээний үндэсний үйлдвэрлэгч “Чиглэл” ХХК нь хуванцар савыг хэрэглээнээс гаргаж, зэвэрдэггүй гангаар үйлдвэрлэсэн шингэн хүнсний бүтээгдэхүүн хадгалах савны хэрэглээг бий болгох талаарх материалыг</p>	100%

		36 малчид, “Бест хөгжлийн шийдэл ТББ”-аас “Цэнхэр харгиа ТББ”-аас “Харилцаа эерэг хандлага, маркетинг санхүү”- гийн сургалтад хамрагдсан 27 иргэн, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, хоршоод, худалдаа үйлчилгээний аж ахуйн нэгжүүдэд хүргэж ажилласан байна. Мөн Сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төвийн 6 байгууллагад хүргэж ажиллаа.	
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САЛБАРЫН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ:			
99	7.1 Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээг сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Сэлэнгэ аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлтэй уялдуулан төлөвлөх	Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээг сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Сэлэнгэ аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлтэй уялдуулан Ерөө сумын 2023 онд Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 08-р сарын 16-ны өдрийн 115 тоот тогтоолоор Төрийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 50 төрлийн ажил үйлчилгээг 6112636.6 мянган төгрөгийн өртөгтэйгээр хийгдэхээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд оруулан Монгол Улсын Сангийн ямаар батлуулан ажилласнаас Бугант тосгонд 235 сая төгрөгийн өртөгтэй 1,2км хайрган хучилттай автозам, 500 сая төгрөгийн өртөгтэй 1,2км замыг асфальтаар хучиж, 197 сая төгрөгийн өртөгтэй 96 ширхэг гэрэлтүүлэг хийгдсэн бол Ерөө суманд 1.040.385.043 төгрөгийн өртөгтэй 1.9 м замыг асфальтаар хучиж, 2.9 км дугуйн замыг шинээр барьж, 140 сая төгрөгийн өртөгтэй Сургуулийн авто зогсоол, ЭМТ-өөс гангын зам хүртэлх 430м хайрган хучилттай авто замыг шинээр барьж, цэцэрлэгийн хуучин авто засварласан.	100%
100	7.2 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээг “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын дагуу сумын иргэдийн 80-аас доошгүй хувийн саналд үндэслэн төлөвлөх, төлөвлөлт болон гүйцэтгэлийг Орон нутгийн удирдлагын системд бүрэн байршуулах	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын 1 279 224 200 төгрөгийн 12 төсөл арга хэмжээнээс 12 ажил зарлагдаж, тендер шалгаруулалт хийгдэн 11 ажилд гэрээ байгуулан 100 хувийн гүйцэтгэлээр хүлээн авч үүнээс 1 ажилд оролцогч байхгүй байна.	90%
101	7.3 2024 оны Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний саналыг Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалын дагуу боловсруулан 2023 оны 05 дугаар сарын 15-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлэх	Ерөө суманд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хийгдэх 40,219,984,724.20 төгрөгийн зураг, төсөвтэй Ерөө Соёлын төв шинээр барих, Засаг даргын тамгын байр шинээр барих, Ахмадын сувилал, Бугант хүртэлх 28 км хатуу хучилттай зам тавих, Бугант Сургууль, Ерөө ЭМТөвийн барилгын өргөтгөл барих, Бугант тосгоны нэгдсэн бохирын шугам шинэчлэх 7 ажлын саналыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст хүргүүлсэн.	50%
102	7.4 2023-2024 оны төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний гүйцэтгэлд ашиглагчийн хяналт тавьж, гүйцэтгэл, явцын талаарх мэдээллийг аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлэх	Ерөө суманд 2024 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Соёлын төв шинээр барих, Бугант хүртэлх 27,8 км хатуу хучилттай зам тавих, Ерөө ЭМТөвийн барилгын өргөтгөл барих 3 ажлын төсөв суусан.	100%
103	7.5 Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсвийн хөрөнгөөс авсан дотоодод үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний тайлан, төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын ажилд сумын иргэдийг ажлын байраар хангасан болон өрхийн үйлдвэрлэгчдээс бараа, бүтээгдэхүүнийг худалдан авсан талаарх тайланг нэгтгэн ирүүлэх	2023 онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнээс Мал угаалгын банн, Малын тарилгын суурин төмөр хашаа барих, ЭМТ-ын монтаж солих, Цагдаагийн кабоны завсар зэрэг ажлуудыг орон нутгийн “Төгөлдөр Ерөө” ОНӨААҮГазар, “Таван эрдэнэ бэт”ХХКомпаниар гүйцэтгүүллээ. Эдгээр байгууллагуудад орон нутгийн 8 иргэн ажиллаж байна.	90%
104	7.6 Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын хүрээнд бий болсон хөрөнгийг бүртгэлжүүлж, өмчид	“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бий болсон бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг үндсэн хөрөнгөд бүртгүүлэхээр сумын Засаг даргын захирамжаар баталгаажуулан /ЗДТГ- 3 ЕБС-	70%

	бүртгэн, ашиглагч байгууллагыг тодорхойлон, хөрөнгө эзэнгүйдэх асуудлыг таслан зогсоох	1, Ерөө цэцэрлэг-1, Бугант 2-р цэцэрлэг-1, Ерөө цагдаагийн хэсэг -2/ бүртгэлжүүлэн ажиллаж байна.	
105	7.7 Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж, гүйцэтгэл удааширсан, зогсонги байдалд орсон төсөл арга хэмжээг эрчимжүүлэх чиглэлээр ажил арга хэмжээ зохион байгуулж ажиллах	2022 онд Орон нутгийн Хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Үржлийн төв байгуулах гүйцэтгэгч байгууллага болох “Ти си кей эйч” ХХК үлдсэн ажлыг гүйцэтгэн 100 хувийн гүйцэтгэлтэй дуусгаж сумын комисст хүлээлгэн өгсөн.	100%
106	7.8 Төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг, худалдан авах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, худалдан авах ажиллагааны чиглэлээр сургалтад албан хаагчдыг хамруулж чадавхжуулахад анхаарч ажиллах	Төсвийн болон орон нутаг хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын тайланг хагас жилээр гарган иргэдэд ЗДТГазрын мэдээ, tender.gov.mn цахим хаягаар нээлттэй танилцуулан ажиллаж байна. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн С.Чулуунцэцэг “Тогтвортой амьжиргаа-3” төслийн зохицуулагч Д.Цэнд-Аюуш, сумын ЗДТГазартай хамтран “Малын тоо толгойн албан татварын орлогыг Орон нутгийн хөгжлийн санд хэрхэн төвлөрүүлэх, зарцуулах, тайлагнах” чиглэлээр ЗДТГ-ын албан хаагчид, 1, 2, 3-р багийн малчдын төлөөлөл оролцуулан сургалт зохион байгууллаа.	70%
ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ:			
107	8.1 Сумын хот төлөвлөлт, газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, төлөвлөлтийн дагуу бүтээн байгуулалтын ажлыг хэрэгжүүлэх	Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд “Сумын хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийх” ажилд 198 сая төгрөгөөр “Ланд овнер” ХХК-тай Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан гүйцэтгэл 70 хувьтай байна.	70%
108	8.2 “Амины орон сууц” арга хэмжээг хэрэгжүүлэх	Хэрэгжээгүй байна.	0%
109	8.3 Төв суурин газрын ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх ажлыг иргэд, аж ахуйн нэгжийн санаачилга оролцоотойгоор хийх	2023 оны 08 дугаар сарын 16 ны өдрийн ИТХ-ын 115 дугаар тогтоолын дагуу Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх “Ухаалаг худаг/ усны төв” барих ажилд 125 сая төгрөгөөр “Баялаг говь” ХХК-тай гэрээ байгуулан 100 хувь гүйцэтгэсэн байна.	100%
110	8.4 Спорт цогцолборын барилга, залуучуудын чөлөөт цаг өнгөрөөх талбай, цэцэрлэгт хүрээлэн байгуулах	Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлын хөрөнгө оруулалтаар “Ногоон байгууламж нэмэгдүүлэх” 20,000,000 төгрөгийн тендерт Төгөлдөр Ерөө ОНӨТҮАҮГазар шалгарч Трактортай толгойн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, Гэрэлт гудамжны ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлт хийх ажлыг 100 хувь гүйцэтгэсэн.	100%
111	8.5 “Хашаандаа сайхан амьдарцгаая”, “Сумандаа сайхан амьдаръя” аяныг өрнүүлэх үр дүнг тооцох	Ерөө сум үүсгэн байгуулагдсаны 100 жилийн ойн баярыг угтан сумын Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/112 тоот захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төр төсвийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн дунд амьдрах ая тухтай орчныг бүрдүүлэх, тохижилт ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, шинэ санал санаачилгыг дэмжих үйл ажиллагааг идэвхжүүлэх, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор “Тохижилт, ногоон байгууламжийн аяны хүрээнд болзолт уралдаан”-ыг зарлаж шалгаруулалтыг Шинэ жилийн нэгдсэн арга хэмжээний үеэр гардуулна.	100%
112	8.6 Гэр хорооллыг инженерийн шугам, дэд бүтцэд холбох	Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 06 дугаар сарын 01 өдрийн 2021 оны 06 дугаар сарын 01 өдрийн 161 дүгээр тогтоол “Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж” төсөл, арга хэмжээнд 19 аймгийн 59 сумын төвд Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжаар санхүүжүүлэн хэрэгжүүлнэ гэж заасан. Сэлэнгэ аймгаас Ерөө сум сонгогдож “Дөрвөн гүн” ХХК-иар сумын инженерийн дэд бүтцийн хангамжийн зураг төсөв хийлгэж гүйцэтгэл 80 хувь байна.	90%
113	8.7 Эрүүл мэндийн төвүүдийн засвар үйлчилгээ, өргөтгөлийн барилгын ажлыг хийж, хүчин чадлыг нэмэгдүүлж шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	2024 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажил арга хэмжээнд суусан.	100%

11	8.8 Ерөө-Бугант чиглэлийн хатуу хучилттай 74 км авто замыг барьж байгуулах, холбогдох байгууллагад санал хүргүүлж, шийдвэрлүүлж авто зам барих ажлыг эхлүүлэх	2024 онд хийгдэх 36 тэрбум төгрөгийн өртөгтэй 27,5 км замын хөрөнгө оруулалт Улсын төсөвт суусан.	90%
115	8.9 “Сумын хөгжил, Инженерийн дэд бүтцийн хангамж” төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх	Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 06 дугаар сарын 01 өдрийн 161 дүгээр тогтоол “Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж” төсөл, арга хэмжээнд 19 аймгийн 59 сумын төвд Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжаар санхүүжүүлэн хэрэгжүүлнэ гэж заасан. Сэлэнгэ аймгаас Ерөө сум сонгогдож “Дөрвөн гүн”ХХК-иар сумын инженерийн дэд бүтцийн хангамжийн зураг төсөв хийлгэж гүйцэтгэл 80 хувь байна.	30%
116	8.10 Зам, барилга, байгууламж, инженерийн шугам сүлжээг шинээр барьж байгуулах, өргөтгөл, шинэчлэлт хийх тохиолдолд инженер геологийн судалгаа, дүгнэлт, хангагч байгууллагаас олгосон техникийн нөхцөлийг үндэслэн хийлгэж, эрүүл ахуйн болон шугам сүлжээний хамгаалалтын зурвас газрыг тогтоосон захирамж шийдвэрийг гаргасан байх.	Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 08-р сарын 16-ны өдрийн 115 тоот тогтоолоор Төрийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 50 төрлийн ажил үйлчилгээг 6112636.6 мянган төгрөгийн өртөгтэйгээр хийгдэхээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд оруулан Монгол Улсын Сангийн ямааар батлуулан ажилласнаас Бугант тосгонд 235 сая төгрөгийн өртөгтэй 1,2км хайрган хучилттай автозам, 500 сая төгрөгийн өртөгтэй 1,2км замыг асфальтаар хучиж, 197 сая төгрөгийн өртөгтэй 96 ширхэг гэрэлтүүлэг хийгдсэн бол Ерөө суманд 1.040.385.043 төгрөгийн өртөгтэй 1.9 м замыг асфальтаар хучиж, 2.9 км дугуйн замыг шинээр барьж, 140 сая төгрөгийн өртөгтэй Сургуулийн авто зогсоол, ЭМТ-өөс гангын зам хүртэлх 430м хайрган хучилттай авто замыг шинээр барьж, цэцэрлэгийн хуучин авто засварласан.	100%
117	8.11 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал үүссэн нөхцөлд инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн хэвийн ажиллагааг хангах, засвар, арчлалтын ажлыг шуурхай гүйцэтгэх зорилгоор материал, тоног төхөөрөмжийн нөөцийг бүрдүүлэх, иргэдийн аюулгүй байдлыг хангах, анхааруулах мэдээлэл, тэмдэглэгээг хийж бэлтгэсэн байх.	Ерөө суманд дулааны уурын зуухны үйл ажиллагааг МОНЖИТ ХХК, Төгөлдөр Ерөө ОНӨААТҮГазар, Буган өндөр ХХК гүйцэтгэж байна. Эдгээр байгууллагууд гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал үүссэн нөхцөлд дулааны инженерийн шугам сүлжээг хэвийн ажиллуулах эрчим хүчний нөөц үүсгүүрийг бэлэн байдалд ажиллуулж байна.	70%
118	8.12 Орон нутгийн болон хот хоорондын нийтийн зорчигч тээвэр, шуудан тээврийн үйлчилгээг журмын дагуу зохион байгуулж цагийн хуваарь, маршрутыг мөрдүүлэх.	Орон нутгийн болон хот хоорондын нийтийн зорчигч тээвэрийн үйлчилгээг “Ерөө буурагчин” ХХК журмын дагуу зохион байгуулж цагийн хуваарь, маршрутыг мөрдүүлэн ажиллаж байна.	100%
119	8.13 Шаардлага хангахгүй, ашиглагдахгүй болсон эрчим хүч, холбооны агаарын шугамуудыг буулгах, гудамж талбайг хаяжуулах, суурилуулсан хяналтын камерын ашиглалт, хамгаалалтыг сайжруулах.	Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Бугант тосгонд гэрэлтүүлэг нэмэгдүүлэх ажилд 195 сая төгрөгөөр “Арвилах”ХХК Бугант тосгоны Өлөнт, Чулуутын хэсгээр 96 гэрэлтүүлэг суурьлуулсан.	100%
БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН АЖИЛ АРГА ХЭМЖЭЭ:			
120	9.1 Бүх хүүхдийг сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын үйлчилгээнд заавал хамруулахын зэрэгцээ малчдын болон ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүдийг тэгш хамруулах, хөгжлийг дэмжих	Сумын хэмжээнд нийт 350 хүүхэдтэй үүнээс ердийн сургалтаар 251 хүүхэд хувилбарт сургалтад 47 хүүхэд, өөр сум аймагт 20 хүүхэд хамрагдаж байна. Хамран сургалт 92 хувьтай. Малчдын 17 хүүхэд суралцаж, хувилбарт сургалтын хүүхдүүд цагийн сургалтад 14 хоног тутамд хамрагдсан. 5 настай 93 хүүхдээс ердийн сургалтаар 73 хүүхэд, хувилбарт сургалтаар 10 хүүхэд суралцаж, өөр аймаг суманд 10 суралцаж байна. Жил бүр хувилбарт сургалтыг зохион байгуулж, 6 сард малчдын хотонд 1-2 сарын сургалтыг явуулж 30-50 хүүхдэд СӨБ олгож байна. 2 багийн дарга нар, Хүүхэд хамгааллын хамтарсан багтай хамтран ажиллаж байна	100%

121	9.2 Хичээл сургалтын хоцрогдлыг нөхөж, сургалтын чанарыг дээшлүүлэн, элсэлтийн ерөнхий шалгалтын хэмжээст онооны дунджийг ахиулах	<p>2023 оны ЭЕШ-нд 12 а, б ангийн 33 сурагч 9 хичээлээр 106 шалгалт өгөхөөр бүртгүүлсэн бөгөөд сурагчид 100 хувь мэргэжлээ сонгосон байна.</p> <p>12-р ангийн сурагчид 2022 оны 11-р сараас IT компанийн ЭЕШ-800 цахим давтлагад 2023 оны 02-р сарын 06-наас эхлэн хуваарийн дагуу танхимын давтлагад хамрагдсан.</p> <p>ЭЕШ-ын 9 хичээлээр 2 удаагийн мини ЭЕШ-ыг зохион байгуулсан ба эхний шалгалтад давхардсан тоогоор 105 сурагч оролцож 52.7 хувийн гүйцэтгэлтэй байсан бол 2 дахь удаагийн шалгалтаар 102 сурагч 9 хичээлээр оролцож гүйцэтгэл 56.5 хувьтай дүгнэгдэж 3.8 хувиар ахисан байна.</p>	100%
122	9.3 “Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлж, чадварлаг багш нарыг урамшуулах бодлого баримтлах	<p>Багш нарыг ажлын байран дээрээ хөгжих боломжоор хангаж, сурч боловсроход дэмжлэг үзүүлэх зорилгоор “Хичээл сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хэрэгжүүлэх арга зүй” сургалтыг 12 судлагдахуунаар БМДИ-ээс цахимаар зохион байгуулсан сургалтад 61, APLUS цахим сургалт /132 төрөл/-д 539, ажлын байран дахь сургалтад 499, бүсийн хэмжээний 9 сургалтад 67, аймгийн хэмжээний 10 сургалтад 115, үндэсний хэмжээний 3 сургалтад 68 нийт 37 сургалтад давхардсан тоогоор 1349 багш ажилчид хамруулсан.</p>	100%
123	9.4 Сургалтын байгууллагыг ухаалаг төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлэх	<p>Ерөнхий Боловсролын Сургууль:</p> <ul style="list-style-type: none"> • УИХ-ын гишүүн Ч.Ундрамын дэмжлэгээр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Синапс ХХК” нь суралцагчдын хичээлийн агуулгаар судалсан шинжлэх ухааны мэдлэгээ чадвар дадал болгох, амьдралд бүтээлчээр хэрэгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж 49 нэр төрлийн 13.801.370 төгрөгийн эрэгтэй эмэгтэй Технологийн хичээлийн сургалтын хэрэглэгдэхүүн, 30 нэр төрлийн 9.758.100 төгрөгийн Физикийн хичээлийн сургалтын хэрэглэгдэхүүн, 125 нэр төрлийн 25.057.780 төгрөгийн Химийн хичээлийн сургалтын хэрэглэгдэхүүн тус тус нийлүүлснийг үндсэн хөрөнгөд бүртгэж мэргэжлийн багшид хүлээлгэн өгч сургалтад ашиглаж байна. • Мөн УИХ-ын гишүүн Ж.Эрдэнэбатын дэмжлэгээр БШУЯ-аас 5 нэр төрлийн 6.148.520 төгрөгийн Хөгжмийн зэмсэг нийлүүлснийг үндсэн хөрөнгөд бүртгэн мэргэжлийн багшид хариуцуулан сургалтад ашиглаж байна. <p>Цэцэрлэг:</p> <ul style="list-style-type: none"> - Сэлэнгэ аймгийн Боловсролын ерөнхий газраас сургалтын хэрэгцээнд 3.554.798 (Гурван сая таван зуун тавин дөрвөн мянга долоон зуун ерэн найм) төгрөгийн төсөвт өртөг бүхий суурин компьютер - “Мон жим ХХК”- ны хөрөнгө оруулалтаар 2.000.000 төгрөгийн хөшиг тюл. - “БТЕГ”-аас 16.147.444.20 төгрөгийн өртөг бүхий хүүхдийн ширээ, тавиур морин хуур, ус цэвэршүүлэгч, аяга таваг угаагч автомат машин, гурил зуурагч, шарах шүүгээ, багш ширээ - Сум хөгжлийн сангийн санхүүжилтээр 20.000 сая төгрөгийн өртөг бүхий 8 бүлгийн 137 м хивсэнцэр - БШУЯамнаас 220.000 төгрөгийн өртөг бүхий хэт ягаан туяаны кварц - Төсвийн хөрөнгө оруулалтаар 2.004.700 төгрөгийн өртөг бүхий 8 бүлгийн хүлээн авах өрөөний буйдан сандал нийт 68.683.942 төгрөгийн хөрөнгө оруулалт - “Начин трейд ХХК” нь шинэ цэцэрлэгт 30 ширхэг нэг бүрийн 90.000 төгрөг хүүхдийн ор 	100%
124	9.5 Цэцэрлэг, сургууль, дотуур байрны орчин дахь хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах	<p>Эцэг эхийн хөрөнгө оруулалтаар 2 тасалгааг тохижуулсан. Сургуулийн захиргаанаас дотуур байрны багш нарын өрөө болон угаалгын өрөөний эд хөрөнгийг шинэчилж тохижуулсан. Энэ хичээлийн жилд дотуур байранд 78 хүүхэд 2 багш, 2 тогооч, 1 үйлчлэгч 1 жижүүр ажиллаж байна. Хичээл 1 ээлжээр ордог болсонтой холбоотойгоор бага ангийн хүүхдүүд хөгжих боломж нь нээгдэж дугуйлан секцэд бүрэн хамрагдаж байна.</p>	100%

		Дотуур байрны гадна талын болон коридор,хүүхэд хөгжлийн өрөөний гэрэлтүүлгийг сайжруулж шинэчилсэн. Мөн үүдний хонгилыг эрэгтэй ажилтнууд засаж тохижуулсан бөгөөд шинээр агуулах байсан 2 өрөөг засаж тохижуулан орчин нөхцөлийг сайжруулж байна.	
125	9.6 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах, хөгжих, хамгаалуулах эрхийг хангаж сургалтын таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх	Сургуулийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй суралцагч 24 байдаг үүнээс харааны 1, сонсголын 2, тулгуур эрхтний 6, оюун ухааны 6, дауны синдромтой 2, сэтгэц зан төрхийн өөрчлөлттэй 1, уналт таталт оноштой 3, зүрхний гажиг цоорол 3 суралцагч байна. Тэднийг хамт олон дунд нь нийгэмшүүлэн, сурч хөгжих боломжоор ханган ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй 8 суралцагч нь 11 төрлийн дугуйлан, сонгон, секц, клубт хамрагдан хөгжиж байна. Тус сумын 2 цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй 6 хүүхэд явуулын багшийн үйлчилгээгээр суралцаж байгаа бөгөөд эдгээр хүүхдүүдийн онош нь эмнэлгийн дүгнэлтээр батлагдсан гурван суралцах боломжгүй оноштой, нэг хүүхэд ахлах-б бүлэгт суралцаж байна.	100%
126	9.7 Орон нутгийн иргэдэд насан туршдаа суралцах тэгш боломжийг олгох, шаардлагатай нөхцөлийг нь бүрдүүлэх	2023 оны байдлаар 39 удаагийн 36 төрлийн сургалтад 2297 иргэнийг хамруулсан.	100%
127	9.8 Цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэлийн нөхцөлийг сайжруулж, мэргэжлийн хүний нөөцөөр хангах, туслах аж ахуйг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	ЦЭЦЭРЛЭГ: Энэ онд БШУЯ наас шарах шүүгээ 1,682, 000 , 4 ширэмтэй пийшин 2,900,000, аяга таваг угаагч автомат машин 1,392,000 т , гурил зуурагч 968.000т, угаалгын машин 582.490 төгрөг нийт 7.524.490 өртөг бүхий тоног төхөөрөмж сайжруулан ажиллаж байна. Хоол үйлдвэрлэл нь хамрагдсан хүүхдийн тоо, хоол үйлдвэрлэлийн бүртгэл, хоолны цэсийг ESIS системд үүсгэж хянах, түүхий эд материалын бүртгэл хөтөлж зэрэг бичиг баримтыг хөтөлж , хүний нөөцийг 3 удаагийн сургалтад хамруулан ажиллаж байна. ЕБСургууль: Хүүхдийн хоолны хэрэгцээнд зориулж талбайд сонгино, төмс, байцаа, хүлэмждээ өргөст хэмх, юуцай, бууцай, вандуй, чинжүү зэргийг тарьж ургуулахаар үрсэлгээгээ хийн үрээ бэлтгээд байна. Дотуур байранд 78 суралцагч, бага ангид 444 сурагч “Үдийн хоол” хөтөлбөрт хамрагдаж байна. Хоолны цэсийг дотуур байр сараар, үдийн хоол 7 хоногоор гаргадаг бөгөөд хоолны нэр төрөл сарын хугацаандаа давтагддаггүй. Сэлэнгэ аймгийн ИТХ-ын тогтоолоор батлагдсан сургалтын байгууллага тоног төхөөрөмж арга хэмжээний хүрээнд хоол үйлдвэрлэлийн гол тогоог хэрэгцээт тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд 3.100.00 төгрөгийн өртөг бүхий 1-р хоолны тогоо, 3.600.000 төгрөгийн өртөг бүхий 2-р хоолны тогоо нийт 6.700.000 /зургаан сая долоон зуун мянган/ төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлснийг хөрөнгөд бүртгэн дотуур байрны гал тогоонд хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглагдаж байна.	100%
128	9.9 Цэцэрлэг, сургуулийн дутагдаж байгаа мэргэжлээр орон нутагт шилжин ажиллах багш нарт орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлэх	ЦЭЦЭРЛЭГ: МУБИС -ийн харьяа Дархан дээд сургуульд туслах багш С.Сарангоог Дуу хөгжмийн багшаар, Туслах багш Ж.Энхжаргалыг цэцэрлэгийн бүлгийн багшаар тус тус сургасан. Мэргэжлийн багш нарын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор 4 багшийн байр сууцны түрээсийн зардлыг шийдвэрлэж ажиллалаа.	100%
129	9.10 Сумын түвшинд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх чиглэлээр орон нутгийн томоохон аж ахуйн нэгж, гарааны бизнес эрхлэгчидтэй хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэн байгууллагын нийтийн эзэмшлийн талбайн зөөлөн эдлэл шинэчлэх ажилд 20.000.000 сая төгрөг шийдэж нийтийн эзэмшлийн 137 м2 хивс шинэчлэх ажил хийгдсэн.	100%

		Монжим трейд ХХК тай хамтран эрхлэгч, арга зүйч , нярав нягтлан, урлаг заал , коридорт 2.000.000 өртөг бүхий хөшиг чүүлийг хандиваар тохижуулав.	
130	9.11 Үндэсний бичигтэн 2022-2024” хөдөлгөөнийг өрнүүлэх, үр дүнг тооцох	Үндэсний бичиг соёлын өдөр” 1 сарын аяны хүрээнд Ерөө сумын СӨБ болон ЕБС-ийн багш ажилчид, Соёлын төвийн ажилтан, ЗДТГ -ын ажилтан албан хаагчдад дэвтэр нээлгэн журамласан үг бүхий эхээр цээж бичиг хийж, галигаас монгол бичигт буулган бичих, монгол бичгээр минутаар унших үйл ажиллагааг зохион байгуулж түвшнийг тогтоолоо. Цаашид түвшинд нь тохирсон даалгавар хийлгэж эргэх холбоотой ажиллахаар төлөвлөн ажиллаж байна. Үүнд: ЕБС –ийн 37 багш, СӨБ –ийн 12 багш, ЗДТГ ын 18 ажилтан албан хаагч хамрагдлаа.	90%
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ:			
131	10.1 Спорт цогцолборын тоног төхөөрөмж, техник хэрэгслийг тогтмол нэмэгдүүлэх	Нийгмийн хариуцлагын хүрээнд фитнес тоног төхөөрөмж суурилуулах 30.000.000 сая төгрөгийн төсөв батлуулсан.	30%
132	10.2 Нийтийн биеийн тамир, спортыг иргэдийн эрүүл мэнд, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгон хөгжүүлэх, шаардагдах санхүүг шийдвэрлэх	“Эрүүл Монгол хүн”, “ЦАГ ГАРГАЯ” биеийн тамирын арга хэмжээг улс орон даяар зохион байгуулж байгаатай холбогдуулан Спорт цогцолбороос 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Ахмадуудын дунд “Алхалт таны эрүүл мэндэд тустай” явган аяллыг сумын ЗДТГ-ын өмнөх талбайгаас Ерөө гүүр хүртэл зохион байгуулж нийт 25 ахмад настан оролцлоо. Мөн Эрүүл Монгол хүн үндэсний хөдөлгөөний хүрээнд “Өглөөний хүн” аянд хамт олноороо нэгдэж 2023.04.03- 06.25 хүртэл өдөр бүр -ны өглөө ЗДТГ-ын өмнөх талбайгаас Ерөө гүүр хүртэл алхалтаа хийлээ.	90%
133	10.3 Сургуулиудад хичээлээс гадуурх спортын дугуйлан секцийг хичээллүүлж, секц сургалтын тоо, хамрах хүрээг нэмэгдүүлэх	<ul style="list-style-type: none"> • Чөлөөт бөхийн зааланд ажлын 5 өдөр чөлөөт бөхийн бэлтгэл орж өдөр бүр 30-40 сурагч, 12 иргэн хамрагдаж байна. • Үндэсний бөхөөр давхардсан тоогоор 840 сурагч, 336 бөхчүүд хичээллэсэн байна. • Сумын эмэгтэйчүүдийн холбооноос хамтарч 14 хоногийн ИОГЫН дасгал сургууллт өглөө 6 цагаас 8 цагийн хооронд зохион байгуулж давхардсан тоогоор 224 иргэн хамрагдсан. • Ажлын 5 хоногийн өдрийн 2 цагийн сагсан бөмбөгийн сурагчдын дунд бэлтгэл орж 45 сурагч хамрагддаг. 	100%
134	10.4 “Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”-ын үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж, иргэдийг хамруулах	Түвшин тогтоох сорилд 654 иргэнийг хамруулсан.	90%
135	10.5 Багийн, өвлийн, үндэсний спортын төрлүүдийг хөгжүүлэх, өвлөн уламжлуулах, сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах	Буриад улсын Закаменск-д зохион байгуулагдсан Бөмбөгтэй хоккейн олон улсын тэмцээнд Сэлэнгэ аймгаа төлөөлж Бугант тосгоны сурагчид оролцон Тэргүүн байр эзэллээ.	70%
136	10.6 Орон нутгийн алдартай тамирчин, дасгалжуулагчдаар ёс зүй, зөв хандлага төлөвшүүлэх, эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг бий болгох талаар нийгэмд зөв зүйтэй үлгэр дуурайлал болох нөлөөллийн ажлыг зохион байгуулах	Т.Бямбаагийн нэрэмжит Ерөнхий боловсролын сургууль, Ерөө Сумын Спорт Цогцолбороос Идэрчүүдийн Дэлхийн аваргын хүрэл медальт Азийн аваргын мөнгөн медальт Дэлхийн залуучуудын аваргын шагналт тавдугаар байрт Монгол улсын хошой аварга ОУХМ Ганболдын Мөнхцэцэгийн нэрэмжит тэмцээн нийт 13 жингийн 74 сурагч оролцож амжилттай болж өндөрлөлөө.	90%
137	10.7 “Спортлог Сэлэнгэчүүд” арга хэмжээг хэрэгжүүлэх	УИХ-н гишүүн Ж.Эрдэнэбатын нэрэмжит “СЭЛЭНГЭ ЛИГ -2023” 10 дахь удаагийн спортын наадам зохион байгуулагдаж 17 сум 6 тосгодын 137 багийн 1300 гаруй тамирчид	90%

		өөрсдийн хурд хүч авхаалж самбаагаа дайчлан өрсөлдөж шагайн харваан төрөлд хүрэл, Залуучуудын насны ангилалд эмэгтэй сагс хүрэл, Оюутны ангилалд эрэгтэй волейбол мөнгө медаль хүртэж багийн дүнгээр 5 дугаар байр эзэллээ.	
138	10.8 Иргэдийн дунд спортын олон төрөлт тэмцээнийг зохион байгуулах	<p>Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг угтан Ерөө сумын эмэгтэйчүүдийн холбоо болон Спорт цогцолбороос хамтран сумын эмэгтэйчүүдийн дунд спортын 3 төрөлт тэмцээнийг 2023.03.06-ны өдөр амжилттай зохион байгууллаа. Волейболын тэмцээнд 14 баг, даамны тэмцээнд 14, ширээний теннисний тэмцээнд 14 тамирчид тус тус оролцлоо.</p> <p>Ерөө сум үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг угтан “Өвөл цагийн соёл, хүмүүжлийн ажлын нээлтийн арга хэмжээг Засаг даргын Тамгын газраас 5 төрөлт спортын тэмцээнээр зохион байгуулж нийтдээ төр, төсвийн байгууллагууд ажилчид, иргэд 130 гаруй хүнийг хамруулсан.</p>	90%
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ:			
11.1 Нийгмийн эрүүл мэнд болон эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр:			
139	11.1.1 Алслагдсан сум, багийн иргэд, малчид тариаланчдад нарийн мэргэжлийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг явуулын хэлбэрээр үзүүлэх	<p>Алслагдсан багийн хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг явуулын амбулаториор хүргэх “Халуун сэтгэл 23” үзлэгийн баг Ерөө суманд амжилттай ажиллаж, нийт 1140 орчим иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хүргэж үйлчилсэн. Айл өрхүүдэд гурван төрлийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, 2 төрлийн оношилгоо (зүрхний цахилгаан бичлэг, эхо)-д 258 иргэн хамруулж, 230 гаруй өвчлөл илэрснээс 10 иргэний өвчлөл шинээр оношлогдсон байна.</p> <p>Иргэдийн дунд зонхилон тохиолдож буй тэргүүлэх өвчлөл:</p> <ol style="list-style-type: none"> 1. Зүрх судасны эрхтэн тогтолцооны өвчлөл- 27.0% 2. Бөөр шээсний замын эрхтэн тогтолцооны өвчлөл -25.8% 3. Хоол боловсруулах /нойр булчирхай/ эрхтэн тогтолцооны өвчлөл -42.5% 4. Амьсгалын эрхтэн тогтолцооны өвчлөл- 0,4% хувь тус тус эзэлж байна. <p>Мөн үзлэгийн үеэр явуулын эмийн сан ажиллаж, 820.0 мянган төгрөгийн эмийн борлуулалт хийж үйлчилсэн байна.</p> <p>Багийн бага эмч Г.Эрдэнэтуяа Энхтал, Нарийн хөндий, Хандгайт, Улаанбулаг, Шаазгайтын 56 малчин өрхийн 162 хүнд эрүүл мэндийн үйлчилгээг хүргэж ажилласан байна. Артерийн даралт, чихрийн шижин өвчнөөс урьдчилан сэргийлэх гарын авлага тараасан.</p>	100%
140	11.1.2 Эх, нялхсын эрүүл мэндийг сайжруулж, өвчлөл, эндэгдлийг бууруулах ажлыг эрчимжүүлэн, үр дүнг тооцож ажиллах	<p>Ерөө сумын ЭМТ нь өөрийн харьяаллын 0-17 насны 1322 хүүхдээс гадна явуулын, түр оршин суудаг хүүхдүүдэд анхан шатны тусламж үйлчилгээг тасралтгүй үзүүлдэг. Багийн эмч нар эргэлтийг баталсан хуваарийн дагуу долоо хоногийн Мягмар , Пүрэв гарагуудад нэг хүртэлх насны хүүхдийн гэрийн эргэлтийг хийдэг. Жирэмсэн эмэгтэйчүүдийг эхний 3 сартайд хяналтад хамруулах ажилд энэ онд 65 эмэгтэйг хяналтад авч хамрагдалт 96 хувьтай.</p> <p>Жирэмсэн эмэгтэйчүүдийн давтан шинжилгээг сумын эрүүл мэндийн төвд биохими, цусны ерөнхий шинжилгээ, шээсний ерөнхий шинжилгээг хагас автомат анализатораар, элэгний В, С вирус илрүүлэх, ХДХВ/ДОХ, тэмбүү илрүүлэх шинжилгээг түргэвчилсэн оношлуураар хийж, давхардсан тоогоор 65 жирэмсэн эмэгтэйг хамруулсан.</p> <p>Хөх умайн хорт хавдрыг илрүүлэх эрт илрүүлэг хамрагдах 220 эмэгтэйгээс хамрагдсан 71 хамрагдалтын хувь 32.2 байна. Умайн хүзүүний хорт хавдрын шинжилгээ өөрчлөлттэй илэрсэн 3 буюу 4,2 хувь илэрсэн лавлагаа шатны оношилгоо, шинжилгээнд явуулсан.</p>	90%

141	<p>11.1.3 Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэн эрүүл мэндийн байгууллагын гадаад, дотоод орчны тохижилт (тэргэнцэрт зориулсан үүдний хэсэг, хананы бариул, дуугүй хөтөч, тусгайлсан жорлон, дуут дохио гэх мэт)-ыг сайжруулах</p>	<p>Эрүүл мэндийн төвийн хэвтэн эмчлүүлэх хэсэгт цэвэр, бохир усны системд холбогдсон ариун цэврийн өрөөтэй болсон бөгөөд жорлонгийн суултуур, био 00, угаалтуур нь эвдрэл гэмтэлгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, жирэмсэн эмэгтэйчүүд, өндөр настай хүмүүст ээлтэй орчин бүрдүүлэхэд анхаарч тохижуулж, тухтай орчин бүрдүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> • Хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлүүлэх налуу шат болон шатны бариулыг хийж хөгжлийн бэрхшээлтэй иргэд саадгүй үйлчлүүлэх боломжийг бүрдүүлсэн байна. • Харааны бэрхшээлтэй болон өндөр настан, унах эрсдэл өндөртэй хүмүүст зориулсан ханын бариултай. • Өрөө тасалгаанууд босгогүй. Тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй болон хэвтрийн хүнд өвчтэй иргэдэд зориулсан тэргэнцрийг үүдний хэсэгт байрлуулсан. • Гадна орчны болон дотор гэрэлтүүлэг сайтай. • Харааны бэрхшээлтэй болон өндөр настан, унах эрсдэл өндөртэй хүмүүст зориулсан ханын бариултай. • Өрөө тасалгаанууд босгогүй. Тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй болон хэвтрийн хүнд өвчтэй иргэдэд зориулсан тэргэнцрийг үүдний хэсэгт байрлуулсан. • Гадна орчны болон дотор гэрэлтүүлэг сайтай. 	100%																								
142	<p>11.1.4 Улс орон даяар зохион байгуулагдаж байгаа урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт өөрийн харьяа нутаг дэвсгэр дэх хүн амыг насны бүлгээр бүрэн хамруулах, энэ чиглэлд ажил олгогчид болон салбар дундын хамтын ажиллагааг ханган манлайлж ажиллана.</p>	<table border="1" data-bbox="800 695 1793 1230"> <thead> <tr> <th>Эрт илрүүлэг</th> <th>Нийт хамрагдвал зохих тоо</th> <th>Хамрагдсан тоо</th> <th>Хамралтын хувь</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэг үзлэг</td> <td>4058</td> <td>2639</td> <td>65%</td> </tr> <tr> <td>Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэг</td> <td>3079</td> <td>2563</td> <td>83%</td> </tr> <tr> <td>Элэгний эрт илрүүлэг</td> <td>4058</td> <td>1118</td> <td>27%</td> </tr> <tr> <td>Умайн хүзүү, хөхний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэг</td> <td>342</td> <td>138</td> <td>40%</td> </tr> <tr> <td>Хүүхдийн эрт илрүүлэг үзлэг</td> <td>1322</td> <td>883</td> <td>66.7%</td> </tr> </tbody> </table> <p>Дээрх илрүүлэг үзлэгээр илэрсэн эмгэгүүдийг хяналтад авч, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. ЭМГазраас зохион байгуулсан Халуун сэтгэл 2023 аяны хүрээнд алслагдсан айл өрхөд 3 төрлийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, 2 төрлийн оношилгоо (зүрхний цахилгаан бичлэг, эхо)-д 258 иргэн хамруулж, сумын эрүүл мэндийн төвд байрласан суурин баг нь иргэдэд 7 төрлийн нарийн мэргэжлийн эмчийн тусламж үзүүлж нийт 1140 үзлэг, оношилгоог хийсэн байна.</p> <p>Төгөлдөр Ерөө ОНӨТҮГ 18 ажилчдад, цэргийн насны 44 залуу, эрүүл мэндийн мэндийн төвийн 20 ажилчдад үзлэг хийж 8 төрлийн шинжилгээ хийсэн.</p>	Эрт илрүүлэг	Нийт хамрагдвал зохих тоо	Хамрагдсан тоо	Хамралтын хувь	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэг үзлэг	4058	2639	65%	Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэг	3079	2563	83%	Элэгний эрт илрүүлэг	4058	1118	27%	Умайн хүзүү, хөхний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэг	342	138	40%	Хүүхдийн эрт илрүүлэг үзлэг	1322	883	66.7%	100%
Эрт илрүүлэг	Нийт хамрагдвал зохих тоо	Хамрагдсан тоо	Хамралтын хувь																								
Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэг үзлэг	4058	2639	65%																								
Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэг	3079	2563	83%																								
Элэгний эрт илрүүлэг	4058	1118	27%																								
Умайн хүзүү, хөхний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэг	342	138	40%																								
Хүүхдийн эрт илрүүлэг үзлэг	1322	883	66.7%																								

		Мөн 40-65 насны иргэдийн дунд артерийн гепиртензийн эрт илрүүлгийн үзлэг 806, чихрийн шижин хэв шинж -2 илрүүлэг үзлэгт 810 шинээр илэрсэн 6, элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгт 581 хүн хамрагдсан . Одоогоор элэгний хатууралтай 4, элэгний хорт хавдартай 4 хянагдаж эмчилгээ үйлчилгээ авч байна.	
143	11.1.5 Цар тахлын үед эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хэвийн, тасралтгүй байдлыг хангаж, нөөцийг бүрдүүлэн, хэнийг ч орхигдуулахгүй ажиллана.	Ковидын түргэвчилсэн шинжилгээг 63 хүнд урьдчилан сэргийлэх зорилгоор хийсэн бөгөөд эерэг гарсан 3 тохиолдол бүртгэгдсэн. Томуу төст амьсгалын замын өвчлөл хүндрэлээс урьдчилан сэргийлж халдварт өвчин ихсэх улирлыг угтуулан иргэдийн дунд сургалт сурталчилгааг орон нутгийн мэдээллийн хэрэгсэл, гарын авлага, боршур хийж, цахим хуудсанд зөвлөгөө мэдээлэл байршуулах зэрэг хэлбэрүүдээр явуулж байна	100%
144	11.1.6 Эрүүл мэндийн салбарын хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжих зорилтот хөтөлбөр, арга хэмжээг (“Эрүүл идэвхтэй амьдрал”, “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд”, “Хавдрын эсрэг”, “Харшлаас сэргийлэх”, “Эрүүл чийрэг эр хүн”, “Элэг бүтэн Монгол”, “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх”, “Орчны эрүүл мэнд”) хэрэгжүүлж ажиллана.	1.Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх ажлын хүрээнд: Хүн амыг улирлын чанартай томуу, томуу төст өвчин бусад хүн байгалийн үзэгдлээс шалтгаалах халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 6 удаагийн сургалт , 10 төрлийн ажил арга хэмжээг, 3 удаагийн үзлэг оношилгоог зохион байгуулж нийтдээ давхардсан тоогоор 2500 гаруй иргэнийг хамруулсан. Улирлын чанартай томуу томуу төст амьсгалын замын өвчлөл хүндрэлээс урьдчилан сэргийлэх халдварт өвчин ихсэх улирлыг угтуулан иргэдийн дунд сургалт сурталчилгааг гарын авлага, боршур хийж цахим хуудсанд зөвлөгөө мэдээлэл байршуулах, халдварын эсрэг дэглэм зэрэг арга хэрэгслийн талаар иргэдэд тогтмол сурталчилдаг. 2.Эрүүл идэвхтэй амьдрал арга хэмжээний хүрээнд: Иргэд албан хаагчдын эрүүл мэнд, хөдөлгөөнийг дэмжин эрүүл сайхан агаарт эрчимтэй хөдөлгөөн хийх нөхцөлийг бүрдүүлэх, эвсэг хамт олонч зан төлөвшүүлэх, нийгэм соёлын оролцоог идэвхжүүлэх зорилгоор 4 арга хэмжээ, 2 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 1350 иргэнийг хамруулсан. 3.Эх хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд арга хэмжээний хүрээнд: Иргэдэд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлт, бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс сэргийлэх зорилгоор “Бэлгийн замаар дамжих халдвараас сэргийлэхэд иргэдийн оролцоо”, “НҮЭМ”, “Гэр бүл төлөвлөлт”, “Гэр бүлийн хүчирхийлэл” сэдвүүдээр сургалтуудыг зохион байгуулж нийт 53 иргэнийг хамрагдсан. 4.Харшлаас сэргийлэх арга хэмжээний хүрээнд: Нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламж, явган хүний замын хог, цас мөсийг тогтмол цэвэрлэж, орчныг бохирдолгүй цэвэр байлгаж, шарилж хогийн ургамлыг түүж цэвэрлэх зорилгоор байнгын цэвэрлэгээний хуваарь гарган 4 удаа цэвэрлэгээ хийсэн. Ургамлын болон тоосны харшил элбэг тохиолддог сарууд буюу 4-9 сард иргэд, албан хаагчдад танхимаар болон цахимаар “Ерөө сумын эрүүл мэндийн төв сургалт сурталчилгаа” хаягаар зөвлөмж мэдээлэл хүргэн ажиллаж байна. 5 .Элэг бүтэн Монгол хөтөлбөрийн хүрээнд : Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/577 тоот /2022-2025 /Элэг бүтэн Монгол арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд үзлэг шинжилгээг стандартын дагуу чанартай, аюулгүй, жигд хүртээмжтэй нэмэлт төлбөргүй үйлчилгээ үзүүлж ажилласан бөгөөд элэгний хавдар илрүүлэх үзлэгт 1231 хүнийг хамруулсан. Элэгний В,С вирустэй нийт 81 үйлчлүүлэгч байсан бөгөөд Үүнээс В вирустэй -46, С вирустэй 31, ВС хавсарсан вирустэй -4 байна. 2023 онд В вирус -6, С вирус -6 ВС хавсарсан вирустэй -3 нийт 15 иргэн вирус илэрсэн бөгөөд нийт хяналтаас хасагдсан -9,	100%

		одоо 87 хүн хяналтад байна. Элэгний хяналтын үйлчлүүлэгчдийн 98 хувь нь вирусийн эсрэг эмчилгээнд хамрагдсан. Элэгний хорт хавдрын хяналтад 7, элэгний хатууралтай 4 хүн эмчилгээ үйлчилгээ авч байна.	
145	11.1.7 Сэтгэцийн эрүүл мэнд ялангуяа хүүхэд, өсвөр үеийнхэнд сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, архи, тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөл, түүний талаарх мэдлэг олгох, хэрэглээг бууруулах, урьдчилан сэргийлэх болон осол, гэмтлээс сэргийлэх (ахуйн орчны осол гэмтэл, уналт, авто тээврийн гэх мэт)-д салбар дундын хамтын ажиллагааг ханган хамтран ажиллана.	Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн байгууллагууд болон иргэдийн бүлэгтэй хамтран ажиллаж “Осолгүй орчин”, “Унаж гэмтэхээс сэргийлье” сурталчилгааны материал хүргэн сурталчилгаа хийж гаднах цас мөсөө цэвэрлэх их цэвэрлэгээний ажил зохион байгуулсан. Бага насны хүүхэдтэй эцэг эхчүүдэд зонхилон тохиолдож болох усанд живэх, унаж гэмтэх, хордох, хахах, түлэгдэлт зэрэг осол гэмтлээс хэрхэн сэргийлэх, түүнд яаралтай авах арга хэмжээг хэрхэн авах бага насны хүүхдийг эзгүй орхихгүй байх талаар тогтмол зөвлөгөө өгч мэдээллийг боршур болон эмт-ийн facebook, телевизороор видео зураг ,хэлбэрээр иргэдэд түгээж ажилласан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан, хүүхэд, үйлчлүүлэгч нарт шатан дээр халтирахаас сэргийлж резин нааж сандал , цонхны тавцан дээр хүүхэд гаргахыг хориглох, ажлын байр архи, тамхигүй орчин, хүүхдээ түлэгдлээс сэргийлье санамж байрлуулсан.	50%
146	11.1.8 Жирэмсний эрт үеийн хяналтын хамралтыг нэмэгдүүлэх, Мөн тухайн сум, тосгоны малчин өрхийн жирэмсэн эмэгтэй, отор нүүдэл болон түр оршин суугаа явуулын жирэмсэн эмэгтэйчүүдийг давхар хянах,	Жирэмсэн эмэгтэйчүүдийг эхний 3 сартайд 65 эмэгтэйг хяналтад авч 96 хувьтай ажиллаж байна. Жирэмсэн эмэгтэйчүүдийн давтан шинжилгээг сумын эрүүл мэндийн төвд биохими, цусны ерөнхий шинжилгээ, шээсний ерөнхий шинжилгээг хагас автомат анализатораар, элэгний В, С вирус илрүүлэх, ХДХВ/ДОХ, тэмбүү илрүүлэх шинжилгээг түргэвчилсэн оношлуураар хийж, давхардсан тоогоор 144 жирэмсэн эмэгтэйг хамруулсан. Хөх умайн хорт хавдрыг илрүүлэх эрт илрүүлэгт хамрагдах 220 эмэгтэйгээс хамрагдсан 71 хамрагдалтын хувь 32.2 байна. Умайн хүзүүний хорт хавдрын шинжилгээ өөрчлөлттэй илэрсэн 3 буюу 4,2 хувь илэрснийг лавлагаа шатны оношилгоо, шинжилгээнд явуулсан.	100%
147	11.1.9 Өрх, сумын эрүүл мэндийн төвд 9 сар, 18 сар, 36 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг тогтмол зохион байгуулна. (Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/304, А/699, А/460 дугаар хамтарсан тушаал).	Сумын ЭМТ нь өөрийн харьяаллын 0-17 насны 1322 хүүхдээс гадна явуулын, түр оршин суудаг хүүхдүүдэд анхан шатны тусламж үйлчилгээг тасралтгүй үзүүлдэг. Багийн эмч нар эргэлтийг баталсан хуваарийн дагуу долоо хоногийн Мягмар , Пүрэв гарагуудад долоо хоногоор хуваарь гарган ,0-1 сартай хүүхдийг 7 хоног тутамд, 2-6 сартай хүүхдийг 14 хоногт нэг удаа, 6-12 сартай хүүхдийг сард 1 удаа үзэж картад бичилт хийж тэмдэглэл хөтлөн ажилладаг . Нэг хүртэлх насны хүүхдийн гэрийн эргэлтийн хамралт 100 хувьтай ажиллаж байна.	100%
148	11.1.10 Хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийг дэмжих, шүд цоорох өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг өөрийн орон нутгийн онцлогт тулгуурлан зохион байгуулах. (Үүнд “Эрүүл шүд” сэдэвт аяныг сургууль, цэцэрлэгүүдэд өрнүүлэх)	ЕБС-ын эмчтэй хамтран 1-12 ангийн сурагчдын дунд эрт илрүүлгийн урьдчилан сэргийлэх үзлэгийг хийж 766 хүүхэд буюу 89,7 хувийг хамруулсан. Уг үзлэгээр бүх сурагчдад амны хөндийн үзлэгийг давхар хийсэн бөгөөд өвчлөлөөр нь авч үзвэл: Шүд хорхойтох өвчин /Кариес/ 378 буюу 49,3%, Архаг тонзиллит 3,3 хувийг тус тус эзэлж байна. Амны хөндийн эрүүл мэндийн талаар, тэр дундаа шүдээ угаах үйлдлийг хэвшил болгох зорилгоор ЕБС 3а ангийн 25 сурагчдыг шүдний нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулж, “Амны хөндийн эрүүл мэнд”, “Шүдээ хэрхэн зөв угаах вэ” дадлага сургалтыг зохион байгууллаа. Эрүүл мэндийн төвийн шүдний кабинетаар /шүдний нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт/ давтан үзлэгтэй нийлээд давхардсан тоогоор нийт 90 хүн үйлчлүүлснээс 28 буюу 31 хувийг хүүхдүүд эзэлж байна.	100%
149	11.1.11 Хүн амын дунд зонхилон тохиолдож буй халдвар бус өвчин (элэг, хөх, умайн хүзүүний хорт		100%

	хавдар, чихрийн шижин, цусны даралт зэрэг)-ний эрт илрүүлэх үзлэг, шинжилгээнд иргэн бүрийг хамруулах, иргэдэд өгөх мэдээлэл, сургалт, сурталчилгааг эрчимжүүлэн салбар хоорондын уялдааг ханган ажиллана.	2023 онд 40-65 насны иргэдийн дунд артерийн гепиртензийн эрт илрүүлгийн үзлэг 806, чихрийн шижин хэв шинж -2 илрүүлэг үзлэгт 810 шинээр илэрсэн 6, элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгт 581 хүн хамрагдсан . Одоогоор элэгний хатууралтай 4, элэгний хорт хавдартай 4 хянагдаж эмчилгээ үйлчилгээ авч байна.	
11.2 Хүний нөөцийг хангах чиглэлээр:			
150	11.2.1 Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд гардан ажиллаж буй сувилагчийн тоог нэмэгдүүлж, эмч, сувилагчийн харьцааг 1:2- т хүргэх арга хэмжээг хэрэгжүүлэх, орон нутгийн захиалгаар жилд сувилагч мэргэжлээр суралцагчийг шинээр сургах	ЭМТ-ийн дарга-1, их эмч-1, багийн бага эмч -1, эх баригч бага эмч-1, статистикч бага эмч-1, вакциатор-1, сувилагч-5, лаборант-1, эмийн санч-1, нягтлан бодогч-1, нярав-1, тогооч-1, үйлчлэгч-2, жолооч-2, нийт 20 эмч, ажилчидтай эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж байна. Шинээр ажилд орсон сувилагч -1, жолооч-1	100%
151	11.2.2 Дутагдалтай эмч, мэргэжилтнээр бүрэн хангаж, тэдний нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллуулах чиглэлээр санаачилгатай ажиллаж, түрээсийн орон сууц болон бусад хэлбэрээр орон байртай болгох, мэргэшил олгох болон дээшлүүлэн сургах зардлыг шийдвэрлэх, урамшуулах, эмнэлгийн мэргэжилтнийг дээд шатлалын эмнэлэгт ажлын байранд дадлагажуулан сургах, сэлгэн ажиллуулах арга хэмжээг дэмжиж ажиллах	Ажилчдыг нийгмийн асуудлыг шийдвэрлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор 5 давхарт 2 өрөө байртай. Эмнэлгийн мэргэжилтэн , ажилчдын ажлын гүйцэтгэлийн үзүүлэлт, идэвх санаачилгатай, сайн ажилласан ажилчдад улирлын урамшууллыг улирал бүр 15-40 хувийн урамшуулал олгосон.	100%
11.3 Хүн амын эрүүл аюулгүй байдлыг хангах чиглэлээр:			
152	11.3.1 Сумын ундны усны эх үүсвэрийн онцгой, энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтэд хяналт тавих	Ундны усны эх үүсвэрийг хамгаалах зорилгоор “Болд төмөр Ерөө гол” ххк- нь 9000 ширхэг бургас модыг Баян гол дагуу тарьж, 1-р багийн Хангайн даваа, Чулуутын булгийн эхийг хашаажуулахаар төлөвлөөд байна. Тавин багийн Хужиртад сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 20,0 төгрөгийн өртөгтэй гүний худаг гаргах ажлыг “Бодь хараа” ХХК гүйцэтгэсэн.	90%
153	11.3.2 Харьяалах нутаг дэвсгэрийнхээ хүн амыг эрүүл ахуй, стандартыг хангасан ундны усаар тогтвортой, хүртээмжтэй хангах арга хэмжээг авч хэрэгжүүлж ундны усны эх үүсвэрийг нэмэгдүүлэх	Харьяалах нутаг дэвсгэрийнхээ хүн амыг эрүүл ахуй, стандартыг хангасан ундны усаар тогтвортой, хүртээмжтэй хангах ажлын хүрээнд сумын төсвийн хөрөнгө оруулалтаар 125,0 сая төгрөгийн өртөгтэй ус цэвэршүүлэх, гүний устай “Усны төвийг Баялаг говь”ХХК 80 хувийн гүйцэтгэлтэй байна.	90%
154	11.3.3 Хүн амын хэрэглэж байгаа ундны болон ахуйн усны чанар, аюулгүй байдалд тухайн нутаг дэвсгэрийн төвлөрсөн болон төвлөрсөн бус ус хангамж хариуцсан байгууллага, албан тушаалтан холбогдох стандарт, дүрмийн дагуу хяналт, шинжилгээ хийж, усны чанарыг сайжруулах арга хэмжээг авах	Ерөө сумын 1, 2-р багийн 4 хэсгээс ундны усны дээж авч Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газарт шинжлүүлэхэд анхны дүгнэлтээр унданд хэрэглэж болохгүй гэж гарсан. Зориулалтын дээжийн саваар дахин дээж авч шинжлүүлэхээр ажиллаж байна..	50%
155	11.3.4 Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн сүлжээнд эрсдэлийн үнэлгээг тогтмол хийлгэх, гарсан үнэлгээний дагуу арга хэмжээг авах	Эрсдэлийн үнэлгээ хийгдээгүй байна.	0%
156	11.3.5 Ахуйн гаралтай хог хаягдал, эмнэлгийн гаралтай хог хаягдлыг булшлах газарт тухайн сумын ИТХ-аар хэлэлцүүлж тогтоолоор газрыг олгож, Засаг дарга захирамж гаргаж баталгаажуулан хүн, мал, амьтанд халдвар тараах, байгаль орчинд аюултай	ЭМС-н 2017оны 12-р сарын 12-ны өдрийн А/505тоот тушаалын дагуу эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилах,цуглуулах,хадгалах байрыг 2022 онд барьж байгуулсан бөгөөд жил бүр засвар хийж эмнэлгээс гарсан хог хаягдлаа түр хадгалан 14 хоног бүр хогны цэг рүүгээ тээвэрлэн устгаж байна.	100%

	хог хаягдлыг эрүүл ахуйн нөхцөл, шаардлагын дагуу цуглуулах, хадгалах, тээвэрлэх, тогтоосон тусгай цэгт булшлах		
157	11.3.6 Эрх бүхий байгууллагын шийдвэрээр хориглосон газар, цэг болон нийтийн эзэмшлийн зам, талбайд хүнсний бүтээгдэхүүнийг ил задгай худалдаалах, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлүүлэхгүй байх	Эрх бүхий байгууллагын шийдвэрээр хориглосон газар, цэг болон нийтийн эзэмшлийн зам, талбайд хүнсний бүтээгдэхүүнийг ил задгай худалдаалах, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлддэггүй.	100%
11.4 Эрүүл мэндийн даатгалын чиглэлээр хийх ажил, арга хэмжээнүүд:			
158	11.4.1 Эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх ялангуяа ядуу, эмзэг бүлгийн иргэдийг бүрэн хамруулах, энэ чиглэлээр орон нутгийн удирдлага, иргэдтэй хамтран ажиллах, эрүүл мэндийн даатгалын талаар	<p>Даатгуулагчид үзүүлэх тусламж үйлчилгээний чанарыг сайжруулан шаардлагатай тоног төхөөрөмж хангах зорилгоор эх баригч, лаборант, сувилагч нарт компьютер, хурууны хээ уншигч, ЭХО аппарат, иммунологийн /Immunofluorescence Analyzer FIA-100/ аппарат, гемотологи аппарат, бумба, жин хэмжигч шарлагын аппарат зэргээр хангасан.</p> <p>Иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд цахим технологи нэвтрүүлэх ажлын хүрээнд ЭМДаатгал, ЭМХТ -ын H-info, health.gov.mn E.hospital.mn програмуудыг Оношилгоо шинжилгээ, Гэрийн тусламж үйлчилгээ, Өдрийн эмчилгээ, Сэргээн засах, эмчийн үзлэг, түргэн тусламж, яаралтай тусламж, хэвтэн эмчлүүлэх үйлчилгээ, эрт илрүүлэг зэрэг тусламж үйлчилгээнүүдийг цахимаар шивж зэрэг 1616 хүнд үйлчилсэн байна. Цахим ажлын гүйцэтгэл чанарыг сайжруулах зорилгоор интернэтийн хурдыг сайжруулах ажлыг Монголын цахилгаан холбоогоор гүйцэтгүүлсэн.</p>	100%
СОЁЛ УРЛАГИЙН САЛБАРЫН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ			
159	12.1 Соёл, урлагийн байгууллагад нэн шаардлагатай мэргэжилтэн бэлтгэх, мэргэшүүлэхэд дэмжлэг үзүүлэх, ажилтны нийгмийн баталгааг сайжруулах	<p>Ажилчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилтын хүрээнд:</p> <p>1.2023 оны жилийн эцсийн байдлаар УБ хотод- 1, аймагтаа-3, Дархан-Уул аймагт-1, бүсэд-1, цахим сургалт-14, сумандаа 3, байгууллагын дотоод сургалт-3 нийт 26 удаагийн сургалт семинарт хөгжмийн багш, номын санч, Соёлын төвийн дарга, бүжгийн багш, ОНСТанхимын ажилтан нар хамрагдаад байна.</p> <p>2. Соёлын төвийг мэргэжилтэй боловсон хүчнээр хангах зорилгоор СУИС-ийн харъяа Соёлын дээд сургуулийн номын сангийн эчнээ ангид номын санч Ц.Болортуяа, Орон нутаг сурталчлах танхимын ажилтан Б.Сэрчмаа нарын суралцах хугацааны цалинг 100 хувь олгон ажиллаж байна.</p>	100%
160	12.2 Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хамгаалалтын дэглэм тогтоож, дурсгал нэг бүрээр кадастрт оруулах	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газруудаа нэг бүрчлэн кадастр оруулахаар төлөвлөгөө гарган, хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилготойгоор холбогдох газарт уламжлан ажиллаж байна.	50%
161	12.3 "Удам угсаагаа дээдэлж, угийн бичгээ хөтөлө" жилийн аяныг зохион байгуулах	<p>"ХАРИУЦЛАГАТАЙ МАЛЧИН-ХӨДӨӨ АЖ АХУЙН СЭРГЭЛТ" сургалтад оролцсон малчдад "УГИЙН БИЧИГ ХӨТЛӨХ НЬ" сэдэвт сургалт зохион байгууллаа.</p> <p>Номын сангаас "Угийн бичгээ хөтөлцгөө" 77 ширхэг гарын авлага бэлтгэн иргэдэд тараасан.</p> <p>Цахимаар:</p> <ul style="list-style-type: none"> • Угийн бичиг гэж юу вэ?, • Угийн бичиг хөтлөх үлгэрчилсэн загвар • Угийн бичиг хөтлөхийн ач холбогдол • Угийн бичгийн схем зураглал • Угийн бичиг хөтлөх арга зүй • 3 үеийн угийн бичиг хөтлөх загвар <p>Угийн бичиг хөтлөх журам, тэмдэглэгээ зэрэг 7 мэдээллийг хүргэсэн./ 60 лайк, 49 сэтгэгдэл/</p>	90%

162	12.4 Ажилтан, албан хаагчдыг сахилга, ёс зүйн зөрчил гаргуулахгүй байх урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулах	2023 онд Соёлын төвийн хамт олноос шеф байгууллагуудтайгаа хамтран нийт 3 удаагийн тэмцээн уралдаанд амжилттай оролцлоо. Үүнд : 1. “Өвөл цагийн соёл хүмүүжлийн ажил-ын” нээлтэд зориулан Т.Бямбаагийн нэрэмжит ЕБС- иас зохион явуулсан” Хөдөлбө+хөгжилдье” тэмцээнд шеф хамт олноороо амжилттай оролцож ТЭРГҮҮН байр, 2. Зэвсэгт хүчний 102 жилийн ойг тохиолдуулан зохион явуулсан Эрчүүд тэмцээнд багаараа 2 дугаар байр эзэлсэн амжилт үзүүллээ. 3. 2023 оны 09 дүгээр сарын 19,20-ны өдрүүдэд Монголын соёл урлагийн ажилтны 30 дахь өдрийг тохиолдуулан Жавхлант суманд Ерөө бүсийн Соёлын ажилтны “БҮС НУТГИЙН СОЁЛЫН ОРОН ЗАЙ” уулзалт өдөрлөгт хамт олноороо “ЕРӨӨГИЙН СОЁЛЫН ТӨВ”, “МОНГОЛ МИНИЙ ЭХ ОРОН” дуугаар ая дууны мэндчилгээ хүргэснээс гадна Волейболын тэмцээнд 3 дугаар байр эзэлсэн амжилттай.	100%
163	12.5 Соёл, урлагийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэн, аж ахуй нэгж, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, түүх, соёлын дурсгалт зүйлсийг гэрээгээр хариуцагчдыг бодлогоор дэмжих	Түүх соёлын үл хөдлөх дурсгалт газруудыг иргэн, аж ахуй нэгжтэй байгуулсан гэрээ төлөвлөгөөний дагуу 2023 оны 4 дүгээр сард шинэчлэн 2 аж ахуй нэгж, 10 иргэнтэй гэрээ байгуулан ажиллалаа.	100%
164	12.6 Нүүдэлчин ахуй, үндэсний өв, соёл, уламжлалыг сурталчлан таниулах “Би Монгол хүүхэд” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах	1. Ерөө суманд Монголын үндэсний сур харвах наадмын нэгэн төрөл болох мөсний сурын харвааг нийтэд сурталчлах, хөгжүүлэх, түүний ёс жаягийг таниулах, уламжлалаа сэргээх, харваачдын ур чадварыг сайжруулах, иргэдийг спортоор хичээллүүлэх зорилгоор Ерөө сумын ЗДТГ, Монголын мөсөн сурын холбоо, Ерөө сумын “Хан буурагчингийн мэргэд” харваачдын холбооноос хамтран зохион байгуулсан Хойд бүсийн мөсөн сурын чуулга харваа 2023 оны 01 дүгээр сарын 28,29 ны өдрүүдэд Ерөө сумын Дааган дэл хэмээх ариун дагшин газар амжилттай зохион байгуулж уг харваанд Монгол орны өнцөг булан бүрээс 200 гаруй харваачид оролцлоо. 2. 2023.01.25-нд Ерөө сумын 1-р багийн засаг дарга Б.Батбаатар, Соёлын төвийн номын санч Ц.Болортуяа нарын хамтаар Тавин 1-р багийн малчин Бат-Очир (Баяд айл), малчин Марат (Казах айл)-нд очиж үндэстнийх нь талаар танилцсан ба хөтөлбөрийн дагуу видео контентын зураг бичлэг хийсэн. 3. ОУ-ын Эмэгтэйчүүдийн баярыг тохиолдуулан ЕБС-ийн сурагчдын дунд зохион явуулсан Ойровын Цэцэгмаагийн нэрэмжит “Үйлчин охид” тэмцээний талаар контент бэлтгэн иргэдэд сурталчиллаа.	100%
165	12.7 Орон нутгийн өөрийн онцлогт нийцсэн соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ, брэндийг тодорхойлж, “Алтаргана-2023” бага наадам, “Цагаан эсгийний баяр”, “Өргөн Сэлэнгэ” хөгжмийн наадам, “Монгол өв соёл-Монгол дархлаа” эвент арга хэмжээг зохион байгуулах	Орон нутагтаа шинээр авьяастануудыг нээн илрүүлэх, тэдний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор 2024 онд тохиох Ерөө сумын 100 жилийн ойг угтсан ажлын хүрээнд сумын ЗДТГ, Соёлын төвөөс хамтран 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр Засаг даргын нэрэмжит “БИД ЕРӨӨ НУТГИЙНХАН” урлагийн наадам зохион явууллаа. Уг наадамд ЗДТГ, ЕБСургууль, 1 дүгээр Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Шеф хамт олон /Соёлын төв, ХААН банк, Төрийн банк, ДСЦШСүлжээ ХХК, ЦДҮСүлжээ ТӨК, Гялс төгрөг ХЗХ/, Ахмадууд, 1,2 дугаар баг зэрэг 8 байгууллага, ААН, багийн иргэд 7 төрлөөр авьяас чадвараа сорин өрсөлдлөө./205 гаруй хүн/. Үзэгчид 156 Шагналын зардалд нийт 1,536,200 төгрөг зарцуулсан. -Алтаргана-2023 наадам болоогүй байна.	50%
166	12.8 “Номын баяр-2023” арга хэмжээг зохион байгуулж, номын сангийн сан хөмрөгийн баяжилт хийхэд дэмжлэг үзүүлэх	Соёлын төвийн номын сангаас дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: 1. ЕБС- ийн 1 - 5 дугаар ангийн дотуур байрны 44 хүүхдэд чанга уншлага	100%

		<p>2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “ХАМТДАА ХӨГЖЬЕ” өдөрлөгийн үеэр дунд Шинэ номын үзэсгэлэн гаргаж, 13 иргэнд үнэгүй карт нээн үйлчилсэн.</p> <p>3. Улсын Тэргүүний 1 дүгээр цэцэрлэгийн бэлтгэл А,Б, бүлгийн 49 хүүхдэд номын сангийн үйл ажиллагааг танилцуулсан.</p> <p>4.Номын баярыг угтан:</p> <ul style="list-style-type: none"> - “Миний дуртай баяр” гар зургийн уралдаан /СӨБ-ийн хүүхдүүдийн дунд/ - “Ангиараа уншъя” шүлгийн уралдаан /ЕБС-ийн сурагчдын дунд/ - “Том ном бүтээх” уралдаан /байгууллагуудын дунд/ тус тус зохион байгуулж шагналыг 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдөр гардуулан өглөө. Нийт 287 хүн хамрагдсан. 	
167	12.9 Тусгай хэрэгцээт иргэдэд үзүүлэх соёлын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх	<p>Соёлын төвөөс Ерөө сумын нийгмийн даатгал, нийгмийн халамж, Эрүүл мэндийн төв, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбооны салбар зөвлөлтэй хамтран “ХАМТДАА ХӨГЖЬЕ” өдөрлөгийн арга хэмжээг зохион байгуулан явууллаа.</p> <p>Өдөрлөгийн үеэр :</p> <ol style="list-style-type: none"> 1. Ерөө сумын Нийгмийн даатгалын улсын байцаагч Э.Болормаа “Эрүүл мэндийн тухай хууль”, Сайн дурын даатгалын ач холбогдлын талаар 2. Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Болормаа “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх тусламж хөнгөлөлтийн талаар 3. Эрүүл мэндийн төвөөс “Халдварт бус өвчнөөс сэргийлье” зэрэг мэдээлэл өглөө. <p>Соёлын төвөөс шинэ номоо сурталчлан, үнэргүй карт нээж, Караоке дуу, чөлөөт бүжиг, Хөгжөөнт тэмцээн зэргийг зохион байгуулан явууллаа.</p>	100%
168	12.10 Монгол бичгийн өв соёл, эх сурвалжийг сурталчлах, “Бүх нийтээрээ хос бичигтэн” болоход уриалсан нөлөөллийн ажлуудыг зохион байгуулах	<ol style="list-style-type: none"> 1.Соёлын төвөөс Үндэсний оюуны соёлын нандин их өв болсон Монгол бичгээ эрхэмлэн дээдэлж, эх хэл бичгээ зөв эзэмшин хэрэглэх, түүнд суралцах, хадгалан хамгаалж, хойч үедээ өвлүүлэх ариун үйлсэд хувь нэмрээ оруулж, өөрийн мэдлэг чадвараа сорьж, уламжлалт бичиг соёлт Монгол хүн гэдгээрээ бахархах эрмэлзэл төрүүлэх зорилготойгоор Төрийн албан хаагчид, ААН, иргэдийн дунд “БОСОО БИЧИГ- БИДНИЙ БАХАРХАЛ” сайхан бичигтэн шалгаруулах уралдааныг зохион байгуулж 13 ажилтан албан хаагч хамрагдан шагналт байруудыг тодруулан урамшууллаа. 2.Сэлэнгэ аймагт зохион байгуулагдсан “Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага MNS 6395:2022” сургалтад Соёлын төвийн ажилтан хамрагдлаа. 	100%
169	12.11 Соёлын биет болон биет бус өвийг өвлөн уламжлагчийг батламжилж, шавь сургалт зохион байгуулж, “Нүүдэлчин Монгол” олон улсын фестиваль зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх	<p>2023 онд Соёлын төвийг түшиглэн 62 суралцагчдад 5 төрлийн шавь сургалтад суралцлаа.</p> <p>"НҮҮДЭЛЧИН МОНГОЛ-2023" Дэлхийн соёлын биет бус өв тээгчдийн фестивальд Сэлэнгэ аймгаа төлөөлөн Ерөө сумаас 2 том хүн, 2 хүүхэд оролцсоноос: Соёлын биет бус өв тээгч П.Гантуяа Монгол Улсын 22 дахь "ӨВЛӨН УЛАМЖЛАГЧ, ХАТГАМАЛЧ"-аар шалгарсан амжилттай. Соёлын төвөөс багш П.Гантуяад 150,000 төгрөгийн урамшуулал олгосон.</p>	100%
170	12.12 Олон улс, улсын чанартай уралдаан тэмцээнд оролцох ардын авьяастан, хүүхэд багачуудад дэмжлэг үзүүлэх	<p>2023 онд Улсын чанартай 2, аймгийн чанартай-3, бүсийн-1 нийт 6 удаагийн уралдаан тэмцээнд Ерөө сумаас нийт 223 хүүхэд, том хүн оролцсоноос:</p> <ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> 7 цом <input type="checkbox"/> Алтан медаль-116, <input type="checkbox"/> Мөнгөн медаль-75, <input type="checkbox"/> Хүрэл медаль-60, <input type="checkbox"/> 4 хүн “Өвлөн уламжлагч, хатгаламч” тэмдгээр <input type="checkbox"/> Ерөө сумаараа БСҮСад наадмаар 3-р байр, <input type="checkbox"/> Хөтөлд болсон бүжгийн наадамд Тэргүүн байр 	100%

		<p>□ Жавхлант суманд болсон “Монгол хүүхэд-Монгол бахархал” язгуур урлагийн наадамд сумаараа Тэргүүн байр, Шилжин явах цомоор тус тус шагнагдсан амжилттай. Улс, аймгийн чанартай уралдаан тэмцээнд амжилттай оролцсон хүүхэд багачууд, ардын авьяастануудад дэмжлэг үзүүлсэн талаар:</p> <p>1.Бид Сэлэнгийн үр сад хүүхдийн наадамд амжилттай оролцсон хүүхэд багачуудыг Ерөө суманд үйл ажиллагаа явуулдаг 1 модны аж ахуй нэгжээс 500,000 төгрөгөөр, 2.Улаанбаатар хотноо зохион байгуулагдаж буй Үндэсний уран хатгамалчдын 4-р уралдаанд ЕРӨӨ сумаас оролцсон Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч, ахмад багш П.Гантуяаг Соёлын төвөөс 150,000 төгрөгөөр, 3.Жавхлант суманд болсон "МОНГОЛ ХҮҮХЭД-МОНГОЛ БАХАРХАЛ" Ерөө бүсийн хүүхдийн язгуур урлагийн наадамд оролцсон хүүхдүүдийн замын зардалд Соёлын төвөөс 250,000 төгрөгөөр тус тус дэмжлэг үзүүлсэн.</p>	
171	12.13 Соёл, урлагийн байгууллагуудын тохижилтын засвар хийх, хөгжим техник хэрэгслийг шинэчлэхэд дэмжлэг үзүүлэх	<p>2023 онд аймаг, улс, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нийт 46,977,400 төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Үүнд:</p> <p>1.Аймгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 15 сая төгрөгийн 22 ширхэг үндэсний хөгжмийн зэмсэг /Морин хуур, ятга, лимбэ, товшуур хөгжмүүд/ 2.Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 13,9 сая төгрөгөөр тайзны өмсгөлөө иж бүрэн шинэчилсэн. 3.Соёлын яамны хөрөнгө оруулалтаар 18,077,400 төгрөгийн үнэтэй 198 хүний суудалтай сандал</p>	100%
ХҮН АМ ЗҮЙН САЛБАРЫН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ			
172	13.1 Өрхийн хэмжээнд иргэдэд гэр бүлийн боловсрол олгох, цус ойртолтыг багасгах арга хэмжээ /хөтөлбөр/-г хэрэгжүүлж, мэргэжлийн байгууллагаас угийн бичгийн хөтлөлтийн асуудлаар мэргэжил, арга зүйн зөвлөгөөг авах, багш ажиллуулж, иргэдийн угийн бичиг хөтлөлтийг нэмэгдүүлэх	<p>Ерөө сумын “Угийн бичгийн зөвлөл”-ийг 2021 онд сумын Засаг даргын захирамжаар байгуулсан ба зөвлөлийн гишүүдийн санаачилгаар “Угийн бичиг хөтлөх” талаар Тавин, Буурагчин багийн 71 иргэн, малчдад биечлэн мэдээлэл өгч ажилласан ба “Угийн бичиг хөтөлцгөө” жижиг ном хэвлүүлэн 120 иргэнд тараан ажилласан.</p> <p>Угийн бичгээ хөтөлж ураг удмаа мэдэцгээе уралдааныг 11 сарын 08-ний өдрөөс 11 сарын 18-ны өдрийг хүртэл зарласан боловч уралдаанд иргэд оролцоогүй. Мөн Ерөө сумын ЗДТГ-ын мэдээ, Ерөө сумын Зарын нэгдсэн цэг фэйсбүүк хаягт 3 төрлийн мэдээлэл байршуулсан ба 967 иргэний хандалттай байна.</p>	100%
173	13.2 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 18.1.2, 18.1.5, 19 дүгээр зүйлийн 19.1.2, 19.1.5, дахь заалтуудын хэрэгжилтийг эрчимжүүлэх	<p>Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор 4 аян, 9 арга хэмжээ зохион байгуулж 8 төрлийн хамгааллын үйлчилгээнд 192 иргэн хамруулж 896.000 төгрөгийг зарцуулан ажиллалаа.</p> <p>Ерөө сумын Хамтарсан багийн үйл ажиллагааг эрчимжүүлж гэр бүл хүүхдийн хүчирхийллээс урьдчилан сэргийлж ажилласнаар 2021-2023 онд гэр бүл, хүүхдийн хүчирхийллийн дуудлага 14 хувиар буурч, илрүүлэг жилд дунджаар 8-12-ийн хооронд хэлбэлзэж байна. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч болон, эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүдийг хувийн хэрэгжүүлэн нэг бүрчлэн төлөвлөгөө гарган ажилласнаар гэр бүлийн хүчирхийлэл 82,8 хувь, эрсдэл 40 хувиар тус тус буурсан. Гэр бүлдээ хүчирхийлэл үйлддэг архины хамааралтай иргэдийн зан үйлд нөлөөлснөөр 2023 онд 5 иргэн архинаас гарсан.</p>	100%
174	13.3 Хамтарсан багийн үйл ажиллагааг удирдлага арга зүйгээр хангаж, зардлыг орон нутгийн төсөвт тусган иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах	<p>Сумын хамтарсан баг 2023 онд 36 төрлийн ажил арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөсөн ба ИТХурлаар буюу орон нутгийн төсөвт Түр хамгаалах байр барихад 80,000,000, хамтарсан багийн үйл ажиллагаанд 20,000,000 төгрөг зарцуулахаар батлагдсан. Түр хамгаалах байр барих ажил тендер зарлагдах шатандаа явж байна.</p>	70%

175	13.4 Хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлж, зорилтот өрх, гэр бүл, эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдийг судлан тогтоож, хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах, шаардлагатай тусламж үйлчилгээнд хамруулах	- Эрсдэлт бүлгийн хүүхдүүдийг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, ЕБСургууль, Цэцэрлэгийн хүүхэд хамгааллын багтай хамтран эргүүл жижүүрийн хуваарь, тэмдэглэлийн дэвтэр гарган сумын 1, 2-р багийн нутаг дэвсгэрийн хэмжээнд анхаарал татсан 14 өрхийн 21 хүүхдийн аюулгүй байдалд 10 удаа хяналт тавин ажилласан. Эрсдэлийн үнэлгээг 3 удаа явуулж 2 өрхийн 2 хүүхэд хасагдаж 6 өрхийн 13 хүүхэд эрсдэлт нөхцөлд амьдарч байна. Сэлэнгэ аймгийн ГБХЗХГазрын даргын 2023 оны а/168 дугаар тушаалын дагуу “ХАМТДАА ШАЛГАЯ, ХАМГААЛЪЯ” арга хэмжээний хүрээнд Эцэг эх, асран хамгаалагч, иргэд олон нийт, аж ахуйн нэгж байгууллагуудын оролцоотойгоор хүүхдэд ээлтэй, эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх, ахуйн хүрээний эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, хүүхдийг ахуйн осол гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, орчны эрсдэлийг үнэлж, шаардлагатай арга хэмжээг авах зорилгоор “Хамтдаа шалгая, хамгаалъя” арга хэмжээний хүрээнд 14 ажил арга хэмжээ төлөвлөж 24.550.400 төгрөг зарцуулан 100 хувь гүйцэтгэн ажиллалаа.	100%
176	13.5 Хүүхэд хамгаалал, залуучуудын хөгжлийг дэмжих чиглэлээр аж ахуй нэгж, байгууллагаас гаргаж буй санал санаачилгыг хөхүүлэн дэмжиж, хамтран ажиллах	"БТЕГ" ХХК-ний Баянгол сангийн хөрөнгө оруулалтаар Сумын Засаг даргын 2021 оны А/171 дугаарт захирамжаар баталсан “Суралцагчдад сургалтын төлбөрийн дэмжлэг олгох журам”-ын хүрээнд Ерөө сумын 23 оюутан хамрагдаж хүүхэд бүр 1,956,000 төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг авсан ба Тавин багаас 6, Буурагчин багаас 8, Бугант тосгоноос 9 оюутан хамрагдсан. Мөн Дархан-Уул аймаг дахь уул уурхай эрчим хүчний политехникийн коллежид шууд суралцах эрхийн бичгийг тус сумын амьжиргааны түвшин доогуур 3 өрхийн 3 залуу, “Хандгайт уул” ХХК-ний санаачилгаар Үндэсний техникийн их сургуульд 1 сурагчийг үнэ төлбөргүй сургахаар тус тус шийдвэрлэсэн.	100%
177	13.6 Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 57 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, хурдан морь уралдаанч хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах	Хурдан морины уралдаантай холбоотой сумын Засаг даргын захирамж-3, албан бичиг-7 гарч зөвшөөрөлгүй уралдсан 1 уралдааныг таслан зогсоон тарааж албан ёсны зөвшөөрөлтэй 3 уралдааныг зохион байгуулсан. Тухайлбал 2023 онд зохион байгуулагдсан 3 төрлийн хурдан морины уралдаанд давхардсан тоогоор 276 хүүхдийн аюулгүй байдалд хяналт тавьж ажилласан ба 3 хүүхэд мориноос унасан боловч бэртэл гэмтэл байхгүй.	100%
178	13.7 Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах	Ерөө суманд нийт 18-34 насны 979 залуучууд байдаг. Залуучуудын хөгжлийн тухай хуулийн дагуу Ерөө сумын Залуучуудын салбар зөвлөл нь 2021-10-22-ны өдрийн А/232 дугаар захирамжаар 9 гишүүний бүрэлдэхүүнтэй, Залуучуудын хөгжлийн зөвлөл нь 2021-10-06-ны өдрийн А/217 дугаар захирамжаар 17 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр, Ерөө сумын Залуусын нэгдэл нь 2023-01 сард байгуулагдан 217 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр хамтран залуучуудруу чиглэсэн ажил арга хэмжээг зохион байгуулж байна. 2023 онд Залуучуудруу чиглэсэн 4 төрлийн 56,000,000 төгрөгийн өртөгтэй ажил арга хэмжээ зохион байгуулахаар ИТХ-аар батлагдсан. Жилийн эцсийн байдлаар залуусын хөгжил хамгааллын төлөө 14 төрлийн ажил арга хэмжээ зохион 127 залуучуудыг нэгтгэн 1200 гаруй залуусыг хамруулан 16,531,600 төгрөгийг зарцуулан ажиллалаа. Тухайлбал “MAGIC HAT” аян, “Бяцхан зүрхэнд амьдрал бэлэглэе” аян, “SUNDAY WALK” явган аялал, “ЕРӨӨ ГОЛОО ХАЙРЛАЯ, ХАМГААЛЪЯ” уриатай голын эрэг дагуух хог цэвэрлэх аян, “Малчин залуусын уулзалт” арга хэмжээ, “Дулаахан өвөлжөөрэй” аян зэрэг 3 аян 3 арга хэмжээ зохион байгуулсан.	100%
179	13.8 Жендерт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах	Жендерт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр 3 сургалт зохион байгуулагдаж 133 иргэн, нөлөөллийн 1аянд 104 иргэн хамрагдсан.	100%

		Хүүхэд гэр бүлд чиглэсэн нөлөөллийн ажлын хүрээнд “Дэлхийн зөн” ОУБ-аас 25 сурагчид “Өсвөр нас”, ГБХЗХГазраас 125 сурагчид “Хүүхдэд амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх модуль сургалт”, эцэг эхчүүдэд ЗДТГазраас зохион байгуулсан “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга”, “хүүхэд хамгаалал” сэдэвт сургалтад 132, Дэлхийн зөн ОУБ-аас зохион байгуулсан “Би бол цор ганц харин харагдах байдал минь ондоо” эцэг эх асран хамгаалагчдын 2 дахь удаагийн сургалтад 2 эцэг эх 2 хүүхэд, “Дэлхий Зөн” ОУБ-аас “ААВ” сургалтад 30 аав, Нийтийн далд ухамсрыг сэргээх “Баярлалаа” төвөөс “Хүний хөгжил ба аз жаргал” сургалтад 113 эцэг эх, Сэлэнгэ аймгийн ГБХЗХГазраас “Гэр бүлийн харилцаа хандлага” сэдэвт сургалтад 69 эцэг эх нийт 8 сургалтад 630 эцэг эх, хүүхдүүдийг хамруулсан. Мөн нөлөөллийн 48 арга хэмжээ зохион байгуулж 7473 иргэнийг хамруулсан.	
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, НИЙГМИЙН ХАЛАМЖ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН САЛБАРЫН АЖИЛ АРГА ХЭМЖЭЭ:			
14.1 Хөдөлмөр эрхлэлт			
180	14.1.1 Зорилтот бүлгийн өрх, иргэнд дэмжлэг үзүүлэх зэргээр ажил хөдөлмөр эрхлэх, тогтмол орлого олох боломжийг бүх талаар дэмжин ажиллах	Ерөө сумын хэмжээнд 3 багийн 2046 өрх үүнээс 1, 2-р багт 1107 өрх амьдарч байна. 2023 оны 1-р сард Зорилтот өрх тодруулах судалгаа явуулж Тавин багаас 11, Буурагчин багаас 9 нийт 20 өрхийг сонгон тэдэнд чиглэсэн үйлчилгээг үзүүлэн ажиллалаа. 2023 оны хагас жилийн байдлаар сумынхаа өрх гэр бүл рүү чиглэсэн 13 төрлийн ажил арга хэмжээ зохион байгуулж 91,799,800 төгрөгийг зарцуулсан. Зорилтот 20 өрхийн 11 гишүүд тодорхой төрлийн ажил хөдөлмөр эрхэлдэг, 3 гишүүн ажил хөдөлмөр эрхлэх боломжгүй, 6 иргэн ажил идэвхтэй хайж байна.	100%
181	14.1.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн санхүүжилтийн дэмжлэгт иргэн, аж ахуй нэгжүүдийг хамруулж байнгын ажлын байр бий болгох	Иргэнд олгох санхүүгийн дэмжлэгт 2-р иргэн М.Отгонжаргалын Тансаг амт төсөл шалгарч хүүгүй, барьцаагүй, 3 жилийн хугацаатай 10 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч үйл ажиллагаагаа өргөтгөн тоног төхөөрөмжөө сайжруулж 2 ажлын байр бий болгосон байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас малчны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 1 өрх малжуулах хөтөлбөрт хамрагдаж барьцаагүй, хүүгүй, 36 сарын хугацаатай 5 сая төгрөгийн санхүүжилт авч тугалтай үнээ 2, 3 бяруу буюу нийт 7 толгой эм үхэр худалдан авсан байна. Мөн Мандал суманд малжуулах хөтөлбөрт хамрагдсан иргэдийг 2 өдрийн мал маллах арга ухааны тухай сургалтад хамрууллаа.	100%
182	14.1.3 Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдсан өрхийн хөдөлмөрийн насны ажил хөдөлмөр эрхлэх боломжтой иргэдийг ажилд зуучлан ажлын байраар хангаж, өрхийн үйлдвэрлэл эрхлэхэд нь дэмжлэг үзүүлж хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнээс түдгэлзүүлэх ажлыг зохион байгуулах	Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд 4 өрхийн 7 том хүн, 16 хүүхэд хамрагдаж байгаа бөгөөд нийтийг хамарсан болон мод тарих ажилд 3 иргэнийг түр ажлын байранд зуучлуулан 15 хоног ажилласан байна.	100%
183	14.1.4 Аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд сурталчлах “ХАБЭА-н сарын аян-2023” арга хэмжээг зохион байгуулах	“Эрүүл аюулгүй ажлын байр нь хөдөлмөрийн хүрээний суурь зарчим ба эрхийн асуудал мөн” сэдвийн хүрээнд “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аян-2023” арга хэмжээг 2023.04.04-ний өдрөөс 2023.05.05-ний өдрийг хүртэлх хугацаанд боллоо. Аяны хүрээнд үйлдвэрлэлийн осолд орж амиа алдсан 6 иргэний ар гэрийнхэнтэй уулзаж хүндэтгэл үзүүлж тус бүр 100000 төгрөг өгсөн. Хөрөө рамтай иргэн 12, 4 аж ахуй нэгж байгууллагуудад аюулгүй ажиллагааны зөвлөмжийг хүргүүлсэн. Хувираа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчдад хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн талаар 45 иргэнд гарын авлага тараасан. Аяны хүрээнд ЗДТГ-ын мэдээ хуудсаар дамжуулан 8 төрлийн мэдээ мэдээллийг иргэдэд хүргэсэн байна.	100%
184	14.1.5 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэн, тэдний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг аливаа сургалт нөлөөллийн ажил, хэлэлцүүлэгт хамруулж,	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон хүүхдэд нийт 37 иргэнд 60.839.000 төгрөг, асрагч 37 иргэнд 68.250.000 төгрөгийн тэтгэмж олгосон байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй	100%

	саналыг нь сонсох замаар тэдний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх	иргэний хөнгөлөлт тусламжийг 90 хүн 11 үйлчилгээнд 15.168.000 төгрөгийн санхүүжилт олгосон байна. “Хамтдаа хөгжье” хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн уулзалт өдөрлөгт 32 иргэн хамрагдаж Нийгмийн даатгалын байцаагч, халамжийн мэргэжилтэн, Эрүүл мэндийн төвийн эмч сувилагч нар мэдээлэл өгч сургалт зохион байгууллаа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд Мандал суманд зохион байгуулагдсан “Бид хамтдаа” 4 төрөлт спорт, урлагийн наадамд манай сумын ХБИ-ны холбооноос 11 иргэн амжилттай оролцсон. 11 сарын 24нд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд “Хамтдаа хөгжье” 4 төрөлт тэмцээн, караоке дуу, Витаминжуулалт, Аха цэнгээнт тоглоом зэрэг тэмцээнүүдийг зохион байгууллаа. Уг арга хэмжээнд 45 иргэн хамрагдаж 1560000 төгрөгийн төсөв зарцууллаа.	
14.2 Нийгмийн хамгаалал			
185	14.2.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний эрх ашгийг хамгаалах чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих	2023 оны жилийн эцсийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах ажлын хүрээнд 8 ажил арга хэмжээ зохион байгуулж 5.418.400 төгрөгийг зарцуулсан. 1. Сэлэнгэ аймаг Ерөө сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 4.6-д Сумын хэмжээний төл төсвийн байгууллагууд, үйлчилгээний газруудад ахмад настан, жирэмсэн, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дараалал харгалзахгүйгээр үйлчлэх “Үйлчилгээний соёл”-ыг хэвшүүлнэ гэж тус тус заасан зорилтын хүрээнд Ерөө суманд үйл ажиллагаа явуулдаг төр төсвийн 5, нийтийн зориулалттай үйлчилгээний 6 байгууллагуудын дарга эрхлэгч нарт сумын Засаг даргын албан бичгээр ахмад настан, жирэмсэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд дараалал харгалзахгүйгээр үйлчлэх, үйлчилгээний соёлыг хэвшүүлэн ажиллахыг үүрэг болголоо. 2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэнийг үнэмлэхжүүлэх ажлыг журмын дагуу зохион байгуулж 2023 оны жилийн эцсийн байдлаар 10 иргэнд шинээр, 15 иргэнд сунгалт хийж гардуулан өглөө. 3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбооны салбар зөвлөлтэй хамтран “ХАМТДАА ХӨГЖЬЕ” өдөрлөгийн арга хэмжээг зохион байгуулсан арга хэмжээнд 28 иргэнийг хамруулж “Эрүүл мэндийн тухай хууль”, сайн дурын даатгалын ач холбогдол, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх тусламж хөнгөлөлт, халдварт бус өвчнөөс сэргийлэх талаар мэдээллүүдийг хүргэж ажилласан. 4. Сэлэнгэ аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбооноос зохион байгуулсан “Зүрхэндээ нартай хүмүүс” урлагийн тоглолт зохион байгуулагдаж 131 иргэн хамрагдсан. 5. Дэлхийн зөн ОУБайгууллагаас зохион байгуулсан “Би бол цор ганц харин харагдах байдал минь ондоо” эцэг эх асран хамгаалагчдын 2 дахь удаагийн сургалтад 2 хүүхдийг асран хамгаалагч нарын хамт хамруулсан. 6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах зорилгоор Сэлэнгэ аймгийн Шаамар суманд зохион байгуулагдсан “Хамтдаа хөгжье” зуны уулзалтад 10 иргэн хамруулж 1.000.000 төгрөгийг зарцуулсан. 7. Сэлэнгэ аймгийн Мандал суманд зохион байгуулагдсан “Бид хамтдаа” урлаг, спортын нэгдсэн наадамд оролцсон 6 иргэний замын зардалд 268,800 төгрөгийг олгосон 8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд 4 төрөлт урлаг, спорт, танин мэдэхүйн тэмцээн зохион байгуулж 45 иргэн хамруулан 2,349,600 төгрөгийг зарцуулсан.	100%
186	14.2.2 Ахмад настны хөгжил, оролцоог хангах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	XVII жарны Үзэсгэлэн болгогч хэмээх Туулай жилийн сар шинийн баярыг тохиолдуулан сумын Тавин, Буурагчин, Бугант багийн нийт 546 ахмад настанд хүндэтгэл	100%

		<p>үзүүлэх арга хэмжээ зохион байгуулан аж ахуйн нэгж байгууллагуудын хандив 24.500.000 төгрөг, засаг даргын нөөц хөрөнгөөс 7.315.000 төгрөг нийт 31.815.000 төгрөгийг зарцуулан ажиллалаа.</p> <ul style="list-style-type: none"> - Аймгийн Засаг даргын хүндэтгэлийг 85-аас дээш 21 ахмад настанд - Ерөө сумын Засаг даргын хүндэтгэлийг 75-аас 84 хүртэлх насны 35 ахмад настанд - Ерөө суманд үйл ажиллагаа явуулж байгаа газар тариалан, уул уурхай, худалдаа үйлчилгээ, модны аж ахуйн нийт 55 компаниудын хүндэтгэлийг- 490 ахмад настанд үзүүлсэн. <p>2023 оны хагас жилийн байдлаар Монгол Улсын Төрийн дээд шагнал Алтан гадас одонгоор 1, Хүнс, хөдөө аж ахуйн “Тэргүүний ажилтан” цол тэмдгээр 2, Мал аж ахуйн хүндэт профессор-2 Монгол Улсын Хоршооллын салбарын 100 жилийн Хүндэт медалиар 1, Монголын Залуучуудын байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ойн медалиар 1, МҮЭ-ийн Холбооны “Хүндэт тэмдэг”-ээр 1, МҮЭ-ийн холбооны “Хөдөлмөрийн алдар” тэмдгээр 1 ахмад шагнагдсан. Мөн Аймаг сумын цолтой 50-аас дээш настай 13 бөхөд хүндэтгэл үзүүлсэн. Ахмад настай 14 иргэнд түлээний мод олгосон.</p>	
14.3 Нийгмийн даатгал			
187	14.3.1 Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг бүрдүүлэх	<p>Нийгмийн даатгалын санд 7.618.317.29 мянган төгрөгийн шимтгэлийн орлого хуримтлуулах төлөвлөгөөтэйгөөс 7.628.117.22 мян, төгрөгийн орлого хуримтлуулсан. Тайлант хугацаанд 46 ажил олгогч, албан журмын 1129 даатгуулагч, сайн дурын 162 даатгуулагчдаас шимтгэлийн орлогыг санд хуримтлуулав.</p>	100%
188	14.3.2 Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогыг бүрдүүлэх	<p>Тайлант хугацаанд албан журмын 1129 даатгуулагчаас 1.387.397.44 мян,төгрөг, сайн дурын даатгалд даатгуулагч 162 иргэнээс 7,332,5 мянган төгрөгийн шимтгэлийг хуримтлуулсан.</p>	100%
189	14.3.3 Шинээр шимтгэл төлөгч ажил олгогчдын тоог нэмэгдүүлэх	<p>Тайлант хугацаанд шинээр 3 аж ахуйн нэгжийг шинээр хамруулсан. Нийгмийн даатгалд төсвийн 7 байгууллага, хувийн 39 аж ахуй нэгжүүд хамрагдаж байна. Энэ онд шинээр “Буман Ерөө Хонь” ХХК, Гансложистик ХК, Цахиур сугай хайрхан ХК-г хамруулсан.</p>	100%
190	14.3.4 Шинээр албан журмын даатгалд даатгуулагчдын тоог нэмэгдүүлэх	<p>Тайлант хугацаанд албан журмын 1129 даатгуулагч хамрагдсанаас шинээр 62 даатгуулагч хамрагдсан.</p>	100%
191	14.3.5 Шинээр сайн дурын даатгалд даатгуулагчдын тоог нэмэгдүүлэх	<p>Жилийн эцсийн байдлаар сайн дурын даатгалд нийт 162 даатгуулагч хамрагдсанаас малчин 75, ХХЭ болон ажил хөдөлмөр эрхлээгүй 86,оюутан 1 даатгуулагч хамрагдсан байна. Шинээр 62 даатгуулагч хамрагдсанаас малчин 28 ,хувиараа хөдөлмөр эрхлэгч буюу ажил хөдөлмөр эрхлээгүй 34 даатгуулагч хамрагдсан байна.</p>	100%
192	14.3.6 Шинээр сайн дурын даатгалд хамруулах малчдын тоог нэмэгдүүлэх	<p>Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд нийт 162 даатгуулагч хамрагдсанаас малчин 75 даатгуулагч хамрагдсан байна. Хамрагдсан даатгуулагчдын 46,2 хувийг малчин даатгуулагч эзэлж байна. Энэ онд шинээр 62 даатгуулагч хамрагдсанаас 28 малчин сайн дурын даатгалд хамрагдсан.</p>	100%
193	14.3.7 Эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх	<p>2023 онд ЭМ-ийн даатгалд нийт 107 даатгуулагч шимтгэл төлж хамрагдсанаас малчин 37, ажил хөдөлмөр эрхлээгүй 23, оюутан 6 даатгуулагч хамрагдсан. EBarimt-г төлж байгаа иргэдийн тоо ороогүй. -Малчин 56% - Тодорхой ажил эрхлээгүй иргэд 52,2% - Оюутан 31.5%</p>	100%

194	14.3.8 Шимтгэлийн хуримтлагдсан өр авлагыг 20-оос доошгүй хувиар бууруулах	Нийгмийн даатгалын шимтгэлийн өмнөх оны авлага 332,145.25 мян, төгрөг байснаас 5 ажил олгогчийн 313,533.60 мянган төгрөгийн авлагыг барагдуулж ажилласан. Оны эхний авлагын 94,3 хувийг барагдуулсан.	100%
195	14.3.9 Тайлант хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүсгэхгүй байх	Тайлант хугацаанд шинээр төсвийн байгууллага болон аж ахуй нэгжийн шимтгэлийн хуримтлагдсан өр үүсгэхгүй өрийг ажил олгогчтой хувиар гарган барагдуулж ажиллаж байна.	100%
196	14.3.10 Нийгмийн даатгалын үйл ажиллагаа, хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах	Иргэд даатгуулагчдын нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн мэдлэгийг дээшлүүлэх,НД-ын багц хуулиудыг сурталчлах, хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор сумын 1,2-р багийн ажил хөдөлмөр эрхэлдэггүй иргэд, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд, малчид ногоочид, иргэд даатгуулагчдад цахим орчноор сурталчилгаа хийж, албан ерөөгөөр ирж үйлчлүүлсэн 1936 даатгуулагчдад мэдээлэл зөвлөгөө өгч ажиллалаа.	100%
ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН АЖИЛ АРГА ХЭМЖЭЭ			
197	15.1. Санхүү, төсвийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор гаргасан заавар журмыг үндэслэн өөрийн харьяа нутаг дэвсгэрт арга зүй, зохион байгуулалтын шуурхай удирдлагаар хангаж, үр дүнг аймгийн Засаг даргын өмнө хариуцна	Санхүү, төсвийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор гаргасан заавар журмыг үндэслэн төсвийн сар улирлын хуваарийн дагуу орон нутаг дахь төсвийг шуурхай удирдлагаар хангаж өр авлагыг бууруулан шаардлагатай нөөцүүдийг бүрдүүлэн ажиллаж байна.Орон нутгийн төсөвт байгууллагуудад өр авлага байхгүй байна.	100%
198	15.2. Аймгийн Засаг даргын баталсан сар, улирлын хуваарилалтыг үндэслэн сумын төсвийн байгууллагын сар, улирлын хуваарилалтыг батлан мөрдөж, санхүүжилт, төлбөр тооцоог хуваарийн дагуу сумын төрийн сангийн дансаар дамжуулан гүйцэтгэх	Сумын Засаг даргын захирамжаар баталсан сар улирлын хуваарийн дагуу ИТХуралд 213825,8 мян.төгрөг, ЗДТГазарт 2487135,3 мян.төгрөг, Бугант захирагчийн албанд 506392,7 мян.төгрөг, Ойн анги 70388,2 мян.төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн 8 байгууллагын тогтмол зардал 1048158,8 мянган төгрөгийн санхүүжилтийг Засгийн газрын удирдлагын мэдээллийн системд шивж орууллаа. Мөн аймагт төвлөрүүлэх орлогод 1489704,0 мянган төгрөг, ОНХСанд 132984,0 мянган төгрөгийг тус тус санхүүжүүлэн ажилласан байна.	100%
199	15.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийг хэмнэлттэй зарцуулж, хяналт тавьж ажиллах	Төрийн хэмнэлтийн хуулийн дагуу батлагдсан төсөвт багтаан өр авлага үүсгэхгүйгээр ажиллаж байна.Тайланд хугацаанд 2 удаа төсвийн зохицуулалт хийж өр авлагыг барагдуулж ажиллаж байна.	90%
200	15.4. Аудит болон хяналт шалгалтын байгууллагуудаас хийгдсэн шалгалтын зөрчил дутагдлуудыг арилгаж, цаашид давтан алдаа дутагдал гаргахгүй ажиллах	Төсвийн тухай хууль болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн танилцуулгыг бүх санхүүгийн ажилтнуудад нэг удаа зохион байгуулж 12 хүн оролцсон. Мөн аймгийн Засаг даргаас өгөгдсөн үүрэг, чиглэл өгөх албан тоотыг бүх байгууллагын дарга, нягтлан бодогч нарт хүргүүлэн ажиллалаа. Мөн аймгийн СТСХэлтэсээс сургалт, уулзалтыг зохион байгуулж манай сумаас 10 хүн оролцлоо.	100%
201	15.5. Аймаг, сумын төсвийн орлогын бүрдүүлэлтэд хяналт тавин улсын болон аймгийн төсвийн орлогыг хуваарийн дагуу бүрэн төвлөрүүлэх, Төрийн албан хаагчийн цалингийн нэмэгдэл болон орон нутгийн нэмэгдлийг бүрэн олгож ажиллах	Орон нутгийн төсвийн орлого 11-р сарын 27-ны байдлаар 5834551.8 мянган төгрөгийн орлого орохоос 6208102.4 мянган төгрөгийн татварын болон татварын бус орлого орж орлогын төлөвлөгөө 106.4 хувиар биелсэн байна.	100%
202	15.6. Төсвийн тухай хуулийн дагуу иргэд, олон нийтийн оролцоог хангасан, хөтөлбөрт суурилсан сумын 2024 оны төсвийн төслийг боловсруулж, хуулийн хугацаанд Санхүү, төрийн сангийн хэлтэст ирүүлэн хянуулах	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны төсвийн төслийг хуулийн хугацаанд бүх төсөвт байгууллагуудаас авч нэгтгэн хүргүүлээд байна.	100%
203	15.7. Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3 дахь заалтыг үндэслэн иргэдийн оролцоог хангаж, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг батлан,	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын 1,468,709.400 төгрөгийн 12 төсөл арга хэмжээнээс 12 ажил зарлагдаж, тендер шалгаруулалт хийгдэн 11 ажилд гэрээ байгуулан үүнээс 11 ажлыг Улсын комисс хүлээн авсан. Үлдсэн 1 ажилд оролцогч байхгүй тул дахин зарлагдсан, Хяналтыг сайжруулж, иргэдэд ил тод нээлттэй болгох ажлын	100%

	зориулалтын дагуу зарцуулж, сар бүр Орон нутгийн хөгжлийн сангийн программд төлөвлөлт, зарцуулалтын талаарх үнэн зөв мэдээг оруулан аймгийн Засаг даргад тайлагнах	хүрээнд ард иргэдэд шилэн данс, tender.gov.mn сайт, ЗДТГазрын мэдээ болон бусад сайтаар хүргэж байна.	
204	15.8. Төрийн сангийн цахим Портал системийн нэвтрүүлэлтийг шуурхай зохион байгуулж, системийн мэдээллийн аюулгүй байдал нууцлал, найдвартай, хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах, төрийн сангийн дотоод хяналт шалгалт, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын шалгалтыг зохион байгуулах	Засгийн газраас хэрэгжүүлж буй цахим шилжилтийн бодлого, зорилттой уялдуулан Төрийн сангийн газраас ПОРТАЛ СИСТЕМ төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Програмаар байгууллагуудын анхан шатны баримтын шалгалтыг хийж хэрэгжүүлж байна.Төрийн сангийн дотоод хяналтыг Бугант төрийн санд 1 удаа Ерөө сургууль- 1 удаа, Ерөө цэцэрлэгт 1 удаа хийж хэрэгжүүлсэн байна.	100%
205	15.9. Төсөв болон төсвийн гүйцэтгэлийн сар, улирлын мэдээ тайланг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цаглабарын дагуу гаргаж иргэд олон нийтэд мэдээлж, төсвийн ил тод байдал, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган, Шилэн дансны шинэчилсэн цахим сайтад төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн мэдээллийн үнэн зөв, бодит байдалд хяналт тавих	Төсөв болон төсвийн гүйцэтгэлийн сар, улирлын мэдээ тайланг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цаглабарын дагуу гаргаж иргэд олон нийтэд мэдээллэж, өглөг авлагын мэдээг Фрибаланс программд шивж оруулан орлогын мэдээг сар бүр Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлэн ажиллалаа.	100%
206	15.10. Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журмыг мөрдөн сумын Санхүүгийн албаны даргыг аймгийн Засаг даргатай, төсвийн байгууллагуудын нягтлан бодогчийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргатай тус тус зөвшилцөн томилж, чөлөөлөх болон Санхүүгийн албаны боловсон хүчний тогтвортой ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэн ажиллах	Санхүү албаны даргыг 2016.02.29 ны өдрийн 1/133 тоотойр Аймгийн засаг даргатай, Төсөвт байгууллагын нягтлан бодогч нарыг 2016.04.16 нд аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсийн даргатай зөвшилцөн томилсон.	100%
207	15.11 Нягтлан бодох бүртгэлийн хуулийн хүрээнд аж, ахуйн нэгж байгууллагуудын нягтлан бодох бүртгэл хөтлөлт, хэрэгжилтийн байдалд зөвлөгөө өгөх, Нягтлан бодох бүртгэлийн хууль, Аудитын тухай хууль болон холбогдох заавар журмыг сурталчлах, аж ахуйн нэгж байгууллагуудын санхүүгийн тайлан хуулийн хугацаанд нэгтгэгдэж байгаа байдалд холбогдох санхүүгийн тайлангийн нэгтгэлийн програмаар дамжуулан хяналт тавих	Монгол улсын Сангийн яамнаас аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайлангийн И-баланс цахим системийг нэвтрэлтийн нэгдсэн системд холбон хөгжүүлэх ажлыг “ Гааль, татвар, санхүүгийн мэдээлэл технологийн төв “ улсын үйлдвэрийн газартай хамтран 2023 оноос эхлэн хэрэгжүүлж байна. Энэ ажлын хүрээнд И-баланс цахим системд нэвтрээгүй сумын хэмжээний аж ахуйн нэгж байгууллагуудын удирдлага, нягтлан бодогч нартай хамтран ажиллаж байна.	50%
СТАТИСТИКИЙН САЛБАРЫН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ			
208	16.1. 2023 оны сумдаас нэгтгэж ирүүлэх албан ёсны статистикийн 51 төрлийн мэдээг, 285 удаагийн давтамжтайгаар үнэн зөв, бодитой, цаг хугацаанд нь гаргаж, аймгийн Статистикийн хэлтэст ирүүлэх	2023 оны байдлаар 51 төрлийн мэдээг 285 удаагийн давтамжтайгаар хүргүүлсэн байна.	100%
209	16.2.Албан ёсны статистик мэдээ, тайлан, тооллого, судалгааны баталгаажуулалт, үнэн бодит байдал чанар хүртээмжийг дээшлүүлэх	Статистикийн салбарын ажил арга хэмжээ 2023 онд 55 төрлийн мэдээг 285 удаагийн давтамжтайгаар хүргүүлсэн байна. Сумын статистик мэдээ, тайлан, тооллого, судалгааны баталгаажуулалт, үнэн бодит байдал чанар хүртээмжийг дээшлүүлэх ажлын хүрээнд	100%

		аймгийн статистикийн хэлтсийн мэргэжилтэн Ц.Хулан, Ч.Цэнд-аюуш нар хийж буй ажлын хяналтад үнэлгээ өглөө.	
210	16.3.Аймгийн Засаг даргын 2017 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн “Анхан шатны статистик мэдээ тайлангийн чанар, үр нөлөөг сайжруулах тухай” 05 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэх	Аймгийн Засаг даргын 2017 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн “Анхан шатны статистик мэдээ тайлангийн чанар, үр нөлөөг сайжруулах тухай” 05 тоот албан даалгаврын дагуу мэдээний архив үүсгэн Багийн засаг дарга нар Хүн ам, өрхийн мэдээллийн санг өдөр тутам баяжуулан ажиллаж байна.	100%
211	16.4.Хүн ам, өрхийн мэдээллийн онлайн сан дээр өрх, иргэний бүртгэл, мэдээлэл, хөдөлгөөн өөрчлөлтийг багийн Засаг дарга нараар цаг тухай бүрт нь хөтлүүлж, сангаас гарах тайлан мэдээг аймаг, сумын түвшинд ашиглуулах	Хүн ам, өрхийн мэдээллийн онлайн сан дээр өрх, иргэний бүртгэл, мэдээлэл, хөдөлгөөн өөрчлөлтийг багийн Засаг дарга нараар цаг тухай бүрд нь хөтлөн сангаас гарах тайлан мэдээг аймаг, сумын түвшинд ашиглан мэдээллийг самбарт байрлуулан мэдээлж, статистикийн үндэсний хорооны даргын 10-р сарын 06-ний өдрийн Статистик мэдээний хамралт, мэдээллийн чанарыг сайжруулах ажлыг эрчимжүүлэх тухай 03 дугаарт албан даалгаврын дагуу сар болгоны 5, 7, 8, 20, 21, 31-ний өдрүүдэд статистик мэдээний чанар, хүн ам өрхийн мэдээллийн сангийн баяжилтыг сайжруулах чиглэлээр хийсэн ажлын тайланг ирүүлэх тухай албан бичгийн дагуу тайланг хугацаанд нь аймгийн статистикийн мэргэжилтэн Б.Хуланд хүргүүлж ажиллалаа. Үүнд: - Хүн амын 142 алдаа - Өрхийн 18 алдаа, - Шинэ төрсөн 7 - Оршин суугаа бүртгэл-94 - Гэрлэлт зөрүүтэй-23 Ерөө сумын 1,2-р багийн нийт 142 алдааг засаж баяжилт хийлээ	100%
212	16.5.Өрхөд суурилсан “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”, “Ажиллах хүчний судалгаа”, болон бусад судалгааг явуулахад туслалцаа, дэмжлэг үзүүлж, удирдлага, зохион байгуулалтаар хангах /сонгогдсон багт хөтөч ажиллуулах/	Өрхөд суурилсан “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-9,11 сард Тавин багт, 6,10,11 сард Буурагчин 2 болон 3-р багт явагдсан. Цаг ашиглалтын судалгааг Бугант 3-р баг дээр явагдсан ба эдгээр судалгааг явуулахад туслалцаа, дэмжлэг үзүүлж, удирдлага, зохион байгуулалтаар хангах /сонгогдсон багт хөтөч ажиллуулан хамтарч ажиллалаа	100%
213	16.6.Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн ээлжит тооллого болон бусад тооллогыг орон нутагтаа чанартай, үр дүнтэй зохион байгуулж шаардлагатай санхүүжилт, хүн хүч, техник хэрэгслээр хангах туслалцаа үзүүлэх	Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн ээлжит тооллогийг сумын Засаг даргын 2023 оны 12 –р сарын 04-ний өдрийн А/300 тоот захирамжаар ажлын хэсэг байгуулагдан 1,2,3-р багийн хэмжээд 28 чиглэлд 99 албан хаагчид хамрагдан нийт 2112900 төгрөгийн шатахууныг зарцуулан ажилласан. Сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/300 дугаар захирамжаар 16 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсэг байгуулагдсан. Уг ажлын хэсэг нь 8 тоологч, 4 жолооч, 1 шалгагч 14 хоногийн хугацаанд 37 аж ахуйн нэгж, 651 өрхийн хамруулсан.	100%
214	16.7. Хуулийн дагуу 5 жил тутам зохион байгуулагддаг “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа”-г сумандаа зохион байгуулахад удирдлага, зохион байгуулалтаар хангах	Хуулийн дагуу 5 жил тутам зохион байгуулагддаг “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа Бугант 3-р баг дээр явагдсан ба эдгээр судалгааг явуулахад туслалцаа, дэмжлэг үзүүлж, удирдлага, зохион байгуулалтаар хангах /сонгогдсон багт хөтөч ажиллуулан хамтарч ажиллалаа	100%
ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН АЖИЛ АРГА ХЭМЖЭЭ:			
215	17.1 Үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй үйл ажиллагаанаас сэргийлэх, таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг судлан тогтоох, арилгах арга хэмжээ авч, энэ асуудлаар нутаг дэвсгэртэй байгаа үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй албадад чиглэл өгч, холбогдох байгууллагад санал хүсэлт тавьж ажиллах	<ul style="list-style-type: none"> Сумын хэмжээнд үйлдэгдэж буй хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор “БАЙГАЛИА ХАМГААЛТЯ”-2023 нэгдсэн арга хэмжээний Ерөө сумын төлөвлөгөөг 4 бүлэг 18 заалттайгаар Ерөө сумын Засаг даргаар батлуулж хэрэгжилтийг ханган ажиллалаа. 2023 оны 05 дугаар сарын 1-15-ны өдрүүдэд 2-р багийн нутаг дэвсгэр Харганат, Өлөнт, Могой, Цамхаг, Ялбаг гэх газруудад ашигт малтмал олборлох гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хяналт шалгалтын ажлыг зохион байгууллаа. Хяналт 	100%

		<p>шалгалтаар Харганын ам Аниш гэх газарт хууль бус ашигт малтмал олборлосон байх шинжтэй зөрчил илэрснийг экологийн цагдаагийн алба шалгаж байна.</p> <ul style="list-style-type: none"> • Мал амьтны гоц халдварт Шүлхий, Бог малын мялзан өвчний ийлдэс судлал, эмнэл зүйн тандалтыг түүврийн аргаар сонгогдсон Ерөө сумын 3-р багийн малчин В.Буянтогтохын 4 толгой үхэр, 6 толгой хонь, 6 толгой ямаа нийт-16 толгой малаас дээж авсан хариу сөрөг буюу эрүүл гарсан байна. Мал амьтны гоц халдварт шүлхий, бог малын мялзан, хонь ямааны цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг зөвлөмжийг 1,2,3-р багийн 187 малчин өрхөд мэдээлэл зөвлөмж өгч ажилласан мөн цахимаар 20 удаагийн давтамжтай мэдээлэл хүргэсэн. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтыг 532 өрхийн 19725 толгой үхэр, 668 толгой гахай нийт 20393 толгой мал амьтныг дархлаажуулалтад хамруулсан. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 162 өрхийн 48517 толгой хонь, 36832 толгой ямаа нийт 85349 толгой бог малыг хамруулсан. Мөн Шүлхийгийн намрын дархлаажуулалтад 664 өрхийн 28920 үхэр 38 өрхийн 880 толгой гахайг хамруулж дуусгаад байна. • Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 онд иргэнд өмчүүлэх газрын зориулалт, байршил, хэмжээг батлах тухай тогтоол болон Монгол улсын иргэнд 2023 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай Монгол улсын Засгийн газрын 2023 оны 03 сарын 22-ны өдрийн 105 дугаар тогтоол батлагдан гарснаас хойш дээрх тогтоол шийдвэрүүдийг үндэслэн сумын Засаг даргын 10 удаагийн захирамжаар нийт 89 иргэнд 17.86 га буюу 224.35 сая төгрөгийн газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар нэг удаа үнэгүй өмчлүүлж газрыг эдийн засгийн эргэлтэд оруулаад байна. • Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн хүрээнд 2023 оны эхний хагас жилийн байдлаар Ерөө суманд нийт 2825 иргэнд 631.66 га газар өмчлүүлсэн байгаа бөгөөд газар өмчлөлийн явц 39.75 хувьтай явагдаж байна. • Батлагдсан төлөвлөгөөний дагуу тайлант хугацаанд сумын Засаг даргын 20 удаагийн захирамж шийдвэрээр нийт 29.38 га газрыг эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Худалдаа үйлчилгээний зориулалтаар 0.3 га газрыг 4 иргэнд <input type="checkbox"/> Өвөлжөө, хаваржааны доорх газрын зориулалтаар 1.4 га газрыг 20 иргэнд <input type="checkbox"/> Үйлдвэрлэлийн барилга, байгууламжийн газрын зориулалтаар 2 га газрыг 1 аж ахуйн нэгж байгууллагад <input type="checkbox"/> Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цогцолбор газрын зориулалтаар 9 га газрыг 2 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад <input type="checkbox"/> Гэр бүлийн хэрэгцээний газрын зориулалтаар 7 иргэнд 0.5 га газрыг <input type="checkbox"/> Төмс, хүнсний ногооны газрын зориулалтаар 1 иргэнд 0.5 га газрыг <input type="checkbox"/> Боловсролын байгууллагын зориулалтаар 0.8 га газрыг 1 төрийн байгууллагад <input type="checkbox"/> Төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд 1 байгууллагад эрчим хүч дамжуулах станцын зориулалтаар 0.01 га, хүлэмж дарлагын газрын зориулалтаар 0.9 га, автомашины зогсоолын зориулалтаар 0.33 га, төрийн захиргааны барилга байгууламжийн зориулалтаар 0.29 га, мод үржүүлгийн газрын зориулалтаар 9 нэгж талбарын 13.35 га газрыг тус тус эзэмшүүлээд байна. • БТЕГол ХХК-ны уурхайн олборлолтын үйл ажиллагаанаас гарах шүүрлийн буюу завсрын усыг Баянголын ай савд нийлүүлж урсгах боломжийг бүрдүүлэн урсцын хэмжээг 	
--	--	--	--

		<p>тогтоох зорилгоор Баруун уулын шүүрлийн усанд хяналтын тоолуур суурилуулан ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> 2021, 2022 онд цахилгааны улмаас айл өрхийн байшин шатсан тохиолдлууд их гарсан тул Ерөө сумын Засаг даргын Тамгын газраас Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газарт уламжилсан хүсэлтийн дагуу "ГЭР ХОРООЛЛЫН АЙЛ ӨРХҮҮДИЙН ГАЛ ТҮЙМРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ" 2023 оны 04 дүгээр сарын 10 өдөр зохион байгуулагдлаа. Ерөө сумын 473 айл өрхөд галын аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг хийж, пийшин, зуух, яндангийн аюулгүй байдал, стандарт, норм, нормативыг мөрдүүлэх, галын аюулгүй ажиллагааны зааварчилгааг таниулан сурталчлах ажлыг зохион байгууллаа. Ерөө суманд зөвшөөрөлтэй 3 сүм, 1 дацан үйл ажиллагаа явуулж байна. Аймгийн ИТХурлын Тэргүүлэгчдийн 2022.07.08-ний өдрийн 75, 76, 77, 78 тугаартай тогтоолоор "Бугант Баптист", "Ерөө Баптист", "Ерөө нэгдсэн методист", "Зурхай засал гэгээрүүлэх дацан" тус тус 3 жилийн хугацаагаар үйл ажиллагаагаа сунгуулсан байна. 	
216	17.2 Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журмын 2 дугаар бүлэгт тусгагдсан "Яаралтай мэдээ", "Шуурхай мэдээ"-г тухай бүр, "Танилцуулах мэдээ"-г 7 хоног бүрийн Даваа, Пүрэв гарагийн 10:00-11:00 цагийн хооронд Цэргийн штабын 7036-2570, 94112802 дугаарын утсаар болон selenge_tssh@mod.gov.mn цахим хаягаар ирүүлж байх	<ul style="list-style-type: none"> Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журмын дагуу танилцуулах мэдээг бүтэн жилийн байдлаар гаргаж хүргүүлсэн. 	100%
217	17.3 Төрийн болон албаны нууцын хадгалалт хамгаалалтыг сайжруулах, задрах, үрэгдэхээс урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтыг сайжруулах	<ul style="list-style-type: none"> Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Засаг даргын Тамгын газарт хадгалагдаж буй нууцын зэрэглэлтэй баримт бичигт тооллого хийв. Тооллогыг сумын Засаг даргын 2023 оны А/292 дугаартай захирамжаар томилогдсон ажлын хэсэг 2023-11-15-ны өдөр хийсэн. Нууцын зэрэглэлээр ангилбал "нууц" зэрэглэлтэй 188 хуудас бүхий 5 баримт, "маш нууц" зэрэглэлтэй 75 хуудас бүхий 6 баримт бичиг хадгалагдаж байна. Нууцын ажилтан нууцын зэрэглэлтэй файльтай ажиллах болон албан хэрэгцээний 2 компьютерыг ашиглаж, нууц түлхүүрийг шаардлагын түвшинд үүсгэн хэрэглэж байна. Өрөөний хаалга болон нууцын сейф лац тэмдэгтэй, байнгын ажиллагаатай 5 чиглэлийн камер ажиллаж байна. Нууцын ажилтны өрөөний хаалгыг давхарлаж, төмөр хаалга суулгасан 	100%
218	17.4 Батлан хамгаалах багц хуулийг хэрэгжүүлэх, иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах	<ul style="list-style-type: none"> Батлан хамгаалах багц хуулийг хэрэгжүүлэх, иргэдэд сурталчлах ажлын хүрээнд аймгийн ЗДТГазар, Цэргийн штаб болон орон нутагт зохион байгуулсан цэргийн бүртгэл, ээлжит цэрэг татлага болон батлан хамгаалах, зэвсэгт хүчний аливаа арга хэмжээ, хуулийн сурталчилгааг орон нутгийн цахим хаяг, мэдээллийн самбар болон мэдээллийн цагаар иргэдэд хүргэж ажилласан. <p>(Сэлэнгэ аймаг ЗДТГ, Сэлэнгэ Цэргийн штаб, Ерөө сумын ЗДТГ-ын мэдээ, Сэлэнгэ аймаг Миний Монгол телевиз, Ерөө сумын ЕБС Өсвөрийн аврагч клуб)</p>	100%
219	17.5 Иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлан таниулах	<p>Зэвсэгт хүчний 102 жилийн ой, Монгол цэргийн өдөрт зориулсан "Эрчүүд" тэмцээнийг Ерөө сумын Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн тасаг, Соёлын төв хамтран 2023-03-17-ны өдөр зохион байгуулж, төр төсвийн байгууллага, багуудыг хамарсан 4 баг тамирчид оролцлоо. Тус арга хэмжээг цахимаар нийтэд сурталчлан ажилласан. /406000₮ зарцуулсан/</p>	100%

		<p>2023 оны нэг, хоёр дугаар ээлжийн цэрэг татлага зохион байгуулах ажлын хүрээнд хэсгийн дарга нарт Цэргийн албаны тухай хуулийн мэдээлэл өгч ажилласан.</p> <p>Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад цэрэг-эх оронч хүмүүжил олгох, эх орноороо бахархах үзлийг төлөвшүүлэх, бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэл, тэсвэр хатуужил олгож, эх орноо Батлан хамгаалах Монгол цэргийн залгамж халааг бэлтгэх зорилгоор цэрэг-спортын “ДӨЛ-2023” цогцолбор тэмцээний Ерөө бүсийн болон аймгийн аварга шалгаруулах тэмцээнүүдэд баг тамирчдаа амжилттай бэлтгэн оролцуулсан. Тус арга хэмжээний талаарх мэдээллийг Ерөө сумын цахим хуудас, ЕБСургуулийн “Өсвөрийн аврагч клуб”-ийн цахим хаягаар сурталчлан, сурагчдад тус тэмцээний ач холбогдол, амжилтыг түгээн танилцуулсан.</p> <p>2023 оны нэг дүгээр ээлжийн цэрэг татлагад тэнцсэн залууст эх орноо батлан хамгаалах хүсэл эрмэлзлийг төрүүлэх зорилгоор 2023 онд цэргийн албанаас халагдсан Б.Жавхлантөгсийг урьж цэргийн албанд шинээр татагдах залууст эх орноо батлан хамгаалах итгэл үнэмшил, бахархах сэдлийг төрүүлсэн ярилцлага хийлээ.</p>	
220	17.6 Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд цэрэгжилтийн спортын цогцолбор “Дөл-2023” тэмцээний эхний шатыг сумандаа зохион байгуулж шалгарсан сурагчдыг аймгийн аварга шалгаруулах тэмцээнд бэлтгэж оролцуулах	<ul style="list-style-type: none"> • Ерөө бүсийн аварга шалгаруулах тэмцээн 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр Хүдэр суманд зохион байгуулагдлаа. Тус тэмцээнд Ерөө сумын Т.Бямбаагийн нэрэмжит Ерөнхий боловсролын сургуулийн “ТЭМҮҮЛЭЛ”, Хүдэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн “АЛЬФА” тасгууд хурд, хүч, авхаалж самбааг сорин уралдаж “ТЭМҮҮЛЭЛ” баг шилдгээр шалгарч цэрэгжилтийн спортын цогцолбор “Дөл-2023” аймгийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцон “ТУСГАЙ БЭЛТГЭЛ”-ийн төрөлд шилдгээр шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнуулсан. • Цэрэгжилтийн спортын цогцолбор “Дөл-2023” бүс болон аймгийн аварга шалгаруулах тэмцээнд баг тамирчдын бэлтгэл хангах оролцоог нэмэгдүүлэх зорилгоор сумын Засаг даргын нөөц хөрөнгө болон ЗДТГ азраас нийт 2,094,600 төгрөг зарцуулсан 	100%
221	17.7 Төрийн захиргааны болон төрийн улс төрийн албан хаагчдын цэргийн бэлтгэл сургалтыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабтай хамтран зохион байгуулах	Хугацаа болоогүй	0%
222	17.8 Цэргийн бүртгэлийг зохион байгуулах, хөтлөх, хугацаат цэргийн албаны ээлжит татлага зохион байгуулах, гэрээт цэрэг элсүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэн, цэрэг татлагын байранд хүргэх болон холбогдох бусад зардлыг тухайн сумын Засаг дарга хариуцах	<ul style="list-style-type: none"> • Сэлэнгэ аймгийн ЗДТГ-аар Цэргийн штабын даргын 2022 оны 161 дугаартай албан бичгийн хүрээнд Цэргийн бүртгэлийн сургалт 2023-01-02-ны өдөр 10:30 цагт цахимаар зохион байгуулагдаж, Тамгын газрын дарга, багийн Засаг дарга нар, төрийн захиргаа, хууль эрхзүйн мэргэжилтний хамт оролцож 2023 оны цэргийн бүртгэл зохион байгуулах чиглэл, зөвлөгөөг авсан. • Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын даргын 2023 оны 01 дугаартай албан бичгээр Цэргийн бүртгэл зохион байгуулах тухай аймгийн Засаг даргын 2023 оны А/65 дугаартай захирамж, цэргийн бүртгэлийн маягтыг хүлээн авч сумын Засаг даргын 2023 оны 02 дугаартай захирамжаар Цэргийн бүртгэлийг 2023 оны 01 сарын 04-20 ний өдрүүдэд сумандаа зохион байгуулж 2023-01-31-ний өдөр Ерөө сумын цэргийн бүртгэлийг 17 маягтаар гаргаж Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабт хүлээлгэн өгсөн. 2023 оны цэргийн бүртгэл 98 хувьтай бүртгэгдсэн. • Цэргийн бүртгэлийн мэдээ, судалгааг архивын баримт бүрдүүлэлтийн журмын дагуу үдэж нууц баримт бичгийн хамт хадгалагдаж байна. Иргэдэд сумын ЗДТГ-аар мэдээ групп, Ерөө сумын Зарын цэг болон бусад мэдээллийн суваг, мэдээллийн самбараар цэргийн бүртгэлд хамрагдах тухай мэдээллийг түгээн ажилласан. 	100%

		<ul style="list-style-type: none"> • Ерөө сумын Засаг даргын 2023 оны А/108, А/218 дугаартай “Цэргийн жинхэнэ албаны ээлжит татлага зохион байгуулах тухай” захирамжуудаар цэргийн насны нийт 637 иргэнд зарлан дуудах мэдэгдэл хүлээлгэн өгснөөс эрүүл мэндийн үзлэгт 70 залуу хамрагдаж 20 тэнцсэн. Цэргийн албаны тухай хуулийн хүрээнд ээлжит цэрэг татлагаар эрүүл мэндээр тэнцээгүй 50, бусад шалтгаанаар 8 түр чөлөөлөгдөж, 12 залуу цэргийн албанд татагдан мордлоо. • 2022 оны 1 болон 2-р ээлжийн цэрэг татлагаар татагдсан 21 цэргийг Сэлэнгэ аймгийн Ерөө болон Сүхбаатар өртөөнөөс гэр бүлийн хамт тосон авах ажлыг зохион байгуулсан. • 2023 оны 1, болон 2-р ээлжийн цэрэг татлагын ажилд сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс 3,451,300 төгрөг зарцуулсан байна. <table border="1" data-bbox="806 529 1808 1122"> <thead> <tr> <th colspan="2">2023 оны 1-р ээлж</th> <th>Тараасан зарлан дуудах хуудас</th> <th>Үзлэгт хамрагдсан</th> <th>тэнцсэн</th> <th>Хасагдсан</th> <th>Цэрэгт явсан</th> </tr> </thead> <tbody> <tr> <td rowspan="3">4/25/2023</td> <td>1-р баг</td> <td>63</td> <td>14</td> <td>4</td> <td>1</td> <td>3</td> </tr> <tr> <td>2-р баг</td> <td>86</td> <td>10</td> <td>3</td> <td></td> <td>3</td> </tr> <tr> <td>3-р баг</td> <td>177</td> <td>16</td> <td>5</td> <td>3</td> <td>2</td> </tr> <tr> <td colspan="2"></td> <td>326</td> <td>40</td> <td>12</td> <td>4</td> <td>8</td> </tr> <tr> <th colspan="2">2023 оны 2-р ээлж</th> <th>Тараасан зарлан дуудах хуудас</th> <th>Үзлэгт хамрагдсан</th> <th>тэнцсэн</th> <th>Хасагдсан</th> <th>Цэрэгт явсан</th> </tr> <tr> <td rowspan="3">10/16/2023</td> <td>1-р баг</td> <td>73</td> <td>10</td> <td>2</td> <td>1</td> <td>1</td> </tr> <tr> <td>2-р баг</td> <td>90</td> <td>9</td> <td>4</td> <td>2</td> <td>2</td> </tr> <tr> <td>3-р баг</td> <td>148</td> <td>11</td> <td>2</td> <td>1</td> <td>1</td> </tr> <tr> <td colspan="2"></td> <td>311</td> <td>30</td> <td>8</td> <td>4</td> <td>4</td> </tr> <tr> <td colspan="2">Нийт дүн</td> <td>637</td> <td>70</td> <td>20</td> <td>8</td> <td>12</td> </tr> </tbody> </table>	2023 оны 1-р ээлж		Тараасан зарлан дуудах хуудас	Үзлэгт хамрагдсан	тэнцсэн	Хасагдсан	Цэрэгт явсан	4/25/2023	1-р баг	63	14	4	1	3	2-р баг	86	10	3		3	3-р баг	177	16	5	3	2			326	40	12	4	8	2023 оны 2-р ээлж		Тараасан зарлан дуудах хуудас	Үзлэгт хамрагдсан	тэнцсэн	Хасагдсан	Цэрэгт явсан	10/16/2023	1-р баг	73	10	2	1	1	2-р баг	90	9	4	2	2	3-р баг	148	11	2	1	1			311	30	8	4	4	Нийт дүн		637	70	20	8	12	
2023 оны 1-р ээлж		Тараасан зарлан дуудах хуудас	Үзлэгт хамрагдсан	тэнцсэн	Хасагдсан	Цэрэгт явсан																																																																						
4/25/2023	1-р баг	63	14	4	1	3																																																																						
	2-р баг	86	10	3		3																																																																						
	3-р баг	177	16	5	3	2																																																																						
		326	40	12	4	8																																																																						
2023 оны 2-р ээлж		Тараасан зарлан дуудах хуудас	Үзлэгт хамрагдсан	тэнцсэн	Хасагдсан	Цэрэгт явсан																																																																						
10/16/2023	1-р баг	73	10	2	1	1																																																																						
	2-р баг	90	9	4	2	2																																																																						
	3-р баг	148	11	2	1	1																																																																						
		311	30	8	4	4																																																																						
Нийт дүн		637	70	20	8	12																																																																						
223	17.9 Сумын “Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах төлөвлөгөө”-нд тодотгол хийх, сумын Батлан хамгаалах товчоо, тосгоны дайчилгаа удирдах хэсгийн шинэчлэн батлагдсан орон тооны дагуу үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүнийг бүрэн томилгоожуулж тэдэнтэй зохион байгуулах сургалтыг Цэргийн штабтай хамтран явуулах, түүнд шаардлагатай зардлыг бүрэн хариуцах	<ul style="list-style-type: none"> • Сумын “Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах төлөвлөгөө”-нд тодотгол хийж судалгааг хүргүүлсэн. • Цэргийн нэг дүгээр зэргийн бэлтгэл үүрэгтний тооцооны хуудсыг нэг бүрчлэн бүртгэл хөтлөн 1953-1972 оны 202 , 1973-2003 оны 364 нийт 566 бэлтгэл үүрэгтний тооцооны хуудсыг цэргийн штабт хүлээлгэн өгсөн. 	100%																																																																									
224	17.10 Дайчилгаанд шаардлагатай бараа материал, хэрэгсэл, автомашин болон бусад эд зүйлсээр хангах үүрэг хүлээсэн томилгоот иргэн аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээг тодотгох, шаардлагатай	<ul style="list-style-type: none"> • Дайчилгаанд шаардлагатай бараа материал, хэрэгсэл, автомашин болон бусад эд зүйлсээр хангах үүрэг хүлээсэн хүнсний 3 дэлгүүр, шатахуун түгээх 1 станц, 1 эмийн сантай гэрээ байгуулсан. 	100%																																																																									

	тохиолдолд нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээ цуцлах арга хэмжээг авч ажиллах		
225	17.11 Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийг сонгон авах, тэдний албаны үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах	<ul style="list-style-type: none"> Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж буй иргэн байхгүй. 2024 онд биеэр дүйцүүлэн хаах 5 иргэний саналыг цэргийн штабт хүргүүлсэн. 	90%
226	17.12 Цэргийн бэлтгэл үүрэгтнүүдийг хульд заасан хугацаагаар сургалтад хамруулах, тэднийг дайчилгааны командуудад оногдуулан бүртгэх	<ul style="list-style-type: none"> 2023 оны цэргийн бүртгэлээр Цэргийн бэлтгэл үүрэгтэн 3 иргэнийг дайчилгааны командуудад оногдуулан бүртгэж тодотгол хийсэн. 	100%
227	17.13 Цэргийн албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэдэд мөнгөн төлбөр ногдуулж, төлөлтөд хяналт тавьж ажиллах	<ul style="list-style-type: none"> Цэргийн албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах 1997 онд төрсөн 2 дугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн 44 залууд эрх бүхий албан тушаалтны мэдэгдэх хуудсыг хүлээлгэн өгч мөнгөн төлбөр төлөлтөд хяналт тавьж ажилласан. Өнөөдрийн байдлаар 6 иргэн 8,3 сая төгрөгийн мөнгөн төлбөр төлж, 9 иргэн Цэргийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.5 хэсгийн 1-р заалт үндэслэн чөлөөлөгдсөн. Хаягтаа амьдардаггүй 7 иргэн байна. 	100%
228	17.14 Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийг эрүүлжүүлэхэд сумын эрүүл мэндийн төвтэй хамтран ажиллах, тэдэнд дэмжлэг үзүүлэх	<ul style="list-style-type: none"> Сэлэнгэ аймаг Ерөө сумын Ерөө ЭМТөв, Бугант тосгоны ЭМТөв цэргийн насны залуучуудыг эрүүлжүүлэх төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Ерөө суманд цэргийн насны 386 залуу бүртгэлтэй. Зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчлөлийн эрт илрүүлгийн 2 удаагийн үзлэг, амбулаторийн үзлэг оношилгооны үр дүнд дараах дүгнэлтийг хийв. Оношоор ангилж эрэмбэлэхэд <ol style="list-style-type: none"> Зүрх судасны эмгэгтэй -3 Жингийн илүүдэлтэй – 2 Нүдний хараа сул -3 Унаж татдаг -2 Хөлийн хуруу тайрагдсан -1 Арьс харшлын эмгэгтэй -2 Уушгины архаг эмгэгтэй -4 Сонсгол сул, хэнгэрэг цоорхой -4 Тэмбүүгүйн халдвартай -1 Бөөрний архаг үрэвсэлтэй – 2 Сэтгэцийн эмгэгтэй – 1 залуу тус тус багийн эмчийн хяналтад бүртгэгдсэн <p>Эдгээр залуусыг үе шаттайгаар сумын ЭМТөвүүд эрүүлжүүлэх төлөвлөгөөний дагуу хяналт тавьж, зөвлөгөө өгч байна. Мөн нүдний хараа сул -1, хөлийн хуруу тайрагдсан -1, сонсгол сул -2 иргэн нарийн мэргэжлийн эмчийн хяналтад байж Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоолгосон.</p> <p>2023 оны хугацаат цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан цэргийн насны залуучууд 14 төрлийн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг, 3 төрлийн оношилгоо, 6 төрлийн шинжилгээнд тус тус хамрагдсан. Нийт 50 иргэн эрүүл мэндийн шалтгаанаар чөлөөлөгдсөн бөгөөд эдгээр 50 иргэний мэдээллийг бүртгэн эрүүлжүүлэх төлөвлөгөө гарган нарийн мэргэжлийн эмчид үзүүлж хянаж эмчлэхээр төлөвлөөд байна. Үүнд : Уушгины эмгэгтэй -5, Зүрх судасны эмгэгтэй -2, ЧХХ болон сонсголын өөрчлөлттэй -6, Бөөр шээсний эмгэгтэй -7, Сэтгэцийн эмгэгтэй -4, Таргалалттай -6, Жин бага -3, Арьс харшлын эмгэгтэй -4, Бусад өвчний учир -13 зэрэг өвчний учир эрүүл мэндийн байдлаар тэнцэхгүй гэж бүртгэгдсэн байна.</p>	100%

		Цаашид эдгээр цэргийн насны иргэдийг нарийн мэргэжлийн эмчид үзүүлж , онош тодруулан эмчлэхээр төлөвлөн томуу, томуу төст өвчин, АД ихэссэн, арьс харшлын эмгэгтэй 16 иргэнийг багийн эмч хяналтад авч томуу болон харшлын эмгэгтэй 4 иргэнийг амбулаториор эмчлэн эрүүлжүүлсэн байна	
229	17.15 Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүний сургалтыг үе шаттай зохион байгуулах	Хугацаа болоогүй.	0%
230	17.16 Цэргийн бүртгэлд байгаа эрчүүдийн шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж, бүртгэл хөтлөх	<ul style="list-style-type: none"> • 2023 оны цэргийн бүртгэлээр гадаад-2, хаяг тодорхойгүй-5, оршин суугаа хаягтаа амьдардаггүй-7 бүртгэгдсэн. Оршин суугаа хаягтаа амьдардаггүй болон хаяг тодорхойгүй иргэдэд хяналт тавин ажиллаж байна. 	100%
231	17.17 Хугацаат цэргийн алба хааж буй дайчдын ар гэрт дэмжлэг үзүүлэх, тэднийг халагдан ирэхэд нь хүлээн авах, суралцах болон хөдөлмөр эрхлэлт, зайлшгүй тохиолдолд амьжиргааны эх үүсвэрт орон нутгаас дэмжлэг туслалцаа үзүүлэх	<ul style="list-style-type: none"> • 2022 оны цэрэг татлагад хамрагдан цэргийн алба хаасан 17 залуугийн баримт бичгийг цэргийн штабаас бүрэн хүлээлгэн өглөө. Эдгээр иргэдээс 3 иргэнийг БТЕГол ХХК-д байнгын ажлын байранд зуучилж ажлын байртай болгосон.. 	100%